



НЭЭЛТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын  
Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

2009 оны гуравдугаар улирлын тайлан

Улаанбаатар, 2009



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Дэлхийн санхүү эдийн засгийн  
Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

МУИС-ИЙН ЭДИЙН ЗАСГИЙН СУРГУУЛИЙН  
ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫН ТЭНХИМИЙН СУДЛААЧДЫН БАГ

**Ч. Нарантуяа**

Судалгааны багийн ахлах судлаач, МУИС, ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн эрхлэгч,  
АНУ-ын Мэрилендийн их сургуулийн докторант

**С. Даваасүрэн**

Судлаач, АНУ-ын Өмнөд Нью-Хемпширийн их сургуулийн докторант

**Б. Отгонтөгс**

Судлаач, АНУ-ын Колумбийн их сургуулийн докторант

**Б. Түвшинтөгс**

Судлаач, Эдийн засгийн ухааны доктор, АНУ-ын Бостоны их сургууль, Эдийн засгийн судалгаа,  
эрдэм шинжилгээний хүрээлэн

**Т.Энхбаяр**

Судлаач, АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийн докторант

Зөвлөж, хянан тохиолдуулсан **Б.Мөнхсоёл**

Нээлттэй Нийгэм Форумын менежер

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү номын зохиогчийн эрхийг ННФ эзэмших ба номыг хэсэгчлэн  
болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл доорхи хаягаар хандаж зохих  
зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,

Утас: 976-11-318207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)



# ГАРЧИГ

1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	4
2. ОРШИЛ .....	9
3. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ.....	12
4. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....	17
4.1. Дотоодын үйлдвэрлэл .....	17
4.2. Гадаад худалдаа.....	21
4.3. Макро эдийн засгийн бодлого.....	24
5. БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД.....	36
5.1. Боловсролын салбар.....	37
5.2. Эрүүл мэндийн салбар.....	45
6. ЭДИЙН ЗАСГИЙН ХЯМРАЛЫН ӨРХӨД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ .....	49
6.1. Өрхийн орлого .....	49
6.2. Өрхийн зарлага .....	53
7. ДҮГНЭЛТ.....	59
8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	61
9. ХАВСРАЛТ.....	62

# 1. Тайлангийн хураангуй

Энэхүү улирлын тайланд дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг үргэлжлүүлэн судаллаа. Ингэхдээ дотоод болон гадаад эдийн засгийн нөхцөл байдалд 2009 оны гуравдугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ямар өөрчлөлт орсон, энэ хугацаанд макро эдийн засгийн бодлогын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, цаашилбал манай улсын нийгмийн чухал салбар болох боловсрол ба эрүүл мэндийн салбарт ямар асуудал тулгамдаж байгаа, хямралын улмаас эдгээр салбарт үзүүлж буй нөлөө, Улаанбаатар хотын өрхийн орлого ба зарлага, түүнчлэн хэрэглээнд хямралын үр нөлөөгөөр гарсан өөрчлөлт зэрэг өргөн хүрээтэй асуудлаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, холбогдох бодлогын зөвлөмжийг боловсруулсан юм.

Судалгааны үр дүнд дараах үндсэн дүгнэлтүүдийг хийлээ. Үүнд:

- ▶ Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал доод цэгтээ хүрч улмаар тогтворжих зарим шинж тэмдэг ажиглагдаж эхэлсэн талаар хөгжингүй зарим орнууд мэдэгдээд байна. Уг мэдэгдэл санхүү, эдийн засгийн хямрал саарсныг илтгэж байгаагаас бус эдийн засаг илааршиж, эдийн засгийн өсөлт бий болох талаар ярихад хараахан эрт байгааг анхааруулав.
- ▶ Хямралд нэрвэгдсэн дийлэнх улсуудад төсвийн алдагдал өндөр байгаа хэдий ч, төсвийн зарлагын өсөлтөөр эдийн засгийн уналт зогсож, тогтворжиж эхэлж байхад төсвөөс үзүүлэх эдийн засгийн дэмжлэгийг огцом зогсоох, буцаан татах нь нөхцөл байдлыг улам муутгаж болзошгүй гэсэн болгоомжлол өндөр байна.
- ▶ Дэлхийн улсуудын бодлогын тулгамдсан асуудал нь, нэг талаас төрийн оролцоог хугацаанаас нь эрт болиулбал санхүүгийн тогтвортой байдал, сэргэлт бий болох тал дээр олсон ахиц дэвшилд сөрөг нөлөө үзүүлэх, нөгөө талаас эдгээр арга хэмжээг удаан хугацааны туршид авч хэрэгжүүлснээс инфляцийг дунд хугацаандаа хөөрөгдөх, төсвийн алдагдал нэмэгдэх эрсдлийг тооцоход оршиж байна. Энэ нь өнөөгийн бодлогын томоохон сонголт болоод байна.

- ◀ 2009 оны эхний есөн сарын тоон мэдээнээс манай улсын бодит үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт уналт үргэлжилсээр. Энэ улирлын байдлаар ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан нь хоёрдугаар улирлын 1.6 хувийн уналтаас илүү их байна. Үүнд аж үйлдвэрийн салбар 10.5 хувиар, барилгын салбар 37.7 хувиар буурсан, харин хөдөө аж ахуйн салбар өсөлттэй байгаа нь нөлөө үзүүлжээ.
- ◀ Манай улсын дотоодын үйлдвэрлэлийн уналт үргэлжилсээр байгаа нь хямралын эсрэг мөнгө болон төсөв, сангийн тэлэх бодлого хэрэгжүүлэх орон зай байгаагүйгээс арга хэмжээ авч чадаагүйн зэрэгцээ манай эдийн засаг гадаад эдийн засгаас шууд хүчтэй хамаардаг, үйлдвэрлэл үйлчилгээний салбарын бүтэц өрөөсгөл, эдийн засаг эмзэг байгаатай холбоотой байна.
- ◀ Өнөө үед хамгийн хүндрэлтэй байгаа салбар бол банк, санхүүгийн салбар юм. Учир нь өнөөдрийн байдлаар банкуудын нийт олгосон зээлийн 22.6 хувь нь чанаргүй болоод хугацаа хэтэрсэн зээлээс бүрдэж байна. Мөнгөний бодлогын гол зорилго болох инфляцийн түвшин 2009 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар оны эхнээс 2.6 хувь, сүүлийн 12 сарын байдлаар -1.9 хувьтай гарсан нь мөнгөний бодлого үндсэн зорилгоо биелүүлж байгаа дүр зураг харагдаж байна. Суурь инфляцийн түвшин оны эхнээс 4.1 хувь байгаа нь инфляци тогтворжих шинж тэмдэг ажиглагдаж эхэлснийг илтгэж байна.
- ◀ Сүүлийн 12 сарын туршид Монголбанк бодлогын томоохон сонголттой тулж, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлсэн нь инфляцийг бууруулах бодлого байсан бөгөөд энэ нь үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлсөн. Харин 2009 оны 5 дугаар сараас хойш инфляцийн түвшин нэг оронтой тоонд орж ирсэн учраас мөнгөний хатуу бодлогоо сулруулах эхний алхамыг хийж эхэлсэн. Хамгийн сүүлд, 9 дүгээр сард Монголбанк бодлогын хүүгээ 1.5 пунктээр огцом бууруулж өнөөгийн байдлаар 10 хувьд хүргээд байна.
- ◀ Сүүлийн саруудад мөнгөний бодлого гол зорилгоо биелүүлж эхэлж байгаа хэдий ч энэхүү ололтоо бататгаж мөнгөний бодлогоо цагаас нь өмнө огцом зөөлрүүлэхгүй байх, дунд хугацаандаа инфляцийг бага түвшинд, тогтвортой байлгахад чиглүүлэх нь зүйтэй юм. Монголбанк бодлогын хүүгээ инфляцийн түвшин, түүний талаарх хүлээлтийг харж байж бууруулах, аливаа нэг ашиг сонирхлоос хараат бус байдлаа хадгалж байх нь хамгийн чухал.
- ◀ Инфляцийн түвшин буурсны нэг томоохон ач холбогдол нь бодит хүү өсч 9 дүгээр сарын байдлаар бодит зээлийн хүү 24 хувьтай, бодит хадгаламжийн хүү 15 хувьтай байгаа явдал юм. Инфляцийг бага байлгаснаар зээлийн хүүг зах зээлийн тогтолцоонд суурилуулан бууруулах гол арга, хөшүүрэг болно.
- ◀ Монголбанкны өмнө тулгарсан өөр нэг сонголт нь валютын ханшны талаар баримтлах бодлого юм. Өнөөг хүртэл явж ирсэн түгээмэл төөрөгдөл бол манай улс валютын ханшны чухам ямар тогтолцоог сонгож байгаа нь тодорхойгүй байгаад оршиж байна. Монголбанк иргэд байгууллагаас гадаад валют худалдан авч валютынхаа нөөцийг зузаатгаж, оронд нь төгрөгийн нийлүүлэлтийг өсгөх үйл явц



ажиглагдаж байна. Тэгэхээр, бодлогын хүүгээ бууруулж, валютын арилжаагаараа дамжуулан төгрөгийн нийлүүлэлтийг ийнхүү өсгөж байгаа нь мөнгөний зөөлөн бодлого аль хэдийнэ эхэлжээ гэж харагдахаар байна.

- ◀ Сүүлийн үед банк санхүүгийн салбарт хэд хэдэн тулгамдсан асуудлууд үүсээд байна. Монголбанкны мэдээлж байгаагаар Анод банкинд гадаад тооцооны будлианаас 58.6 тэрбум төгрөгийн зөрүү бичилт илрээд байна. Түүнчлэн, 40 том зээлдэгчиддээ олгосон 125.5 тэрбум төгрөгийн зээлийн 123 тэрбум төгрөг нь чанаргүй зээл болжээ. Анод банкны хадгаламж эзэмшигчдийн мөнгийг төр хариуцаж, Монголбанкнаас 129 тэрбум төгрөгийн зээл олгоод байгаа. Төр хариуцна гэдгийн ард татвар төлөгчдийн мөнгө байгаа гэдгийг хатуу ойлгох хэрэгтэй юм.
- ◀ Манай улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлснээс хойш олон банк дампуурсан, хаагдсан бөгөөд энэхүү тохиолдол бүрд төрөөс алдагдлыг нь дааж байсан. Хамгийн сүүлд олон тооны хадгаламж зээлийн хоршоод дампуурахад хүртэл төрөөс хэсэгчлэн алдагдлыг нь даасан. Энэ бүх бодлогын шийдлүүд ёс суртахууны эрсдлийг улам дэвэргэж байгаа. Энэ асуудлыг зохицуулахын тулд хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгож, түүнтэйгээ банкны хяналт шалгалтын тогтолцоог уялдуулах арга зам байж болно.
- ◀ Банк санхүүгийн салбарт гарсан нэг шинэ санаачлага бол Хөгжлийн банк байгуулах асуудал. Хөгжлийн банкинд ямар нэг онцлог давуу тал байхгүй бол одоо байгаа арилжааны банкуудад хөрөнгө оруулах замаар томоохон төслүүдийг санхүүжүүлэх бүрэн боломжтой. Төрөөс тус банкны удирдлагыг томилох тохиолдолд дээр дурьдсан ёс суртахууны эрсдлийг дагуулах болно. Хөгжлийн банк байгуулах нэг дорвитой давуу тал нь банкны секторт өрсөлдөөнийг улам эрчимжүүлэхэд оршино.
- ◀ Банк, санхүүгийн салбарт гарсан өөр нэг үйл явц бол Монгол шуудан банк, Хадгаламж банк нэгдсэн явдал юм. Энэхүү нийлэх үзэгдэл түгээмэл болсон тохиолдолд өнөөгийн барууны орнуудад ажиглагдаад байгаа хэтэрхий том банкуудыг үүсгэх нөхцлийг бүрдүүлж магадгүй юм. Банкуудын системдээ эзлэх хувь хэмжээ ихсэх тусам тухайн банкинд бий болох хүндрэл нь нийт салбараа эрсдэлд оруулдаг гэдгийг өнөөгийн хямрал тод харуулсан.
- ◀ Засгийн газрын орлого 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 1.3 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурсан. Харин Засгийн газрын зарлага 1.6 их наяд төгрөг буюу өмнөх жилийн мөн үеийн түвшинд байна. Төсвийн алдагдал 332.5 тэрбум төгрөгтэй тэнцүү байгаа ба оны эцэс гэхэд зорилтот түвшин болох ДНБ-ий 5.8 хувь буюу 364 тэрбум төгрөгт барьж чадах эсэх нь тодорхойгүй байна.
- ◀ Манай орны хувьд Засгийн газрын төсвийн орлого цөөн тооны эрдэс баялгийн экспортоос хэт хараат байгаа нь эдийн засгийн хямралын үед төсвийн тэлэлтийг бий болгох боломжийг хязгаарласан. Тийм учраас Засгийн газрын төсвийг эдийн засгийн мөчлөгөөс хамааралгүй болгох шаардлагатай байна.

- ◀ Ашигт малтмалаас орж ирж байгаа орлого нь үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай тул ашигт малтмалын үнэ өсөх үед хуримтлал бүрдүүлж, үнэ буурсан үед тэрхүү хуримтлуулсан нөөцөөсөө төсвийн алдагдлаа нөхөх замаар гадаад худалдааны тогтворгүй байдлаас эдийн засгаа сэргийлэхэд оршиж байна. Түүнчлэн, Засгийн газрын зарлагын өсөлтөд хязгаар тавих нь энэхүү арга хэмжээний салшгүй нэг хэсэг нь юм. Үүнтэй холбоотой бусад орны туршлага элбэг байгааг анхаарууштай.
- ◀ Боловсролын салбарын хувьд манай улс орлогын түвшнээрээ ижил төстэй бусад орнуудтай харьцуулахад илүү их хэмжээний мөнгийг зарцуулдаг хэдий ч хамран сургалт зэрэг үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тэдгээр орнуудтай дүйцэхүйц хэмжээнд л байна. Энэ нь боловсролын салбарын зарлага эерэг дам нөлөө харьцангуй багатай хөтөлбөрт ихээхэн зарцуулагдаж байгаагийн үр дүн юм.
- ◀ Боловсролын бодлого нь орлого багатай иргэдийг дэмжихэд чиглэхгүй байна. Боловсролын ихэнх хөтөлбөр нь, жишээлбэл, хүүхдийн хоол, бүх нийтийг хамарсан шинжтэй байхад, зорилтот бүлэгт чиглүүлсэн зарим арга хэмжээ нь эзэндээ хүрээгүй байна.
- ◀ Хямралын улмаас боловсролын салбарт үзүүлж буй нөлөөг судлахад мэдээлэл ихээхэн дутмаг байна. Энэ нь тухайн салбарын үндсэн бэрхшээлүүдийн нэг юм. Боловсролын төсөвт таналт хийгдсэн хэдий ч үндсэн үйлчилгээнд нөлөө үзүүлэх хэмжээний таналт гэж үзэх үндэслэлгүй юм. Харин, өрхийн үйл хөдлөлд өөрчлөлт орж, хямралын улмаас сургууль завсардалт өссөн эсэхийг дүгнэх тоон мэдээлэл нь энэ оны сүүлээр гарах төлөвтэй байна.
- ◀ 2006 онд Эрүүл мэндийн даатгалын болоод Эрүүл мэндийн хуулиудад нэмэлт өөрчлөлт хийж эрүүл мэндийн даатгалын энэ салбарт гүйцэтгэх үүргийг хязгаарлагдмал болгосон. Энэ тодотголоор эрүүл мэндийн байгууллагуудын бараг бүх зардлыг Засгийн газрын зарлагаар санхүүжүүлэхээр зааж өгсөн.
- ◀ Эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх нь хоёрдогч болоод гуравдагч шатны нарийн мэргэжлийн үйлчилгээнээс зарлага багатай тул анхан шатны эмнэлгүүдийн гүйцэтгэх үүргийг өсгөх нь нийт эрүүл мэндийн салбарын үр ашгийг дээшлүүлэхэд сайнаар нөлөөлнө.
- ◀ Эмнэлгүүдийн үйл ажиллагаа зарлага өндөртэй, үр ашиг багатай гэдэг нь тогтоогдсон учраас тэдгээрийн үйл ажиллагааг харилцан уялдуулж, шаардлагагүй гэж үзсэн эмнэлгүүдийг хаах, гарцаагүй байх ёстой эмнэлгүүдэд үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах талаар нэгдсэн бодлого дутагдаж байна. Өрхийн эмнэлгүүдийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, нөгөө талаас хоёрдогч болоод түүнээс дээд шатны эмнэлгүүдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх нь эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал болоод байна.
- ◀ Хямрал өрхийн түвшинд ямар нөлөө үзүүлсэн талаар хийсэн судалгаа алга байна. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс хөдөөгийн өрхийн орлого ихээхэн багассан байж болзошгүй байна.

- ◀ Хотын өрхийн хувьд ямар өөрчлөлт гарсан талаар 2009 оны 10 дугаар сард гурван шатны санамсаргүй түүвэрлэлтээр нийслэл хотын 6 дүүргийн 24 хороонд оршин суух 400 өрхөд сарын дундаж орлого, зарлага, хүнсний болон хүнсний бус бараа, үйлчилгээний хэрэглээ хэрхэн өөрчлөгдсөн талаар тандалтын судалгаа хийсэн.
- ◀ Судалгаагаар эдгээр өрхийн сарын дундаж мөнгөн орлого 487,460 төгрөг байгаа бөгөөд энэ нь 2008 онд хот суурийн газарт орших өрхийн сарын дундаж орлого болох 406,667 төгрөгөөс 20 хувиар илүү байна. Эдгээр өрхийн сарын дундаж мөнгөн зардал 443,724 төгрөг буюу 2008 оны улсын нийт хот суурин газарт орших өрхийн сарын дундаж орлого болох 410,134 төгрөгөөс 8 хувиар илүү байна.
- ◀ Эдгээр 400 өрхийн хувьд 2008 оны эхний есөн сартай харьцуулахад 2009 онд уг өрхийн хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ ерөнхийдөө хэвийн байсан гэж хариулсан байна. Харин элсэн чихэр, жимсний хэрэглээ нь илүү буурсан байна. 2009 он гараад эдгээр айлууд дунджаар нэг сард 284 мянган төгрөг хүнсний бус бараа болон үйлчилгээнд зарцуулж байгаа нь 2008 оны хот суурин газрын айлуудын дундаж хэмжээ болох 200 мянган төгрөгөөс өндөр байна. Хүнсний бус бараа болон үйлчилгээний зарлага өндөр байгаагийн гол шалтгаан нь 2008 онтой харьцуулахад эдгээр өрхийн 55 хувь нь боловсролд, 42 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнд, 43 хувь нь тээвэр, холбоонд, 28 хувь нь хувцсанд зарцуулах зардал өссөн гэж үзэж байгаатай холбоотой байна.



## 2. Оршил

Дэлхийн эдийн засгийн хямрал өндөр хөгжилтэй орнуудад нэгэнтээ доод цэгтээ хүрлээ гэж хэдэн сарын өмнө мэдэгдсэн. Хямрал доод цэгтээ хүрэх, бодит өсөлт гарах хоёрын хооронд цаг хугацааны зөрүү байдаг бөгөөд энэ нь ихээхэн удаан үргэлжлэх ч боломжтой байдаг. Түүгээр ч үл барам байдал дахин муудах магадлалыг ч үгүйсгэж болохгүй. Иймээс Олон Улсын Валютын Сан (ОУВС) эдийн засгийг дэмжсэн төсвийн тэлэлтээ үргэлжлүүлэхийг зөвлөсөөр байна. Дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын G20 бүлэг дэлхийн эдийн засгийн 85 хувийг эзэлдэг бөгөөд эдгээр орнуудад хэрэгжүүлж буй төсвийн тэлэлтийн бодлого дэлхийн ДНБ-ийг энэ онд дор хаяж 1 пунктээр, ирэх онд түүнээс арай багаар өсгөнө гэсэн тооцоог ОУВС-аас гаргасан байна. Ирэх оны хувьд дэлхийн эдийн засаг 3.1 хувиар өснө, үүнд АНУ-ын эдийн засаг 1.5, Япон 1.7, Еврогийн бүс 0.3, БНХАУ 9 орчим хувиар өсөх төлвийг гаргажээ<sup>1</sup>. Үүнээс харахад 2009 онд дэлхийн эдийн засаг 1.1 хувиар унах төлөвтэй харьцуулбал эдийн засаг ирэх онд сэргэнэ гэсэн хүлээлттэй байна. Гэхдээ энэхүү сэргэлт нь нэлээд удаан хугацаанд явагдаж, зээлийн эх үүсвэрийн хомсдол болон ажилгүйдлийн өндөр түвшин тодорхой хугацаанд үргэлжлэхийг сануулж байна. Төсвийн томоохон тэлэлт хийсэн хөгжингүй орнуудын хувьд засгийн газрын өр нэмэгдэж, 2014 онд ДНБ-ий 110 хувьд хүрнэ гэсэн тооцоо байна. Хямрал нүүрлэхээс өмнө буюу 2007 онд энэ үзүүлэлт 80 хувьтай байжээ. Энэ нь урт хугацаандаа зээлийн хүү өсөх хандлагыг бий болгож, эдийн засгийн сэргэлтийг удаашруулах мадагдалтай.

Манай улсын хувьд энэ оны эхний улиралд ДНБ үлэмж хэмжээгээр унасан нь хямралын томоохон дохио болсон. Харин хоёрдугаар улирлаас эхлэн уналт саарсантай холбоотой хүлээлт нэлээд өөдрөг болж, хүнд хэцүү үе ард хоцорлоо гэсэн дүгнэлтийг зарим хүмүүс хийсэн. Гэсэн хэдий ч энэ улирлын инфляциас бусад макро үзүүлэлтүүд сөрөг хэвээр, бүр муудаж гарсан нь хямрал дуусах болоогүй гэдгийг сануулж байна. Мөн хямрал нь урьдчилан таахад бэрхшээлтэй эрсдлийг дагуулж байдаг гэдгийг дахин санахад илүүдэхгүй биз.

1 International Monetary Fund (2009) "World Economic Outlook: Sustaining the Recovery", October

Энэ удаагийн тайландаа бид манай орны эдийн засагт гуравдугаар улиралд ямар өөрчлөлтүүд гарсан, бодлогын ямар арга хэмжээ авагдсан, энэ нь ямар үр дүнтэй байсан талаар дэлгэрэнгүй авч үзлээ. Дотоодын үйлдвэрлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан хэвээр байгаа бөгөөд уналт нь энэ оны өмнөх улирлаас ихэссэн нь хямрал гүнзгийрч буйн шинж юм. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, барилга, үйлчилгээ зэрэг гол салбар уналттай хэвээр байна. Харин зэсийн үнэ өссөнөөс уул уурхайн салбарын уналт саарсан ч өсөлт гараагүй хэвээр байна. Энэ жилийн хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, тэр дундаа газар тариалангийн бүтээгдэхүүн нэлээд өсөлттэй байгаа нь байгалийн таатай нөхцөл, энэ салбарыг дэмжсэн Засгийн газрын бодлоготой холбоотой юм. Энэ улиралд гадаад худалдаа өмнөх улиралтай харьцуулахад үргэлжлэн өссөн хэдий ч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Ашигт малтмал, түүн дотроо алт болон бохир ноолуур зэрэг зарим нэг бүтээгдэхүүний эрэлт өндөр байна. Дүнгээрээ экспорт 23, импорт 46 хувийн уналттай байснаас гадаад худалдааны тэнцэл сайжирсан нэг давуу тал ажиглагдаж байна. Дотоодын үйлдвэрлэл болон гадаад худалдааны талаарх тоон мэдээлэл болон холбогдох дүн шинжилгээг 4 дүгээр бүлгээс харна уу.

Макро эдийн засгийн бодлогод гарсан өөрчлөлтүүдийг мөн дээрх бүлэгт авч үзэв. Төсөв, сангийн бодлогод онцгой өөрчлөлт гараагүй бол бодлогын хүү буурснаар мөнгөний бодлого энэ хугацаанд зөөлөрч эхэлсэн байна. Харин Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан, урьдчилсан төлбөр болох 100 сая ам. доллар манай Засгийн газрын дансанд орсон, хоёр банк нэгдсэн, Хөгжлийн банк байгуулах, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулж байгаа зэрэг бодлогын чанартай болон цаашдаа эдийн засагт томоохон нөлөө үзүүлэх үйл явдлууд боллоо. Үүнтэй холбоотойгоор бид дүн шинжилгээ хийж, өөрсдийн бодлыг илэрхийлэв. Ингэхдээ Норвеги болон Чилийн хуримтлалын сан зэрэг бусад орны жишээг 4 дүгээр бүлэгт авч үзэв.

Манай төсвийн зарлагын томоохон хувийг эзэлдэг боловсрол болон эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, суурь бэрхшээл, тулгамдсан зарим асуудал, хямралын энэ салбарт үзүүлсэн нөлөө зэргийг тайлангийн 5 дугаар бүлэгт судалж, холбогдох дүгнэлтүүдийг хийв. Энэ хоёр салбар нь зарцуулж буй хөрөнгийн хувьд бусад орнуудтай харьцуулахад өндөр байдаг хэрнээ үр дүнгийн үзүүлэлтүүдийн хувьд тэдгээрээс илүү гарч чадахгүй байгаа, зарим тохиолдолд муу байгаа нь зарцуулж буй хөрөнгийн үр ашгийн тухай асуудлыг босгож байна. Бидний үзэж байгаагаар энэ хоёр салбарын аль алинд нь төрийн оролцоо хэт их бөгөөд төсвийг оновчгүй хөтөлбөр, үйлчилгээнд зарцуулж байгаа нь хувь хүний үйл хөдлөлд сөргөөр нөлөөлж, зарим тохиодолд “хэт хэрэглээ”-г бий болгож байна гэж дүгнэснийг 5 дугаар бүлгээс үзнэ үү.

Тайлангийн сүүлийн бүлэгт эдийн засгийн хямралын өрхийн түвшинд үзүүлж буй нөлөөг судлахыг зорив. Өнөөгийн байдлаар манай эдийн засагт үзүүлж буй хямралын нөлөөг голчлон цөөн тооны макро үзүүлэлтээр л баримжаалж байна. Бодит эдийн засгийн салбар, өрх гэр, пүүсийн түвшинд хийсэн судалгаа тун хомс байна. Микро түвшний тоон болон чанарын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, тэдгээрт үндэслэн бодлого боловсруулах нь хямралт байдлыг даван туулах, төрөөс хэрэгжүүлэх нийгмийн халамжийн болон бусад бодлогуудыг оновчтой болгоход дөхөмтэй юм. Иймээс бид Улаанбаатар хотын 400 өрхийн хувьд орлого, зарлага, хэрэглээнд гарсан өөрчлөлтийг

илрүүлэх, холбогдох дүгнэлтийг хийх зорилгоор тандалтын судалгааг хийж, үр дүнг энэхүү тайландаа оруулав. Хэдийгээр судалгааны түүвэр нь нийслэл хотын 235 мянган өрхийг бүрэн төлөөлж чадахгүй ч тодорхой хэмжээний мэдээллийг өгч буйгаараа өрхийн түвшний мэдээллийн хомс байдлыг даван туулахад хувь нэмрээ оруулна гэж үзэж байна. Энэ судалгаагаар өрхийн нэрлэсэн орлого болон зарлага буурсан хандлага ажиглагдахгүй, харин ч өнгөрсөн онтой харьцуулбал бага зэргийн өсөлттэй байна. Хэрэглээний хувьд бүтцийн мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй байна. Өрхийн орлого, зарлага, хэрэглээний талаарх дэлгэрэнгүй тоо болон дүгнэлтийг 6 дугаар бүлгээс үзнэ үү.

### 3. Дэлхийн санхүү, эдийн засгийн байдалд гарсан өөрчлөлт

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал доод цэгтээ хүрч улмаар тогтворжих зарим шинж тэмдэг ажиглагдаж эхэлсэн талаар энэ оны гуравдугаар улирлаас хөгжингүй зарим орнууд мэдэгдээд байна. Уг мэдэгдэл санхүү, эдийн засгийн хямрал саарсныг илтгэж байгаагаас бус эдийн засаг илааршиж, эдийн засгийн өсөлт бий болох талаар ярихад хараахан эрт байгааг бас анхааруулсан билээ. Дэлхий нийтийг хамарсан энэхүү хямрал саарч байгаа нь таатай мэдээ хэдий ч хямралаас бий болсон эдийн засгийн хүндрэлийг даван туулахад ямар бодлого хэрэгжүүлэх, амар арга замыг сонгох зэрэг нь ихээхэн чухал шийдвэр шаардсан асуудлууд болоод байна.

Дэлхий нийтийг хамарсан хямралд харьцангуй бага өртсөн улсуудын тоонд Австрали, Израиль болон манай урд хөрш Хятад зэрэг улс багтаж байна. Азийн орнууд хямралыг харьцангуй хохирол багатай даван туулж байгаа нийтлэг жишиг байгаа бол Австрали улс нь хямралын давалгаанд бага өртсөн, онцгой тохиолдлын улсад тооцогдож байна. БНХАУ төсөв санхүүгийн болон мөнгөний тэлэх бодлогоо үргэлжлүүлж байгаа бөгөөд Хятад болон Энэтхэгийн эдийн засгийн өсөлт нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг үндсэндээ тодорхойлов. Гэхдээ эдгээр улсуудын эдийн засгийн тогтворжилт, макро эдийн засгийн нааштай үзүүлэлт нь дэлхийн эдийн засаг эрүүлжиж байгаагийн дохио болж чадахгүй байна. Хямралд хүчтэй нэрвэгдсэн Европын улсууд, Америк болон Их Британи зэрэг томоохон эдийн засгууд өнөө хэр нь ажилгүйдэл, бодит орлогын бууралт, банк санхүүгийн сул байдал зэрэг олон хүндрэлтэй асуудалтай тулгарсаар байгаа нь дэлхий эдийн засаг эрүүлжих хараахан болоогүйг нотолсоор байна.

Дэлхийн эдийн засгийн сэргэлт нь санхүүгийн тогтолцооны хүндрэл үргэлжилсээр байгаа, ажилгүйдэл, ядуурлын түвшин нэмэгдэж байгаа, эдийн засагт хуримтлалыг нэмэгдүүлэх үйл явцад тодорхой хугацаа шаардагдаж буй зэргээс шалтгаалан удаашрах төлөвтэй байна. Тиймээс дэлхийн улсууд хямралын үед төсвөөс үзүүлж буй бодлогын дэмжлэгийг ямар дэс дараалал болон хурдацтайгаар хумих асуудлыг хэлэлцэж эхлээд байна. Бодлогын шийдвэр гаргагчид нь төсвийн дэмжлэгийг шат дараалалтай бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэдэг дээр санал

нэгдэж буй ч төсвөөс олгосон дэмжлэгээ буцаан татаж эхлээгүй байна. Энэ нь дэлхийн эдийн засаг сэргэх болоогүй, тогтворгүй, эмзэг байдалд оршин байгааг илтгэж байна.

Хямралд нэрвэгдсэн дийлэнх улс орнуудад төсвийн алдагдал өндөр байна. Төсвийн зарлагын өсөлтөөр эдийн засгийн уналт зогсож, тогтворжиж эхэлж байхад төсвөөс үзүүлэх эдийн засгийн дэмжлэгийг огцом зогсоох, буцаан татах нь нөхцөл байдлыг улам муутгаж болзошгүй гэсэн болгоомжлол өндөр байгаагийн дээр засгийн газрууд шаардлагатай гэж үзвэл шинэ нэмэлт санхүүжилтийг хийх, идэвхи санаачилгыг өрнүүлэхэд анхаарлаа хандуулсаар байна. Эдийн засагт төрийн оролцоог аль болох багасгах нь чухал байдаг ч төсвийн дэмжлэгийг огцом бууруулж, буцаан татах нь нөхцөл байдлыг улам муутгаж болзошгүй гэсэн болгоомжлол өндөр байгаа юм. Бүхэлдээ, санхүү эдийн засгийн хямралын үед төсвөөс олгосон дэмжлэгийн үр нөлөөний талаар дүгнэлт, үнэлгээ хараахан хийгдэж дуусаагүй, зарим улсуудад дөнгөж эхлэлийн шатандаа хэрэгжиж байна.

Хямралын үед төсвөөс үзүүлсэн дэмжлэгээс хэн ямар хэмжээний үр ашиг хүртсэн талаарх судалгаа, хэлэлцүүлэг АНУ-д эхлээд байгаа ба энэ ажлын хүрээнд төсвийн дэмжлэг авсан томоохон банк, санхүүгийн байгууллагын данс бүртгэл, ашигт ажиллагааны түвшинг шалгаж, төсвийн дэмжлэгийн хуваарилалт, ашиглалтад үнэлэлт дүгнэлт өгч эхлэв. Тус ажлын хүрээнд томоохон санхүүгийн институци, компаниудын төсвийн дэмжлэгийн зарцуулалтад хийсэн хяналтаас тухайн байгууллагын дээд удирдлагын цалин хөлс, бусад зардалд зарцуулсан хэмжээ хэт өндөр байгааг шүүмжилж, цаашид төсвийн дэмжлэгийг томоохон удирдлагын зардлыг санхүүжүүлэхэд зарцуулахгүй байх асуудлыг хэлэлцэж байна. Дашрамд, өнгөрсөн онд төсвөөс ихээхэн дэмжлэг авсан томоохон банк санхүүгийн байгууллагууд, Гоулдмэн Сакс, Бэнк оф Америка, Ситигруп зэрэг нь энэ оны дундаас төсвийн дэмжлэгийг буцаан төлж эхлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн.

Дэлхийн улс орнуудын өнөөгийн эдийн засгийн бодлогын тулгамдсан асуудлыг тоймлон авч үзвэл, нэг талаас төсвийн дэмжлэгийг хугацаанаас нь эрт болиулбал санхүүгийн тогтвортой байдал, сэргэлт бий болох тал дээр олсон ахиц дэвшилд сөрөг нөлөө үзүүлэх, нөгөө талаас эдгээр арга хэмжээг удаан хугацаанд авч хэрэгжүүлснээс эдийн засгийн санаачилгыг бууруулах, сөргөөр нөлөөлөх, инфляцийг дунд хугацаандаа хөөрөгдөх, төсвийн алдагдал нэмэгдэх эрсдлийг тооцоход улсууд томоохон бодлогын сонголт хийх хэрэгтэй болов.

Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн Банкнаас 2009 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн талаарх таамаглалуудаа он гарсаар хэд хэдэн удаа өөрчилсөн. Энэ нь дэлхийн эдийн засаг хямралын нөлөөгөөр маш тогтворгүй байдалд орсныг баталж байна. Дэлхийн зарим улсуудын 2009 оны бодит ДНБ, ажилгүйдлийн түвшин, хэрэглээний үнэ болон урсгал тооцооны тэнцлийн талаар ОУВС-ийн урьдчилсан төлвийг хүснэгт 3.1-д үзүүлэв.



Хүснэгт 3.1. Дэлхийн зарим улсуудын макро эдийн засгийн үзүүлэлт, 2009 оны урьдчилсан төлөв

	ДНБ-ийн бодит өсөлт (%)	Хэрэглээний үнийн индекс	Ажилгүйдлийн түвшин	Урсгал тооцооны тэнцэл (ДНБ-ий %)
АНУ	-2.7	-0.4	9.3	-2.6
Европын хөгжингүй улсууд	-4.2	0.3	9.9	-0.7
Япон	-5.4	-1.1	5.4	1.9
Их Британи	-4.4	1.9	7.6	-2.0
БНСУ	-1.0	2.6	3.8	3.4
БНХАУ	8.5	-0.1	-	7.8
Энэтхэг Улс	5.4	8.7	-	-2.2
ОХУ	-7.5	12.3	-	3.6
Монгол	0.5	8.5	-	-6.9

Эх сурвалж: ОУВС «Дэлхийн эдийн засгийн тойм», 2009 оны 10 дугаар сар

Дэлхийд тэргүүлэгч улсуудын томоохон зөвлөгөөн болох G20-ийн хүрээнд дэлхийн эдийн засагт хүч түрэн орж ирж буй өндөр өсөлттэй улсууд болох БНХАУ, ОХУ болон Энэтхэгийн байр суурь, нөлөө өссөөр байна. Дээр дурдсанаар хөгжиж буй улсуудын энэ оны эдийн засгийн өсөлт нь Хятад болон Энэтхэг улсын эдийн засгийн өсөлтөөр тодорхойлогдож байна. 2009 оны гуравдугаар улиралд Хятадын эдийн засаг 8.9 хувиар, харин Энэтхэг улсынх 5.3 хувиар өсчээ. Өмнөх улиралд хоёр орон 7.9 болон 7.6 хувиар тус тус өссөн байна. ОХУ-ын эдийн засаг гуравдугаар улиралд 9.4 хувиар хумигдаад байгаа нь энэ оны хоёрдугаар улирлын 10.9 хувийн бууралтыг бодвол бага зэрэг сайжирсан үзүүлэлт юм.

2009 оны 7 дугаар сарын байдлаар ажилгүйдлийн түвшин Европын өндөр хөгжилтэй улс болох Францад 9.8, Германд 8.3, Их Британид 7.9, Испанид 18.5 хувь, цаашилбал Польшид 11.1, Унгарт 9.9, Латвид тус тус 12 хувьтай байв. Хямралын нөлөөгөөр зарим хөгжингүй улсуудад ажилгүйдлийн түвшин дунд хугацааны туршид өндөр хэвээр байх төлөвтэй байна. ОУВС-ийн тооцоолсноор 2010 онд Европ дахь ажилгүйдлийн түвшин 12 хувьд хүрнэ гэнэ.<sup>2</sup> Ажиллах хүчнийг бизнесийн салбарууд руу буцаан оруулах, ингэхдээ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээмжийн тогтмол өсөлтийг хангахуйц зээлийн санхүүжилтийг бий болгох замаар бүтцийн өөрчлөлт хийх асуудал урган гарч ирж байна. Тодруулбал, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийх нь зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад чухал алхам болох ёстой юм. Санхүүгийн байгууллагуудыг дахин хөрөнгөжүүлэх, амьдрах чадвартай банкуудад бүтцийн өөрчлөлт хийх, харин амьдрах чадваргүй банкуудын асуудлыг болгоомжтой, шат дараатайгаар шийдвэрлэх, үүний тулд давын өмнө банк санхүүгийн институцийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхээс ажлаа эхлэх хэрэгтэй гэж үзжээ. Төсвийн дэмжлэгт аль болох найдахгүй байлгах үүднээс зах зээлд үндэслэсэн идэвх санаачилгыг дэмжих замаар засгийн газрын эдийн засгийн хөтөлбөрүүдийг ээлж дараалалтайгаар алгуур багасгах шаардлага өнөөгийн байдалд чухлаар тавигдаж байна.

2 International Monetary Fund (2009) "World Economic Outlook: Sustaining the Recovery", October

Хямралын томоохон сөрөг нөлөө нь хөгжингүй орнуудад ажилгүйдэл эрс нэмэгдэх, харин хөгжиж буй орнуудад ядуурлын түвшин огцом өсөх хандлагаар илэрч байна. Тодруулбал, 2009 онд нэг хүнд ногдох ДНБ-ий бодит хэмжээ нь сүүлийн 10 жилд анх удаа буурсан Сахарын бүсийн Африкийн орнуудад ядуурлын түвшин огцом өсөхөөр байна. Хямралын өмнөх жилүүдэд дэлхийн эдийн засаг халалттай байсны маш тодорхой жишээ нь сүүлийн таван жилийн туршид Африкийн эдийн засгийн өсөлт 5.5 хувиас буурахгүй байснаас харагдаж байна. Африк тивийн эдийн засаг сүүлийн таван жилийн туршид ийнхүү өндөр өсөлттэй байхад гадаад эдийн засгийн орчны таатай нөлөө гол үүрэг гүйцэтгэжээ. Сонирхуулахад, Африк тивд дэлхийн алмазын нөөцийн 60, кобальтийн 30, фосфоритын 40, газрын тос болон нефтийн 10-15 хувь тус тус байдаг юм байна.<sup>3</sup> 2009 онд тус тивийн эдийн засгийн өсөлт огцом буурах нь нэгэнт тодорхой болоод байна.

ОУВС-ийн сүүлийн таамаглалаар хөгжиж буй улс орнуудын ДНБ-ий бодит өсөлт 2009 онд 1.75 хувьд хүрэх урьдчилсан төлөвтэй байгаа нь 2008 оны өсөлтөөс даруй 4 пунктээр доогуур үзүүлэлт болно. Дэлхийн Банкны судалгаагаар хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нэг пунктээр буурах нь ядуучуудын тоог 20 саяар нэмэгдүүлдэг. Тэгвэл энэ онд хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт өнгөрсөн оноос 4 пунктээр буурснаар ядуучуудын тоо 80 саяар өсч болзошгүй байна.

АНУ-д хямралын нөлөөгөөр 2.6 сая гаруй хүн ядуурал руу гулсан орсны дээр ажилгүйдлийн түвшин энэ оны 9 дүгээр сард 9.8 хувьд хүрчээ. Өсөн нэмэгдэж буй ажилгүйдэл, ядуурлын түвшнээс улбаалан энэ онд АНУ-д зээлээр орон сууцаа авсан 1.8 сая иргэд орон сууцаа алдаж болзошгүй байдалд хүрээд байгааг судалгаа харуулж байна.<sup>4</sup> АНУ-ын орон сууцны үнэ 2009 оны хоёрдугаар улирлаас эхлэн бага зэрэг өссөн нааштай хандлага бий хэдий ч хэрэглэгчдийн итгэлийн индекс<sup>5</sup> тогтвортой өсөхгүй, хэлбэлзсээр байгаа нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагааны 70 орчим хувийг хэрэглээний зарцуулалт эзэлдэг тус улсын хувьд таагүй үзүүлэлт юм. Иргэд баталгаатай ажилтай, байнгын тогтвортой орлоготой болсон үедээ бүтээгдэхүүн болон үйлчилгээний хэрэглээндээ илүү ихийг зарцуулдаг. Тэгвэл ажилгүйдлийн түвшин 10 орчим хувьтай байгаа нь дэлхийн томоохон хэрэглэгч тус улсын иргэдийн хэрэглээний үйл хөдлөлд мэдэгдэхүйц өөрчлөлтийг бий болгоод байна. Бид өмнөх тайландаа Америкийн өрх гэрүүд өнгөрсөн оны сүүлээс эхлэн хадгаламжаа нэмж эхэлсэн бөгөөд хувийн хадгаламж өрхийн орлогын 6.9 хувьд хүрээд байгааг онцолсон билээ.<sup>6</sup> Америкийн хэрэглэгчдийн үйл хөдлөлд гарч буй эдгээр өөрчлөлт нь дэлхийн улс орнуудын эдийн засаг, тэр дундаа хөгжиж буй болон өндөр өсөлттэй орнуудын эдийн засагт бүтцийн өөрчлөлт, тэдгээрийн бараа бүтээгдэхүүний экспортод шинэ хандлагыг бий болгож болзошгүй юм. Өмнөх тайланд дурдсанаар энэ нь давын өмнө Хятадын экспортод суурилсан өндөр өсөлтийн үеийн төгсгөл ирж буйн дохио байхыг үгүйсгэх аргагүй юм. Дэлхийн эдийн засагт үүссэн нөхцөл байдлаас экспортод түшиглэсэн өсөлтийн стратеги баримталдаг, урсгал дансны илүүдэлтэй хөгжиж буй олон эдийн засаг дотоодын эрэлт, импортдоо илүү

3 Pan African Capital Group Report, 2009 оны 9 дүгээр сар

4 Research Study, Realty Trac, United States, 2009 оны 9 дүгээр сар

5 Bureau of Labor Statistics, United States, 2009 оны 10 дугаар сар

6 Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө, хоёрдугаар улирлын тайлан, 2009 он

найдаж, энэ чиглэлийн бодлогодоо шинэчлэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тулгарч байна.

АНУ-д ядуурлын түвшин 2007 онд 12.5 хувьтай байсан бол 2008 онд 13.2 хувь болж өссөнөөр 39.8 сая Америкчууд ядууралд нэрвэгдээд байна. Энэ нь 1960 оноос хойш тус улсад бий болсон хамгийн өндөр ядуурлын үзүүлэлт ба ядуурал ийнхүү өссөнтэй холбоотой тус улсын голч орлоготой өрхийн орлого 2008 онд 2007 оноос 2000 ам. доллараар буурчээ.<sup>7</sup> АНУ-ын ДНБ оны эхний улиралд 6.2 хувь унасан бол хоёрдугаар улиралд уналтын түвшин багасч 0.7 хувиар буурсан байна.<sup>8</sup> Гэсэн хэдий ч ажилгүйдлийн түвшин нэмэгдсээр байгаа болон ядуурал өссөнөөс нийгмийн халамжийн үйлчилгээнээс хүртэгсдийн тоо энэ онд эрс нэмэгдэхээр болжээ.

АНУ-ын долларын ханш энэ оны 3 дугаар сараас эхлэн гол зургаан валютын эсрэг 14 хувиар унасан<sup>9</sup>. Долларын ханшны сулралтаас Америкийн экспортын дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэж, өнгөрсөн 8 дугаар сард экспорт өсч, импорт буурсан дүнтэй байгаа нь тус улсын гадаад худалдааны алдагдлыг бууруулсан гэж тэмдэглэж байна. Долларын ханшны сулралт нь дэлхийн зах зээлд ямар өөрчлөлтийг бий болгов? Долларын ханш суларсантай холбоотойгоор хөрөнгө оруулагчид дэлхийн зах зээлд алтны худалдан авалтаа нэмэгдүүлж, алтыг нөөцөлж байгаагаас дэлхийн зах зээлд алтны үнэ өсч байна. Уул уурхай олборлох салбарт томоохон хувийг алтны үйлдвэрлэл эзэлдэг манай улсын хувьд энэ нь эерэг хандлагыг илэрхийлж байна. Зогсонги байдалд ороод байсан манай улсын алтны экспорт энэ улиралд өссөн нь үүнтэй холбоотой байх магадлалтай юм. Үнэт эдлэлийн эрэлт 13.8 хувиар унасан байхад дэлхийн зах зээлд алтны худалдан авалт сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд 110 хувиар өсч, 8.4 сая унци алтыг 8.7 тэрбум ам. доллараар худалдан авсан байна<sup>10</sup>. Алт төдийгүй түүхий нефтийн дэлхийн зах зээлийн үнэ энэ оны 6 дугаар сараас эхлэн нэг баррель нь 65-аас 75 ам. долларын хооронд өндөр хэлбэлзэлтэй байгаа нь ам. долларын ханш суларсантай болон дэлхийн эдийн засаг цаашид сэргэнэ гэсэн хүлээлттэй холбоотой.

Дээр дурдсанаар хямралын нөлөөгөөр хөгжингүй орнуудад ажилгүйдэл, хөгжиж буй орнуудад ядуурлын түвшин огцом өссөнөөр дэлхийн эдийн засгийн хүндрэл цаашид үргэлжлэх төлөвтэй байна. Тиймээс ажиллах хүчнийг бизнесийн салбар руу буцаан татах, хөрөнгө оруулалт, бүтээмжийн тогтмол өсөлтийг хангахуйц зээлийн санхүүжилт хийнэ гэдгээс дэлхийн олон улс эдийн засагтаа тэр дундаа банк санхүү, бизнесийн салбартаа шинэчлэлт, бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тулгарав. Хямрал зогсонги байдалд орлоо, эдийн засаг цаашид сэргэнэ гэсэн иргэдийн итгэл найдвар, эдийн засгийн өрсөлдөх чадвар, давуу талаа алдах вий гэсэн бизнес эрхлэгчдийн айдас, эргэлзээ, техникийн болон бусад шалтгааны улмаас бодлогын сайн шийдвэр гаргаж чадахгүй байх вий гэсэн бодлого боловсруулагчдын болгоомжлолын дунд дэлхийн эдийн засаг өрнөж байна.

7 United States' Census Bureau, 2009 оны 9 дүгээр сар

8 Bureau of Economic Analysis, Commerce Department, United States, 2009 оны 9 дүгээр сар

9 Bloomberg News Report, 2009 оны 10 дугаар сар

10 Exchange-Traded Fund (ETF) Security Report, 2009 оны 10 дугаар сар


## 4. Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн байдал

### 4.1. Дотоодын үйлдвэрлэл

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2009 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буурч огцом уналттай байснаа хоёр, гуравдугаар улиралд уналт багассан нь дэлхийн эдийн засгийн хямрал зогсонги байдалд орж, цаашид тогтворжиж эхлэх зарим шинж тэмдэг бий болсонтой холбоотой юм (Зураг 4.1). Манай улсын ДНБ-ий сүүлийн жилүүдийн огцом өсөлт ч, энэ онд бий болсон уналтын үйл явц ч манай орны эдийн засаг дэлхийн эдийн засгийн ерөнхий хандлага, эдийн засгийн мөчлөгийн эерэг болон сөрөг нөлөөний аль алинд маш мэдрэмтгий, түүнээс хүчтэй шууд хамааралтай байгааг нотолж байна.

Өнгөрсөн оны сүүлээс манай эдийн засгийн дотоодын үйлдвэрлэлд бий болсон шинж төлвийг тоймлон авч үзвэл ноолуурын үнэ ханш дэлхийн зах зээлд унаснаас боловсруулах үйлдвэрлэл буурч, уул уурхайн салбар зогсонги

Зураг 4.1. ДНБ-ий өсөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулахад



Эх сурвалж: УСХ, 2008 ба 2009 оны 9 дүгээр сарын бюллетень

байдалд орсноор тээвэр, харилцаа холбооны салбарын үйлдвэрлэл багасч, хүн амын худалдан авах чадвар буурснаас жижиглэнгийн болон бөөний худалдаа буурч, нийтдээ банкны зээл зогссоноос үйлдвэрлэл, үйлчилгээний салбар уналттай хэвээр байна.

2009 оны эхний гурван улиралд манай улсын ДНБ (2005 оны зэрэгцүүлсэн үнээр) 2529.6 тэрбум төгрөг болж, 2008 оны мөн үеэс 2.2 хувиар буурсан нь Дэлхийн Банкнаас 2009 оны 2 дугаар сард гаргасан тайланд манай улсын ДНБ энэ онд 2.7 хувиар өснө гэсэн таамаглал биелэх магадлал үндсэндээ байхгүй болсныг харуулж байна. Сангийн яамны энэ оны эдийн засгийн өсөлт 1.4 хувьтай байна гэсэн урьдчилсан тооцоо ч мөн биелэгдэх магадлал бага гэж үзэж байна.

**Аж үйлдвэр, хөдөө аж ахуй:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн оны эхний есөн сард өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буураад байна. Эхний хагас жилд 7.9 хувиар унаад байсан тус салбарын үйлдвэрлэлийн уналт гүнзгийрэхэд уул уурхай олборлох үйлдвэрлэл 2.4 хувь (эхний хагас жилд 1.6 хувиар буурсан), боловсруулах аж үйлдвэрийн салбар 27.8 хувиар (эхний хагас жилд 22.6 хувиар буурсан) унасан нь нөлөөлжээ<sup>11</sup>. Дотоодын үйлдвэрлэлийн салбарт уналт үргэлжилсээр байгаа нь хямралын эсрэг тэлэх бодлого хэрэгжүүлж чадаагүйтэй холбоотой юм. Ийнхүү эдийн засгаа дэмжих боломж мөнгөний болон төсөв, сангийн бодлогын хувьд үндсэндээ байхгүй талаар бид өмнөх тайлангууддаа дэлгэрэнгүй тайлбарласан<sup>12</sup>.

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо оны эхний есөн сард 5.3 хувиар буурснаас уул уурхайн салбарт 10.1 хувь, боловсруулах салбарт 4.5 хувиар багасчээ. 2009 оны эхний есөн сард бүртгүүлсэн ажилгүй иргэдийн нийт тоо 40 гаруй мянгад хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 27.1 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо төвийн бүс болон Улаанбаатарт 40 гаруй хувиар өсчээ. Бодит үйлдвэрлэлийн уналт ийнхүү үргэлжилбэл ажилгүйдлийн түвшинг цаашид ч нэмэгдүүлэх хандлагатай байна.

Мал аж ахуй болон газар тариалангийн салбарын хувьд, 2009 оны эхний есөн сарын байдлаар нийт төллөх эх малын 80.7 хувь төллөсөн, зүй бусаар хорогдсон том малын тоо өнгөрсөн оны мөн үеэс 2.8 хувиар нэмэгдсэн, харин хураасан үр тариа 59.7 хувь, төмс 28.6 хувиар өссөн, дарш бэлтгэл 2.9 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна<sup>13</sup>. Гэсэн хэдий ч агуулахын хүрэлцээ муу, саяхан болсон байгалийн хүндрэлд газар тариалангийн олон аж ахуй нэрвэгдсэн, үүнээс шалтгаалан хураан авч буй тарианы болц, чанар муудаж, хаягдал нэмэгдсэн зэрэг хүндрэлтэй асуудлууд салбарын хэмжээнд үүсээд байна. Засгийн газраас газар тариалангийн үйлдвэрлэлд үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд тус салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн хэдий ч уналтад ороод байгаа үйлдвэрлэлийн бусад томоохон салбарын хүчтэй нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэлийн салбарт нааштай өөрчлөлт гарч чадахгүй, уналт үргэлжилсээр байна.

Дотоодын үйлдвэрлэлийн уналт үргэлжиж байгаа болон ажилгүйдлийн түвшин өссөн зэргээс дүгнэхэд бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт эрэлт буурснаар үйлдвэрлэл, бодит орлого, ажил эрхлэлт багасч, манай эдийн засгийн уналт

11 ҮСХ, 2009 оны 1-ээс 9 дүгээр сарын бюллетень

12 “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө”, нэг, хоёрдугаар улирлын тайлан, 2009 он

13 Мөн тэнд



үргэлжилж буй шинж тэмдэг ажиглагдаж байна. Хүн амын 35.2 хувь нь ядуурлын түвшинд амьдардаг манай улсын хувьд нөхцөл байдал цаашид сайжрахгүй хэвээр үргэлжлэх нь олон тооны иргэдийг ядууралд татан оруулж болзошгүй юм. Сүүлийн 10 гаруй жилийн туршид ядуурлын түвшин буурахгүй байгаагаар үл барам хямралын үр нөлөөгөөр ядуурлын хамрах хүрээ улам тэлэх магадлалтай байна. Сүүлийн жилүүдэд ядуурлын эсрэг хэрэгжүүлсэн нийгмийн халамжийн бодлого эзэндээ хүрэхгүй байгаагийн нэг баталгаа болж байна. Цаашилбал, зөвхөн ядуурлыг зөв тооцож, эдгээр бүлэг хүмүүсийг илрүүлэхээс гадна эмзэг буюу, эдийн засгийн болон бусад нөхцөл байдал өөрчлөгдөхөд ядуурал руу гулган ороход бэлэн байгаа иргэдийн тоо, байршил зэргийг эдийн засгийн шалгуурт үндэслэн тогтоох нь энэ удаагийн хямрал болон цаашид үүсч болзошгүй бусад эрсдлийн үед хэрэгжүүлэх нийгмийн бодлогыг зөв зүйтэй тодорхойлоход дөхөмтэй болохыг сануулж байна.

**Барилга угсралт, үйлчилгээний салбар:** Сүүлийн таван жилд барилга угсралт болон үйлчилгээний салбар огцом өсөлттэй байсан. Хямралын шуурганд хүчтэй нэрвэгдсэн салбар бол барилгын салбар юм. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ оны эхний есөн сард дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 31.5 хувиар буурахад сүүлийн жилүүдэд өндөр хурдацтай байсан орон сууцны барилга 34 хувь, худалдаа үйлчилгээнийх 22 хувиар унасан нь муу нөлөө үзүүлжээ. Харин бүх төрлийн ачаа тээвэр мөн хугацаанд 2.8 хувиар буурсан ба үүнд төмөр замаар тээсэн ачаа 5.5 хувь, агаарын тээврээр тээсэн ачаа 35.4 хувиар буурсан нь сөргөөр нөлөөлөв<sup>14</sup>. Төмөр замаар тээсэн ачааны хэмжээ 2009 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар буурсан бол оны эхний гурван улиралд бууралтын хэмжээ багасч 5.5 хувьд хүрсэн нь гадаад худалдааны эргэлт гуравдугаар улиралд бага зэрэг сайжирсантай холбоотой гэж үзэж болохоор байна. Бүхэлдээ, тээврийн үйлчилгээний салбарын агаарын болон төмөр замын тээвэрлэлт буурсан хэдий ч авто замын тээвэрлэлтийн өсөлтөөр тодорхой хэмжээнд нөхөгдөж байгаа дүр зураг харагдаж байна. Энэ нь хямралын нөлөөгөөр автобензин болон түлшний үнэ тогтворжиж, хэрэглэгчдийн үйл хөдлөлд өөрчлөлт орсонтой холбоотой юм.

Гадаад эдийн засгийн нөлөөгөөр манай орны эдийн засгийн идэвхижил суларсан нь үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг уналтад оруулсан болохыг бид өмнөх тайландаа тэмдэглэсэн. 2009 оны эхний есөн сарын тоон мэдээнээс бодит үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт уналт үргэлжилсээр, энэ нь иргэдийн бодит орлогыг бууруулж, ажилгүйдлийг нэмэгдүүлж байгаа хандлага ажиглагдав. Ажилгүйдэл нэмэгдэхийн хэрээр ядуурлын түвшинд шууд нөлөө үзүүлдэг. Ажилгүйдэл, ядуурлын асуудлыг шийдэх зорилгоор ажлын байрны бууралтад хязгаарлалт хийх нь цалин хөлсний өсөлтийг удаашруулах, олон ажилчдын цалинг бууруулах сөрөг нөлөөтэй. Тиймээс ажиллагсдын эзэмшсэн боловсрол болон хамрагдсан сургалт нь ажлын байрны шаардлагад тохирсон байхын хэрээр ажлын байраа алдахгүй эсвэл цалин хөлс буурахгүй байхад дэмжлэг үзүүлж чадах билээ. Ажилгүйдлийн нийгмийн сөрөг үр дагаврыг багасгахад чиглэсэн хөтөлбөрийг чухам энэ чиглэлд хандуулах шаардлагатай байна.

Эхний хагас жилийн тайландаа бид дотоодын бодит үйлдвэрлэл үйлчилгээний салбарт уналт үргэлжилсээр байгаа, 2009 оны нэгдүгээр улирлыг бодвол хоёрдугаар улиралд гадаад эдийн засагт гарсан зарим нааштай нөлөөгөөр

14 ҮСХ, 2009 оны 1- 9 дүгээр сарын бюллетень

тодруулбал, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлтийн эерэг нөлөөгөөр уналт бага зэрэг саарсан ч эдийн засгийн хямрал доод цэгтээ хүрч, цаашид өсөлт ажиглагдах болоогүйг онцлон тэмдэглэсэн билээ<sup>15</sup>. 2009 оны эхний есөн сарын тоон мэдээ ч үүнийг дахин нотлов. Манай улсын дотоодын үйлдвэрлэлийн салбарт уналт үргэлжилсээр байгаа нь хямралын эсрэг бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх орон зай нэгэнт байхгүй байсны зэрэгцээ манай эдийн засаг гадаад эдийн засгаас шууд хүчтэй хамаардаг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бүтэц өрөөсгөл, эдийн засаг эмзэг байгаатай холбоотой гэж үзэв.

#### Шигтгээ 4.1. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл

Өнөөдөр Монголын тохилог орон сууцны зах зээлийг үндсэндээ хоёр хэсэгт хувааж болно<sup>1</sup>. Нэг нь 1990 оноос өмнө баригдсан хуучин орон сууц, нөгөө нь 2000 оноос хойш баригдсан буюу шинэ орон сууц юм. Энэ хоёр зах зээлд орон сууцны үнэлгээ болон үнийн хөдөлгөөн нь өөр динамикаар явагддаг. Шинэ орон сууц талбайн хэмжээгээр тооцогдон ам. доллараар үнэлэгддэг. 1990 оноос өмнө баригдсан байрны хувьд хэдэн өрөө байр гэдгээсээ хамаарч үнэлэгддэг. Жишээ нь: 3, 4 дүгээр хорооллын 3 өрөө байр энэ онд дунджаар 50-60 сая төгрөг<sup>2</sup>, хотын төвийн харьцангуй чанартай баригдсан гэгдэх шинэ орон сууцны кв. метрийн үнэ 1000-1500 ам. доллар байна.

Сүүлийн хоёр жилийн дотор үл хөдлөх хөрөнгийн зах зээл тун тогтворгүй байлаа. 2007 оны хавраас 2008 оны зуны хооронд хуучин байрны үнэ 120-150 хувь өссөн бол 2008 оны зунаас хойш 40 хувь буугаад байна. Харин шинэ ялангуяа өндөр зэрэглэлийн орон сууцны үнэ харьцангуй тогтвортой буюу хэлбэлзлийн хэмжээ 20-40 хувьтай л байна<sup>3</sup>.

Нэгэн сонирхолтой үзэгдэл бол орон сууцны түрээсийн орлогын өгөөж нь үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлогын өгөөжөөс нилээд доогуур байгаа нь ажиглагдаж байна. Гуравдугаар хороололд байрлалтай 3 өрөө байрны сарын түрээс 350 мянган төгрөг, зах зээлийн ханш нь 55 сая<sup>4</sup> гэж тооцоход түрээсийн өгөөж жилийн 8.7 хувь байна. Гэтэл зах зээл дээр зарагдаж байгаа 21 дүгээр хороололд байрлалтай нэгэн үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ нь 55 сая төгрөг бөгөөд сарын 700 мянгаас нэг сая хүртэл төгрөгөөр түрээслэх боломжтой байгаа. Энэ нь хөрөнгө оруулалтын өгөөж даруй 16.3- 24 хувь байна гэсэн үг юм.

Өгөөжийн энэхүү зөрүү үүсэхэд орон сууцны ипотектийн зээл нь үйлчилгээний үл хөдлөх хөрөнгөтэй харьцуулбал олдоц сайтай, илүү хөрвөх чадвартай буюу богино хугацаанд түрээслэгчээ олдог, мөн иргэдийн дунд өөрийн өмчилсөн орон сууцанд амьдрах сэтгэл зүйн ханамж өндөр байдаг зэрэг нь үүрэг гүйцэтгэж байгаа. Гэхдээ эдгээр нь хангалттай тайлбар болж чадахгүй болов уу. Өөр нэг шалтгаан нь орон сууц өмчилснөөр нийгэм, эдийн засгийн ямарваа нэг цочрол өөрчлөлт, тухайлбал энэ удаагийнх шиг хямралын эсрэг амьдралын баталгаа болно гэж олонх хүмүүс үздэг явдал байж болно.

- <sup>1</sup> Үл хөдлөх хөрөнгийн "Mongolian Properties" компани нь ([www.mongolia-properties.com](http://www.mongolia-properties.com)) хуучин орон сууцыг "ягаан барилгууд", "гулаг цамхаг", шинэ орон сууцыг "тоглоомын талбай дахь барилгууд", "тансаг зэрэглэлийн барилгууд", "шинэ давалгаа" хэмээн ангилжээ.
- <sup>2</sup> Үл хөдлөх хөрөнгө зуучлалын Осмо компанийн сайт ([www.osmo.mn](http://www.osmo.mn))
- <sup>3</sup> Үл хөдлөх хөрөнгийн "Тэнхлэг зууч" сэтгүүл
- <sup>4</sup> Үл хөдлөх хөрөнгө зуучлалын Осмо компанийн сайт ([www.osmo.mn](http://www.osmo.mn))

15 "Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын Монголын эдийн засагт үзүүлж буй нөлөө", хоёрдугаар улирлын тайлан, 2009 он

## 4.2. Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдаа нь хямралд гүнзгий өртөж байгаа салбаруудын нэг юм. 2008 оны сүүлийн улирлаас эхлэн экспорт, импортын хэмжээ эрс буурч ирсэн байдал энэ оны гуравдугаар улиралд үргэлжилсээр байна. 2009 оны гуравдугаар улирлын экспортын хэмжээг өмнөх оны тухайн саруудтай харьцуулахад 17-26 хувиар, импорт 32-45 хувиар буурсан байгаа нь Хүснэгт 4.1-ээс харагдаж байна.


Хүснэгт 4.1. Гадаад худалдааны өөрчлөлт, хувиар (өмнөх оны мөн үетэй харьцуулахад)

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар
Экспорт	-21.3	-71.0	-38.6	-21.3	-71.0	-38.6	-17.0	-23.6	-26.0
Импорт	-40.0	-51.0	-24.3	-40.0	-51.0	-24.3	-44.8	-40.0	-32.0

Эх сурвалж: УСХ, 2009 оны 9 дүгээр сарын бюллетень

2009 оны эхний улирлын турш экспортын хэмжээний уналт нь импортын уналтаас их байсан бол гуравдугаар улиралд импортын уналт нь экспортынхоос илүү их байна. Үүний үр дүнд гадаад худалдааны алдагдал энэ улиралд багассан байна. 2009 оны гуравдугаар улирлын экспортын нийт хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 157 сая ам. доллараар буюу 23 хувиар, импорт 432 сая ам. доллараар буюу 46 хувиар буурсан байна. Харин сар сараар нь авч үзвэл Зураг 4.2-оос харахад нэгдүгээр улирлын туршид экспорт, импортын хэмжээ огцом ихээр унаж байсан бол хоёрдугаар улирлын туршид экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэж ирсэн. Харин энэ улирлын туршид экспорт болон импортын хэмжээ аажмаар үргэлжлэн нэмэгдэж, эхний таван сарын хугацаанд байсан түвшнээс давж гарсан байна. Ялангуяа 2009 оны 9 дүгээр сард гадаад худалдааны эргэлт он гарсаар хамгийн өндөр түвшиндээ хүрчээ.

Зураг 4.2. Экспорт ба импортын хэмжээ, 2009 оны эхний 9 сард, сая ам. доллар



Эх сурвалж: УСХ, 2009 оны 9 дүгээр сарын бюллетень


2009 оны гуравдугаар улиралд алт, зэсийн баяжмал, молибдений хүдэр ба баяжмал, ноолуур, нүүрс, төмрийн хүдрийн экспорт нэмэгдсэн байна. Молибдений хүдэр ба баяжмал, төмрийн хүдрийн экспорт хоёрдугаар улиралд тус бүр 70 ба 40 хувиар өссөн байсан нь гуравдугаар улиралд мөн адил давтагдаж байна. Харин жоншны хүдэр ба баяжмал 60 хувиар, тунгаасан зэс ба хайлш 24 хувиар, цайрын баяжмал 13 хувиар тус тус буурсан байна. Энэ оны 6-7 дугаар саруудад алтны экспорт огт хийгдээгүй бол 8-9 дүгээр саруудад нийт 2.8 тонн алт экспортод гарчээ. Он гараад эхний есөн сард гаргасан бохир ноолуурын экспортын хэмжээ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 53 хувиар, үнийн дүн нь 34 хувиар нэмэгдсэн байна. 2009 оны 5 дугаар сард бохир ноолуурын экспортын татварыг тэглэсэн нь экспортыг ийнхүү өсгөсөн. Харин самнасан ноолуурын экспортын хэмжээ 9.5 хувиар өссөн байхад үнийн дүн нь 28 хувиар буурсан байгаа нь ноолуурын бүтээгдэхүүний дэлхийн эрэлт буурсантай холбоотой гэж үзэж байна. 2009 оны гуравдугаар улирлын экспортын нийт хэмжээг өмнөх оны мөн улиралтай харьцуулахад үхэр, адууны мах, арьс ширний экспорт нэмэгдсэн байна.

2009 оны гуравдугаар улиралд мөн оны эхтэй харьцуулахад нийт экспорт аажмаар өссөн нь зэсийн баяжмал, алт, молибдений хүдэр ба баяжмал, төмрийн хүдэр, махны экспорт өсч, зарим барааны дэлхийн үнэ аажмаар нэмэгдсэнтэй холбоотой байна. Тухайлбал, 2009 оны 12 дугаар сард нэг тонн нь 2,600 ам. доллар болтлоо буурсан зэсийн үнэ 2009 оны 9 сард дунджаар 6,195 ам. доллар болтлоо өссөн нь гуравдугаар улиралд нийт экспорт өсөхөд нөлөөллөө. Мөн улирлын чанартай нэмэгддэг ноолуурын экспорт энд хувь нэмрээ оруулсан нь дамжиггүй. Нөгөө талаас, Монголын зэсийн гол экспортлогч Хятадын эдийн засгийн байдал аажмаар сайжран, эрэлт өсч байгаатай холбоотой гэж үзэж байна. 2009 оны 8 дугаар сарын байдлаар Хятадын ДНБ-ий өсөлт 12.3 хувьд хүрсэн байна. Зэсийн хамгийн том хэрэглэгч Хятад улс зэсийн баяжмалын импортын 17 хувийн болон цэвэршүүлсэн зэсийн экспортын 10 хувийн татваруудаа тэглэсэн нь манай зэсийн экспортод эерэг нөлөө үзүүлжээ.

2009 оны гуравдугаар улирлын туршид бензин болон дизель түлшний импорт өссөн байна. Мөн эхний хоёр улиралд багасаад байсан хүнсний гол бараа болох гурил, цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосны импорт ихээхэн нэмэгдсэн байна. Түүнчлэн компьютер, гэр ахуйн цахилгаан бараа, суудлын болон ачааны автомашины импорт нэмэгджээ. Харин орлогын мэдрэмж сайтай буюу орлого буурангуут эрэлт нь буурдаг бараа болох алт мөнгөн эдлэлийн импорт буурсан хэвээр байна. Үнийн болон орлогын мэдрэмж муутай бараа болох эмийн импорт 2009 оны 6 дугаар сартай харьцуулахад өссөн байна. Түүнчлэн химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн импорт буурсан нь шинээр хөрөнгө оруулалт хийгдэхгүй байгаатай холбоотой гэж үзэж болно.

Хүнсний гол барааны импорт нэмэгдсэн нь хэрэглэгчдийн эрэлт аажмаар өсч байгааг харуулж байгаа бол үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмжийн импорт буурсан хэвээр байгаа нь дотоодын үйлдвэрлэгчдийн эрэлт нийтдээ сайжрахгүй байгаатай холбоотой. Гуравдугаар улирлын туршид импортын хэмжээ аажмаар өссөн хоёрдахь шалтгааныг авч үзвэл 2009 оны гуравдугаар улиралд өмнөх оны мөн үетэй, ялангуяа оны эхэн үетэй харьцуулахад ам. доллартай харьцах төгрөгийн ханш чангарсан тул манай улсын хувьд гадаадаас худалдан авах бараа үйлчилгээ хямд болсонтой

Зураг 4.3 Гадаад худалдааны тэнцэл, сая ам. доллар.



Эх сурвалж: Монгол Банкны 9 дүгээр сарын статистикийн мэдээлэл

холбоотой. Зүйрлэж хэлбэл 1 ам. долларын үнэтэй ундааг 2009 оны 6 дугаар сард 1,446 төгрөгөөр авч байсан бол 9 дүгээр сард 1426 төгрөгөөр авах болж байна гэсэн үг. Тиймээс нийт импорт өсч байгаа шалтгаан нь нэгдүгээрт, хэрэглэгчдийн эрэлт аажмаар өсч байгаа, хоёрдугаарт, төгрөгийн ханш чангарснаар тайлбарлагдаж байна.

2009 оны гуравдугаар улирлын эцсээр худалдааны тэнцэл 190.5 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын уналт нь экспортынхоос илүү их байсан тул гадаад худалдааны алдагдал ийнхүү бараг дөрөв дахин багассан байна. Хямралын нэг эерэг нөлөө бол гадаад худалдааны алдагдал багасч буй явдал юм.

Хямралын нэг эерэг нөлөө бол гадаад худалдааны алдагдал багасч буй явдал юм. ҮСХ-ны мэдээлснээр гаалийн татварын орлого 2008 оны эхний есөн сард нийтдээ 114 тэрбум төгрөг байсан бол энэ оны эхний есөн сарын турш 84 тэрбум төгрөг болж 30 тэрбум төгрөг буюу 26 хувиар буурчээ. Импортоор оруулдаг бензин, дизель түлш, архи, тамхи, пиво, машинаас авах онцгой албан татварын орлого 2008 оны гуравдугаар улирлын эцэст нийтдээ 124 тэрбум төгрөг байсан бол 2009 оны гуравдугаар улирлын эцэст 115 тэрбум төгрөг болж даруй есөн тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийтдээ 2009 оны гуравдугаар улирлын байдлаар гаалийн болон онцгой албан татварын орлого өмнөх оны мөн үеийнхээс 39 тэрбум төгрөгөөр буурсан нь өмнөх улиралд хүлээсэн 12 тэрбум төгрөгийн алдагдлаас даруй гурав дахин их байна.

Хямралын Монголын эдийн засагт нөлөөлж байгаа гол суваг гадаад худалдаа хэвээр байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2009 оны гуравдугаар улирлын экспорт, импортын нийт хэмжээ үлэмж буурсан хэвээр байна. Харин энэ оны эхэн үетэй харьцуулахад 9 дүгээр сард экспортын болон импортын хэмжээ аажмаар нэмэгдэн эхний таван сарын хугацаанд байсан түвшнээс давж байгаа нь улирлын шинж чанартай эдийн засгийн идэвхжил байсан гэж үзэж байна. Он гарсаар эерэг өөрчлөлт гарч байгаа хэдий ч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад худалдааны салбарт хямрал үргэлжилсээр байна.



### 4.3. Макро эдийн засгийн бодлого

#### **Банк, санхүүгийн салбар ба мөнгөний бодлого**

Өнөөдөр хамгийн хүндрэлтэй байгаа салбар бол яах аргагүй банк, санхүүгийн салбар юм. Учир нь өнөөдрийн байдлаар банкуудын нийт олгосон зээлийн 22.6 хувь нь чанаргүй болоод хугацаа хэтэрсэн зээлээс бүрдэж байна. Өөрөөр хэлбэл, банкуудын олгосон зээлийн 100 төгрөг тутамын 22 төгрөг нь хугацаа хэтрээд явж байна. Хэдийгээр эдгээр зээлийн зарим хэсэг нь буцааж төлөгдөх магадлалтай ч банкуудыг эрсдэлд оруулсаар байна.

2009 оны гуравдугаар улиралд Монголбанкнаас мөнгөний бодлогын талаар баримталж буй бодлогод тодорхой өөрчлөлт гарч бодлогын хэд хэдэн арга хэмжээ авсан. Юуны өмнө мөнгөний бодлогын гол зорилго болох инфляцийн түвшин 2009 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар оны эхнээс 2.6 хувь, сүүлийн 12 сарын байдлаар -1.9 хувьтай гарсан нь мөнгөний бодлого үндсэн зорилтоо биелүүлж байгаа дүр зураг харагдаж байна. Тухайлбал, суурь инфляцийн түвшин оны эхнээс 4.1 хувь байгаа нь инфляци тогтворжих эхний шинж тэмдэг ажиглагдаж эхэллээ гэдгийг харуулж байна. Тайлант жилд инфляцийн түвшинг 10 хувиас бага байлгах зорилтыг Монголбанк тавьж, энэхүү зорилтдоо тохирсон мөнгөний нийлүүлэлтийн бодлогыг авч хэрэгжүүлэхийг зорьж байгаа билээ.

Хямрал Монголын эдийн засагт нөлөөлж эхэлснээс хойших хугацаанд авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийг тоймлон авч үзье. 2008 онд инфляцийн түвшин дунджаар 26.7 хувьд хүрч, оны эцэс гэхэд гадаад худалдааны алдагдал 1 тэрбум гаруй ам. доллар, төсвийн алдагдал 305 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 орчим хувьтай тэнцсэн. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн тогтворгүй байдал даамжирсан байдалтай байжээ. Энэ үед манай бодлого боловсруулагчид мөнгөний болон төсөв, сангийн бодлогын амаргүй сонголтуудыг хийх ёстой болсон. Бид энэ талаар өмнөх улирлын тайлангуудад тодорхой дурьдсан.

Монголбанк үндсэндээ хоёр томоохон сонголттой тулгарчээ. Нэгдүгээрт, инфляцийг бууруулахын тулд мөнгөний хатуу бодлого явуулах шаардлагатай болсон. Гэтэл, мөнгөний хатуу бодлого нь эдийн засгийн нийт эрэлтийг хумих учраас бодит үйлдвэрлэл, үйлчилгээг зогсонги байдалд оруулах, бууруулах сөрөг талтай. Өөрөөр хэлбэл, үнийн өсөлтийг хязгаарлаж бодит үйлдвэрлэлийг зогсонги байдалд оруулах бодлого баримтлах уу эсвэл мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлэн явуулж, инфляцийг цаашид хөөрөгдөх эрсдлийг бий болгох уу гэдэг сонголттой тулгарсан.

Манай орны хувьд зах зээлд суурилсан эдийн засгийн тогтолцоонд шилжээд харьцангуй бага хугацаа туулж байгаа учраас энэхүү бодлогын суурь сонголтын чухлыг тэр бүр ойлгохгүй байна. Тухайлбал, мөнгөний бодлогоо зөөллөж зээлийн хэмжээг өсгөх замаар эдийн засгаа өсгөнө гэж олон хүн хэлдэг хэдий ч яг энэ бодлого нь үнийн өсөлтийг бий болгоно гэдгийг тэр болгон хэлдэггүй, ярьдаггүй, бичдэггүй. Бид өмнөх тайландаа энэ сонголтын талаар бичсэн хэдий ч энэ удаад дахиад давтах нь зүйтэй гэж үзлээ. Чухам яагаад энэхүү сонголтын талаар олон нийтэд ийнхүү дутуу дулимаг мэдээлэл хүрч байна вэ гэхээр банкууд, компаниуд, үйлдвэрлэгчид хямд, олдоц сайтай зээлийн эх үүсвэрийг байнга хүсч байдаг. Тийм ч учраас, мөнгөний зөөлөн бодлогыг ямагт илүүд үздэг гэж хэлж болно. Харин мөнгөний хэт зөөлөн


бодлогын үр дагавар нь инфляци бөгөөд өндөр инфляци олон нийтэд хамгийн хүндээр тусдаг. Ялангуяа, нийгмийн эмзэг бүлгийн бодит орлогыг огцом бууруулдаг. Инфляци нь иргэдийн орлогод ногдуулж буй нэг ёсны татвар. Инфляцийн түвшин өндөр байх тусам энэхүү татварын хувь өндөр байна гэсэн үг. Тиймээс төв банк энэхүү олон нийтийн эрх ашгийг ямар нэг байгууллага, бүлэглэлийн ашиг сонирхлоос хамгаалж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахаар байгуулагдсан байгууллага гэдэг ойлголтыг хэвшүүлэх шаардлагатай.

Нэгэнт инфляцийн түвшин өндөр болж, бодит үйлдвэрлэл, үйлчилгээ зогсонги байдалд орсон үед хатуу мөнгөний бодлого баримтална гэдэг нь бодит үйлдвэрлэл, үйлчилгээг улам зогсонги байдалд оруулж, улмаар эдийн засгийн уналтыг бий болгох магадлалтай бодлогын сонголт хийжээ гэж шууд ойлгож болно. Өөрөөр хэлбэл, үнийн өсөлтийг хязгаарлах замаар макро эдийн засгийн тогтворжилтыг эхлүүлэх нь нэн тэргүүний зорилт байжээ.

Мөнгөний нийлүүлэлтийг бууруулахдаа Монголбанк үнэт цаасаа банкуудад худалдсан. Банкуудад хангалттай хэмжээний төв банкны үнэт цаас худалдах замаар мөнгөний нийлүүлэлтийг хумихын тулд бодлогын хүү буюу 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүгээ өсгөсөн. Дээрх зурагт бодлогын хүү, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, суурь болоод энгийн инфляцийг сүүлийн 12 сарын байдлаар харууллаа.

Дээрх зургаас (Зураг 4.3) харахад Монголбанк бодлогын хүүгээ 2009 оны 3 дугаар сард 5 пунктээр өсгөж мөнгөний нийлүүлэлтийг бууруулах арга хэмжээ авсан. Үүнээс өмнө, гадаад валютын зах зээл дээр валютын нөөцөөсөө худалдах замаар мөнгөний нийлүүлэлтийг бууруулах арга хэмжээг 2008 оны 9 дүгээр сараас хойш авч хэрэгжүүлж байсан юм. 2009 оны 5 дугаар сараас хойш инфляцийн түвшин нэг оронтой тоонд орж ирсэн учраас мөнгөний хатуу

Зураг 4.3. Бодлогын хүү, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, суурь ба энгийн инфляци



Эх сурвалж: Монголбанк

бодлогоо сулруулах эхний алхамыг Монголбанк авч хэрэгжүүлсэн. Хамгийн сүүлд, 9 дүгээр сард Монголбанк бодлогын хүүгээ 1.5 пунктээр огцом бууруулж өнөөгийн байдлаар 10 хувьд хүргээд байна.


Тайлант оны эцэс гэхэд инфляцийн түвшин зорилтот түвшиндээ байх нь макро эдийн засгийн тогтворжилтын эхний томоохон шинж тэмдэг болох нь гарцаагүй. Гагцхүү, энэхүү өндөр үнээр олж авсан тогтворжилтыг амархан алдахгүй байх нь хамгаас чухал. Тухайлбал, мөнгөний бодлогоо хугацаа нь болоогүй байхад сулруулах нь инфляцийг бий болгох магадлалтай гэдгийг ойлгох нь зүйтэй болов уу. Зарим эдийн засагчид, бодлого боловсруулагчид бодлогын хүүг бууруулах ёстой гэж үзэж байгаа. Хэдийгээр мөнгөний нийлүүлэлтийг өсгөх нь банкуудаас олгох зээлийн олдцыг бий болгож болох ч эдгээр хүмүүс инфляцийн үр дагаврыг нь тэр бүр ойлгохгүй, ойлгосон нэг нь хайхрамжгүй хандаж байх шиг санагдана. Нөгөөтэйгүүр, 9 дүгээр сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 16.8 хувиар өсөөд байгаа нь мөнгөний бодлого тийм ч хатуу биш байгааг харуулж байна.

Манай орны хувьд сүүлийн жилүүдэд эдийн засгийн мөчлөг дагасан мөнгөний бодлого явуулсан учраас өндөр инфляцид нэрвэгдсэн гэж бид өмнөх тайлангуудад тайлбарласан. Түүгээр ч үл барам, сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогыг харахад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг ихээхэн дэмжсэн, мөнгөний тэлэлтийг байнга хийдэг тогтолцоотой болсон талаар бид “Санхүүгийн зах зээлийн эхний хагас жилийн тайлан”-даа дурьдсан. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын гол зорилго болох инфляцийн түвшинг тэр бүр хайхраагүй дүр зураг харагдаж байна. Тийм ч учраас энэхүү туйлшрамтгай, эдийн засгийн мөчлөг дагасан бодлогын тогтолцоог эвдэх цаг аль хэдийнэ ирсэн гэж үзэж байна.

Энэ бүхнээс дүгнэхэд мөнгөний бодлого гол зорилгоо биелүүлж эхэлж байгаа хэдий ч энэхүү ололтоо бататгаж мөнгөний бодлогоо цагаас нь өмнө огцом зөөлрүүлэхгүй байх, дунд хугацаандаа инфляцийг бага түвшинд, тогтвортой байлгахад чиглүүлэх нь зүйтэй санагдаж байна. Монголбанк бодлогын хүүгээ инфляцийн түвшин, түүний талаарх хүлээлтийг харж байж бууруулах, аливаа нэг ашиг сонирхлоос хараат бус байдлаа хадгалж байх нь хамгийн чухал. ОУВС-ийн Мөнгөний ба хөрөнгийн зах зээлийн газрын захирал Хосе Виналс мөнгөний бодлогын гол зорилго нь үнийн өсөлтийг бага байлгахад оршдог учраас төв банкны хараат бус байдлыг хадгалах нь хамгаас чухал гэж онцолсон нь бидэнд сургамжтай мэт санагдаж байна.

Инфляцийн түвшин буурсны нэг томоохон ач холбогдол нь бодит хүү өсч байгаа явдал. Учир нь инфляцийн түвшин дунд хугацаандаа бага түвшинд тогтвортой байж, бодит хүүг өндөр байлгах нь яваандаа зээлийн нэрлэсэн хүү буурах угтвар нөхцөл болж өгнө. Өнөөгийн байдлаар төгрөгийн зээлийн хүү дунджаар жилийн 22.2 хувьтай байгаа нь өндөр үзүүлэлт. Төгрөгийн бодит хадгаламжийн хүү өнөөгийнх шиг өндөр байх тусам хүмүүст төгрөгийн хадгаламжаа өсгөх сонирхлыг бий болгоно. Хүмүүсийн хадгалах сонирхол өсч, хадгаламж нэмэгдэхийн хэрээр банкууд хөрөнгийн эх үүсвэрээ хямд зардлаар (хадгаламжийн хүүгээ бууруулж) төвлөрүүлэх боломжтой болж, улмаар банкууд хоорондоо өрсөлдөх замаар зээлийн нэрлэсэн хүүг бууруулах боломжтой. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн хямд эх үүсвэр төвлөрүүлсэн банкууд хоорондоо зээлийн хүүгээрээ өрсөлдөх юм. Энэ бол зээлийн хүүг зах зээлийн тогтолцоонд суурилуулан бууруулах гол арга, хөшүүрэг гэж үзэж байна. Тийм ч учраас инфляцийн түвшин бага байх нь маш чухал.

Зураг 4.4. Хадгаламжийн ба зээлийн бодит хүүгийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

Зарим бодлого боловсруулагчид зээлийн хүүг бууруулахын тулд бодлогын хүүг бууруулах, эсвэл банкуудын нэгдлээр дамжуулан өрсөлдөөнийг бий болгож, зээлийн хүүг бууруулах талаар ярьж байна. Бидний үзэж байгаагаар инфляцийн түвшин бага байх нь хадгаламж болоод зээлийн хүүг бууруулах гол хөшүүрэг нь юм. Харин, инфляцийн түвшин өндөр байх үед төгрөгийн бодит хүү буурах бөгөөд хүмүүс төгрөгийн хадгаламж хийх сонирхол буурна. Энэ нь зээлийн нэрлэсэн хүүг бууруулах боломж муутай болно гэсэн үг. Өнөөгийн байдлаар зээлийн болоод хадгаламжийн нэрлэсэн хүү өндөр байгаа хэд хэдэн шалтгаан байгаа. Инфляци бол зөвхөн нэг шалтгаан нь гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй. Банк хоорондын өрсөлдөөн, банкуудын олгож буй зээлийн багцын эрсдэл, валютын ханшны хэлбэлзэл, хүмүүсийн хүлээлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлөх боломжтой.

Монголбанкны өмнө тулгарсан өөр нэг сонголт нь валютын ханшны талаар баримтлах бодлого юм. Валютын ханшны бодлого нь олон нийтийг, пүүс компаниудыг, банкуудыг төөрөгдөлд оруулж байгаа талаар бид өмнөх улирлынхаа болоод “Санхүүгийн зах зээлийн тайлан”-д дурьдсан. Өнөөг хүртэл явж ирсэн түгээмэл төөрөгдөл бол манай улс валютын ханшны чухам ямар тогтолцоог сонгож байгаа нь тодорхойгүй байгаад оршиж байна. Манай улс зохицуулалттай, чөлөөт хөрвөдөг тогтолцоотой гэх боловч чухам ямар үед гадаад валютын зах зээлд Монголбанкнаас зохицуулалт хийж байгаа нь тэр бүр тодорхой биш байна. Өөрөөр хэлбэл, валютын ханшны зохицуулалт нь мөнгөний бодлогоосоо урьтаж төгрөгийн нийлүүлэлтийг зохицуулж байгаа нь Монголбанкны гол зорилгоос хазайсан үйлдэл болсон гэж ойлгогдохоор байна. Нөгөөтэйгүүр, валютын ханшны хэлбэлзлийн улмаас 2008 оны 9 дүгээр сараас 2009 оны 3 дугаар сарын хооронд 0.6 тэрбум орчим ам.долларыг валютын ханшийг зохицуулах зорилгоор зарсан явдал нь улсын валютын нөөцийг маш бага түвшинд хүргэсэн төдийгүй, төгрөгийн ханшийг иймэрхүү байдлаар барих чадамж, нөөц Монголбанкинд байхгүйг тодоор харуулсан. Тийм ч учраас дараагийн алхам болох бодлогын хүүгээ өсгөхөөс өөр аргагүйд хүрсэн.

2009 оны 9 дүгээр сарын байдлаар гадаад валютын нөөц 1.1 тэрбум ам.доллар байна. Тайлант оны 3 дугаар сард гадаад валютын нөөц 0.5 тэрбум долларт хүрч доод хэмжээндээ очсон бол түүнээс хойш Монголбанк алт худалдах, валютын дуудлагын арилжаагаар дотоодоосоо валют худалдан авах, олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл зэрэг эх үүсвэрүүдээр гадаад валютын нөөцөө зузаатгажээ. Жил бүрийн намар алт олборлолт дуусч, алт тушаагдсанаар гадаад валютын урсгал манай орон руу орж ирэх зүй тогтол ажиглагддаг. Өмнөх жилүүдийн энэ үед Монголбанк ихэвчлэн алт худалдан авч валютын нөөцөө зузаатгаж, оронд нь төгрөгийг эдийн засагт нийлүүлдэг байсан. Өөрөөр хэлбэл, жил бүрийн намар мөнгөний нийлүүлэлт өсдөг зүй тогтол ажиглагдсаар ирсэн. Энэ жилийн хувьд алт худалдан авалт ихэвчлэн Монголбанкнаас гадуур хийгдэж байгаа ч Монголбанк иргэд, байгууллагаас гадаад валют худалдан авч, валютынхаа нөөцийг зузаатгаж, оронд нь төгрөгийн нийлүүлэлтийг өсгөх үйл явц ажиглагдаж байна. Тэгэхээр, бодлогын хүүгээ бууруулж, валютын арилжаагаараа дамжуулан төгрөгийн нийлүүлэлтийг ийнхүү өсгөж байгаа нь мөнгөний зөөлөн бодлого аль хэдийнэ эхэлжээ гэж харагдахаар байна гэдгийн дахин тэмдэглүүштэй.

Цаашид, санхүү, эдийн засгийн хямрал нэгээр дуусахгүй тул валютын ханшны талаарх бодлогоо тодорхой болгох шаардлагатай байна. Гадаад валютын хангалттай нөөцтэй тохиолдолд валютын тогтмол ханшны тогтолцоог сонгож болох юм. Харин, хангалттай нөөц байхгүй өнөөгийнх шиг тохиолдолд валютын ханшны зохицуулалтад ийнхүү идэвхийлэн оролцох нь ойлгомжгүй байдлыг үүсгээд байгааг анхаарах хэрэгтэй.

Сүүлийн үед банк санхүүгийн салбарт хэд хэдэн тулгамдсан асуудлууд үүсээд байна. Хамгийн түрүүнд дээр дурьдсан чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзэлж буй хувийн жин өсч байгаа явдал. Энэ нь банк санхүүгийн салбарыг бүхэлд нь хүндрэлд оруулж байгаа бөгөөд Анод банк он гарсаар Монголбанкнаас томилогдсон бүрэн эрхт төлөөлөгчийн удирдлагад ороод байна. Тус банкны хувь нийлүүлэгчдийн томилсон удирдлага буруу, хариуцлагагүй шийдвэрүүд удаа дараа гаргаж банкаа үндсэндээ дампууруулаад байгаа нь хувь нийлүүлэгчдийн хувьд хүнд тусч байгаа. Гэхдээ, хариуцлагыг эдгээр хувь нийлүүлэгчид үүрэхээс өөр гарц байхгүй мэт санагдаж байна. Монголбанкнаас явуулдаг хяналт шалгалтад дутагдалтай, анзааргагүй өнгөрсөн зүйлүүд байгаа ч эцсийн эцэст хувь нийлүүлэгчид, банкны удирдлагууд л хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг эрсдэлд оруулсан. Цаашилбал, манай улсын банк санхүүгийн тогтвортой байдлыг эрсдэлд оруулаад байна. Банк, санхүүгийн салбар бол олон нийтийн итгэлцлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг гэдгийг хүн бүр мэдэж байгаа.

Монголбанкны мэдээлж байгаагаар Анод банкинд бүрэн эрхт төлөөлөгч томилогдох үед зөвхөн гадаад тооцооны будлианаас 58.6 тэрбум төгрөгийн зөрүү бичилт илрээд байна. Энэ хэмжээний хөрөнгө хаашаа, ямар замаар алга болсон нь тодорхойгүй гэсэн үг. Уг банк 37 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй гэж тус банкны тэнцэл дээр харагдаж байна. Өөрөөр хэлбэл, тус банкинд оруулсан хөрөнгөөсөө их хэмжээний мөнгийг дээрх гадаад тооцоогоор банкны удирдлагууд “алдсан”. Түүгээр ч үл барам дотоод зээлдэгчиддээ олгосон зээлүүд нь эрсдэлд ороод байна. Монголбанкны мэдээлж байгаагаар 40 том зээлдэгчиддээ олгосон 125.5 тэрбум төгрөгийн зээлийн 123 тэрбум төгрөг нь чанаргүй зээл болжээ.

Энэ бүхнээс дүгнэхэд манай банк, санхүүгийн салбарт өнөөгийнхөөс илүү чанартай хяналт шалгалтын тогтолцоо хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Анод банкны хадгаламж эзэмшигчдийн мөнгийг төр хариуцсан. Тийм ч учраас Монголбанкнаас 129 тэрбум төгрөгийн зээл олгоод байгаа. Төр хариуцна гэдгийн ард татвар төлөгчдийн мөнгө байгаа гэдгийг хатуу ойлгох хэрэгтэй юм. Татвар төлөгчид энэхүү 129 тэрбум төгрөгөө эргүүлж олж авах найдвар хэр байгаа вэ?

Эдийн засгийн ухаанд ёс суртахууны эрсдэл (*moral hazard*) гэдэг ойлголт байдаг. Энэ нь зээлдэгч эсвэл ямар нэг төсөл хэрэгжүүлэгч зээлээр авсан санхүүгийн хөрөнгөө зориулалтын бус, өндөр эрсдэлтэй төсөлд зарцуулах эрсдлийг хэлдэг. Анод банкны тохиолдолд тус банк иргэдээс хадгаламжийг нь авчихаад эрсдэл ихтэй үйл ажиллагаанууд явуулсан гэсэн үг юм. Тэгвэл иймэрхүү эрсдлээс банк санхүүгийн тогтолцоог цаашид хэрхэн илүү сайн хамгаалах вэ? Энэ бол тун амаргүй асуулт гэдэг нь тодорхой байна.

Шилжилтийн эдийн засгийн үед манай орны банк санхүүгийн тогтолцоо хэд хэдэн хямралыг даван туулсан. Энэ хугацаанд Төв Ази, ХОТШ, Ардын банк, Сэргээн босголт зэрэг олон банкууд дампуурсан, хаагдсан бөгөөд тохиолдол бүрт төрөөс алдагдлыг нь дааж байсан. Хамгийн сүүлд олон тооны хадгаламж зээлийн хоршоод дампуурахад хүртэл төрөөс хэсэгчлэн алдагдлыг нь даасан. Энэ бүх бодлогын шийдлүүд ёс суртахууны эрсдлийг улам дэвэргэж байгаа нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл, банкууд хүндрэлд орох тоолонд төрөөс ийнхүү бүх алдагдлыг дааж байгаа нь банкуудын удирдлагыг эрсдэл өндөртэй үйлдэл хийхэд хүргэж байж болзошгүй юм.

Өнөөгийн дэлхийн санхүүгийн хямрал чухам энэ төрлийн эрсдлээс болж эхэлсэн. АНУ-ын банкууд эрсдэл ихтэй төслүүд рүү хошуурсан нь хямралыг бий болгожээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралыг эхлүүлсэн хөнгөлөлттэй нөхцлөөр олгогдсон үл хөдлөх хөрөнгийн санхүүжилт нь эрсдэл өндөртэй үйл ажиллагаа байсан. Тийм ч учраас АНУ-ын төр захиргаа шүүмжлэлд ихээхэн өртөөд байгаа. Ийм төрлийн эрсдлээс цаашид банк, санхүүгийн тогтолцоогоо хамгаалах арга замаа өнөөг хүртэл ярьж, хэлэлцсээр байна. Харамсалтай нь энэхүү асуудлыг шийдвэрлэх нэгдсэн жор байхгүй.

Манай орны хувьд чухам ямар хяналтын тогтолцоо бий болговол нэг талаас банк санхүүгийн найдвартай үйл ажиллагааг илүү сайн хангаж чадах вэ, нөгөө талаас иймэрхүү хүндрэлд орох тоолонд татвар төлөгчдийн мөнгөөр гал унтраасаар байх уу гэдэг асуулт гарч байна. Хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгож, сайжруулж түүнтэйгээ банкны хяналт шалгалтын тогтолцоог уялдуулах арга зам байж болохыг бид өмнө нь санал болгосон. Өөрөөр хэлбэл, банкуудын сар, улирал, жилийн хяналт шалгалтыг хадгаламжийг даатгагч байгууллага өөрөө хийдэг байх нь зүйтэй санагдаж байна. Энэ бол дээр дурьдсан ёс суртахууны эрсдлийг бууруулж болох нэг арга зам юм.

Банк санхүүгийн салбарт гарсан нэг шинэ санаачлага бол Хөгжлийн банк байгуулах асуудал. Дэлхийн олон улс орон ийм санаачлагыг гаргаж байсан гэдгийг хүн бүр мэдэж байна. Зарим орнуудад үр дүнгээ өгсөн байхад бусад орнуудад тэр бүр амжилт олоогүй. Тэгвэл Хөгжлийн банк байгуулах бодит шалтгаан нь юу вэ гэдэг асуулт гарч байна. Аливаа нэг арилжааны банк ашгийн төлөө ажиллах ёстой. Тэгвэл Хөгжлийн банк одоо байгаа банкуудаас



ямар давуу талтай байх вэ? Өөрөөр хэлбэл, ямар давуу талаа ашиглаж байж ашигтай ажиллах вэ? Ирээдүйд бий болох томоохон төслүүдийг санхүүжүүлэх нөөц өнөөгийн банкуудад байхгүй гэсэн нэг тайлбар байгаа. Бидний үзэж байгаагаар Хөгжлийн банкинд ямар нэг онцлог давуу тал байхгүй бол одоо байгаа арилжааны банкуудад хөрөнгө оруулах замаар томоохон төслүүдийг санхүүжүүлэх бүрэн боломжтой. Энэ тохиолдолд шинэ банк байгуулж, удирдлага томилж, хөрөнгө зарцуулах шаардлага байхгүй, харин ч бэлэн дадлага, туршлагатай банкуудын хүний нөөц, тэдгээрийн дэд бүтцийг ашиглаж болно. Тэгвэл давуу тал нь юу байж болох вэ?

Эдийн засагчдын хэллэгээр өргөжилтийн үр өгөөжөөс давуу тал олж болох юм. Өөрөөр хэлбэл, бусад банкуудтай харьцуулахад хямд зардлаар зээл гаргах боломжтой. Гэтэл энэ тайлбарын сул тал нь төрөөс банкны удирдлагыг томилох тохиолдолд дээр дурьдсан ёс суртахууны эрсдлийг дагуулах болно. Тийм ч учраас энэ тал дээр анхаарч ашиг сонирхлуудыг зөв, зохистой хуваарилах шаардлага тавигдана. Өөрөөр хэлбэл, ашгийн төлөө ажилладаг хувийн банкуудад дотоод хяналт илүү сайн байх үндэслэл байгаа гэдгийг бодолцох учиртай. Харин, Хөгжлийн банк байгуулах нэг дорвитой давуу тал нь банкны секторт өрсөлдөөнийг улам эрчимжүүлэхэд оршино. Харьцангуй хямд эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх боломжтой. Хөгжлийн банк нь зээлийн хүүгээ доогуур тогтоож, салбарын хэмжээгээр өрсөлдөөнийг эрчимжүүлэх боломж илүүтэй юм. Өрсөлдөөн эрчимжвэл зээлийн хүү буурах, банкны үйлчилгээ олон нийтэд бага зардалтайгаар хүрэх, хүртээмж нь өсөх зэрэг эерэг нөлөөллийг бий болгоно.

Эцэст нь тэмдэглэхэд, өнөөг хүртэл бидний зорьж байгаа эдийн засгийн тогтолцоо нь хувийн өмчинд тулгуурласан, хувь хүний ашиг олох тэмүүллийг дэмжихэд чиглэгдэж байгаа. Төрийн нэртэй банк, компаниуд байгуулагдах тоолонд энэ зорилтоосоо буцаж байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй.

Банк, санхүүгийн салбарт гарсан өөр нэг үйл явц бол Монгол шуудан банк, Хадгаламж банк нэгдсэн явдал юм. Энэхүү нэгдсэн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь 36.9 тэрбум төгрөг болох бөгөөд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээгээрээ 174 тэрбум төгрөг буюу Монголдоо томоохон банк болохоор байна. Одоогийн байдлаар энэхүү шинэ банкны нийт банк, санхүүгийн системд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд эрт байна. Ер нь банкууд нийлэх нь хөгжингүй орнуудын санхүүгийн салбарт элбэг тохиолддог үзэгдэл. Банкууд хоорондоо нэгдсэнээр нэг талаас үйл ажиллагааныхаа зардлыг бууруулдаг, нөгөө талаас тус банкны үйл ажиллагааны цар хүрээ өсч, ашигт ажиллагаа нь дээшилдэг. Харин энэхүү нийлэх үзэгдэл түгээмэл болсон тохиолдолд өнөөгийн барууны орнуудад ажиглагдаад байгаа хэтэрхий том банкуудыг үүсгэх нөхцлийг бүрдүүлж магадгүй юм. Банкуудын системдээ эзлэх хувь хэмжээ ихсэх тусам тухайн банкинд бий болох хүндрэл нь нийт салбараа эрсдэлд оруулдаг гэдгийг өнөөгийн санхүү эдийн засгийн хямрал тод харуулсан.

Эдийн засгийн ухааны энэ жилийн Нобелийн шагналтны нэгээр Оливер Уильямсоныг тодруулсан. Энэ хүний эдийн засгийн ухаанд оруулсан хувь нэмэр бол бидний энд хэлэлцэж байгаа компаниуд ямар шалтгааны улмаас томордог талаар тайлбар өгсөнд оршино. Зохицуулалт талаас нь авч үзвэл компаниудын томрох үйл явц бол ашгаа нэмэгдүүлэх гэсэн үйл ажиллагаатай нь холбоотой тул шууд хэмжээнд нь зохицуулалт хийх арга хэмжээ үр ашиг

муутай гэж тэрээр тэмдэглэсэн байдаг. Харин тэдний ажиллаж буй орчинд зохицуулалт хийх нь илүү үр дүнтэй байж болох талаар анхааруулсан. Тэгвэл, манай банк санхүүгийн системд иймэрхүү банкуудын нэгдэх үйл явцаас гарах төрөл бүрийн эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд банкуудад тавьж буй хяналтын системийг нь сайжруулах, дотоод уялдаатай хяналтын бүтцийг бий болгох хэрэгтэй гэж ойлгож болно.

2010 онд төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг ид хэлэлцэж байна. Энэ үед өнөөгийн санхүү, эдийн засгийн хямралаас чухам ямар зүйлд суралцав, үүний үндсэн дээр ямар бодлогын арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй вэ, цаашид ийм төрлийн хямралаас Монголын банк санхүүгийн салбарыг хэрхэн хамгаалах талаар дээр дурьдсан зүйлүүдийг санамж болгон авч, бодлогодоо тусгаж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

### ***Засгийн газрын санхүү ба төсөв, сангийн бодлого***

Санхүү, эдийн засгийн хямралаас улбаалан Монгол улсын Засгийн газрын санхүүгийн байдалд нэлээд өөрчлөлт гараад байна. Тухайлбал, Засгийн газрын орлого 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 1.3 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Харин Засгийн газрын зарлага 1.6 их наяд төгрөг буюу өмнөх жилийн мөн үеийн түвшинд байна. Төсвийн алдагдал 332.5 тэрбум төгрөгтэй тэнцүү байгаа ба оны эцэс гэхэд зорилтот түвшин болох ДНБ-ий 5.8 хувь буюу 364 тэрбум төгрөгт барьж чадах эсэх нь тодорхойгүй байна.

Санхүү, эдийн засгийн хямралын үед төсөв, сангийн бодлогоор дамжуулан эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээг улс орнууд авч хэрэгжүүлдэг. Өмнөх улирлын тайлангуудад бид энэ талаар дэлгэрэнгүй дурьдсан байгаа. Гол санаа нь төсөв, сангийн бодлого эдийн засгийн мөчлөг дагасан биш харин сөрсөн байдалтай хэрэгжвэл эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад ихээхэн үүрэг гүйцэтгэдэгт оршиж байна.

Өнөөгийн байдлаар дэлхийн томоохон 20 улс орнууд нийтдээ 10.8 их наяд ам. доллартай тэнцэхүйц төсвийн тэлэлт хийгээд байна. Эдгээр улс орнуудын эдийн засаг, санхүүгийн харилцаа холбоо гүнзгийрч, өргөжиж байгаа нь ийнхүү нэгдмэл арга хэмжээ авахад хүргэж байгаа бөгөөд тухайн улс орнууд эдийн засгийн хямралын үед төсвийн тэлэлт хийх нөөц, бололцоогоо хадгалж үлдсэн нь бидэнд сургамжтай. Манай орны хувьд Засгийн газрын төсвийн орлого цөөн тооны эрдэс баялгийн экспортоос хэт хараат байдал нь эдийн засгийн хямралын үед төсвийн тэлэлтийг бий болгох боломжийг хязгаарласан. Тиймээс ирээдүйд бий болох ийм төрлийн санхүү, эдийн засгийн таагүй нөлөөллөөс эдийн засгаа хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудал гарч байна. Өөрөөр хэлбэл, хямралын үе тохиолоо гэхэд төсвийн тэлэлт хийх нөөц, бололцоотой байх ёстой. Өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн төсөв, сангийн бодлогыг харахад олдсоны хэрээр зарцуулж ирсэн дүр зураг харагдаж байгаа.

Эрдэс баялгаас хэт хараат манайх шиг орнуудын Засгийн газрын төсвийг эдийн засгийн мөчлөгөөс хамааралгүй болгох хэд хэдэн арга байдаг. Энэ тал дээр Норвеги, Чили, Ботсвана зэрэг орнууд нэлээд амжилттай ажиллаж байна. Хэдийгээр эдгээр орнуудад хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэрэгслүүд нь өөр өөрийн онцлогтой ч үндсэндээ нэг гол зарчим дээр суурилсан нь

тодорхой байна. Тэр нь юу вэ гэхээр ашигт малтмалаас орж ирж буй орлого нь үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай тул ашигт малтмалын үнэ өсөх үед хуримтлал бүрдүүлж, үнэ буурсан үед тэрхүү хуримтлуулсан нөөцөөсөө төсвийн алдагдлаа нөхөх замаар гадаад худалдааны тогтворгүй байдлаас эдийн засгаа сэргийлэхэд оршиж байна. Энэхүү зарчим нь хэлэхэд амархан ч хэрэгжүүлэхэд маш хэцүү гэдэг нь тодорхой. Учир нь эдгээр бүх арга хэмжээнүүд Засгийн газрын зарлагын хэт өсөлтийг хязгаарлахад чиглэгддэг. Тэгвэл улс төрчид, бодлого боловсруулагчид тэр бүр Засгийн газрын зарлагын өсөлтийг хязгаарлах сонирхол байдаггүй. Сүүлийн жилүүдийн туршлагыг харахад энэ зүй тогтол тодоор ажиглагдаж байгаа.

2004 оноос 2007 оны хооронд дэлхийн зах зээл дээрх манай гол экспортын бүтээгдэхүүнүүд болох алт, зэсийн үнэ 2-2.7 дахин өссөн байхад Засгийн газрын төсвийн орлого дагаад 2.6 дахин, төсвийн зарлага 2.3 дахин өссөн байх юм (Зураг 4.5). Энэхүү өсөлт зөвхөн гурван жилийн дотор ажиглагдсан бөгөөд ирээдүйд энэ хэмжээний гадаад валютын урсгал орж ирэхэд Засгийн газрын зарлагын өсөлтийг хязгаарлах тогтолцоо одоогоор байхгүй байна. 2008 оны эцсийн байдлаар Засгийн газрын зарлага ДНБ-ий 40 хувьтай тэнцүү байгаа нь эдийн засаг дахь төрийн оролцоо их байгааг харуулж байна. Цаашдаа энэ оролцоо ихсэх нь хувийн хөрөнгө оруулалтыг бууруулах сөрөг үр дагавартай тул Засгийн газрын хэрэглээний өсөлтийг аль болох хязгаарлах шаардлагатай.

Тэгвэл улс орнууд ямар зарчмын үндсэн дээр Засгийн газрын хэрэглээгээ хязгаарладаг вэ? Дээр дурьдсан Норвеги улс бол нефть экспортлогч орон. Тэд “Засгийн газрын тэтгэврийн сан” нэртэй хуримтлалын сан байгуулсан. Энэ санд нефтийн экспортоос олсон орлогоо хуримтлуулдаг бөгөөд шаардлага гарсан үед төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын төсөвт мөнгө шилжүүлдэг. Энэ орны төсөв, сангийн бодлогын гол зарчим нь Засгийн

Зураг 4.5. Зэсийн үнэ, Засгийн газрын орлого, зарлага, алдагдал



Эх сурвалж: Монголбанк

газрын “нефтийн бус бүтцийн алдагдал” энэ сангийн хөрөнгийн 4 хувиас хэтрэхгүй байхаар тогтоож өгсөн. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын зарлага нь хамгийн ихдээ нефтээс бусад салбараас орж ирж буй орлого болон дээрх төсвийн алдагдлаар тодорхойлогдох нь ээ. Ийнхүү, Засгийн газрын зарлагын өсөлтийг хязгаарлаж өгч байна гэсэн үг.

Өөр нэг жишээ бол Чили улсын төсвийн тогтолцоо юм. Энэ улсын нийт экспортын 42.5 хувь, ДНБ-ий 22 орчим хувийг зэсийн үйлдвэрлэл эзэлдэг. Тиймээс энэ орны эдийн засаг, Засгийн газрын төсөв нь зэсийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий болох нь тодорхой байна. Энэхүү эрсдлээс сэргийлэхийн тулд төсвийн “бүтцийн илүүдэл”-ийг ДНБ-ий 0.5 хувьд барьж байхаар зааж өгчээ. “Бүтцийн илүүдэл”-ийг тогтоохын тулд Засгийн газар зэсийн “жишиг” үнэ дотоод хэрэгцээндээ тогтоодог. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ энэхүү тогтоосон үнээс давсан тохиодолд илүүдэл орлогыг хуримтлуулдаг. Бусад салбараас орж ирэх Засгийн газрын орлогыг эдийн засгийн мөчлөгийн шинж чанартай хэлбэлзлээс ангижруулан, төсвийн “бүтцийн орлого”-ыг тооцдог. Ийнхүү, зэсийн “жишиг үнэ”-ээр тооцсон орлого болон “бүтцийн орлого”-ыг нэмээд Засгийн газрын зарлагаа хасахад “бүтцийн илүүдэл”-тэй байх ёстой бөгөөд энэхүү илүүдэл нь ДНБ-ий 0.5 хувьтай тэнцэх юм. Өөрөөр хэлбэл, Засгийн газар зарлагаа хэт их өсгөвөл энэхүү зорилго биелүүлэх боломжгүй болно гэсэн үг.

Дүгнэж хэлэхэд, эдгээр тогтолцоо нь Засгийн газрын зарлагын өсөлтийг хязгаарлахад чиглэгдэж байна. Төсвийн энэхүү тогтворжуулалттай зэрэгцээд улс орнууд төрөл бүрийн хуримтлалын сан байгуулдаг. Жишээ нь дээр дурьдсан Норвегийн Тэтгэврийн санд 445 тэрбум ам. доллар, Чилийн Тэтгэврийн сан болон Нийгэм, эдийн засгийн тогтворжилтын санд энэ оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар нийтдээ 22 тэрбум ам. долларын хөрөнгө хуримтлагдаад байгаа юм байна<sup>16</sup>. Эдгээр хуримтлалын сангууд ихэвчлэн эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийдэг. Тухайлбал, хөгжингүй орнуудын Засгийн газрын гаргасан үнэт цаасыг худалдан авдаг. Хэдийгээр эдгээр үнэт цаасны үр өгөөж бага ч буцаж төлөгдөх найдвар сайтай тул худалдан авдаг байх нь. Норвегийн Тэтгэврийн сан л гэхэд сүүлийн гурван жилд дунджаар 4 гаруй хувийн үр өгөөжтэй байсан байна. Өөрөөр хэлбэл эдгээр сангуудын гол зорилго нь эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийж хөрөнгийнхөө худалдан авах чадварыг хамгаалахад оршдог. Харин, эрсдэл өндөртэй, ашиг өндөртэй санхүүгийн үйл ажиллагаа явуулахаас зайлсхийдэг аж.

Манай орны хувьд иймэрхүү төсвийн тогтворжилтын тогтолцоо хэрэгтэй гэдэг нь гарцаагүй. 2006 онд “Монгол Улсыг хөгжүүлэх сан” нэртэй хуримтлалын сан байгуулсан. Уг санг байгуулсан гол зорилго нь ашигт малтмалын гэнэтийн ашгаас орох орлогыг хуримтлуулахад оршиж байсан. Байгуулагдсанаасаа хойш энэхүү санд нэлээд хөрөнгө төвлөрсөн. Тухайлбал, 2006 ба 2007 онуудад энэ санд ДНБ-ий тус бүр 4.8 хувь болон 7.7 хувьтай тэнцэхүйц хөрөнгө төвлөрсөн. Харамсалтай нь энэ хуримтлалын сангаас зарах зарцуулалт нь төсвийн алдагдлыг зөвхөн зайлшгүй хэрэгцээ гарсан тохиолдолд нөхөх биш, харин Засгийн газрын ердийн зарлагуудыг санхүүжүүлсэн учраас дээр дурьдсан тогтворжилтын үүргийг гүйцэтгэж чадаагүй. Тухайлбал, тус сангийн хөрөнгийн гуравны нэгийг халамжийн хөтөлбөрүүдэд, гуравны нэгийг Засгийн газрын хөрөнгө оруулалтад, үлдсэн

16 Sovereign Wealth Fund, [www.swfinstitute.org](http://www.swfinstitute.org)

гуравны нэг нь л хуримтлал болж үлдэхээр зааж өгсөн. Ийнхүү зарцуулалт өндөртэй байсан учраас эдийн засгийн хямрал нүүрлэхэд энэ санд хямралын эсрэг тэмцэх хөрөнгө бага үлдсэн байсан талаар бид өмнөх улирлын тайланд дурьдсан. Тэгвэл энэхүү туршлагаасаа сургамж авч, чухам ямар хувилбараар бид энэхүү төсвийн тогтворжилтыг бий болгох нь зүйтэй вэ гэдгийг сайтар судлах хэрэгтэй байна. Бидний үзэж байгаагаар дээр дурьдсан орнуудын загварыг шууд хуулж болох ч хүндрэл бэрхшээл нэлээд гарах нь тодорхой.

Манай улсын хувьд дэд бүтцийн хөгжил сул бөгөөд дунд хугацаандаа стратегийн шинж чанартай ордуудыг ашиглалтад оруулснаар эрдэс баялгаас хамаарах хамаарал улам ихсэх болно. Ийнхүү, нэг талаас Засгийн газрын зарлагыг өсгөх шаардлагатай, нөгөө талаас эрдэс баялгийн орлогоос хэт хараат байдлыг багасгахын тулд төсвийн зарлагын өсөлтийг нь хязгаарлах ёстой.

Монгол Улсын эдийн засагт гуравдугаар улиралд гарсан томоохон үйл явдал бол Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан явдал байлаа. Энэхүү гэрээ байгуулагдсанаар манай улсын экспорт үлэмж өсөх хандлагатай байгаагаас гадна нийт үйлдвэрлэлийн хэмжээ болоод Засгийн газрын орлогын хэмжээнд ч огцом нөлөөлөхөөр урьдчилсан тооцоо хийгдсэн. Тэгвэл энэхүү үйл явц манай улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ, ямар асуудлууд дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой вэ?

Манай улсын эдийн засаг жил ирэх тусам эрдэс баялгийн олборлолт, түүний экспортод тулгуурласан байдалтай байна. Энэ салбараас хамаарч байгаа хамаарал жил ирэх тусам ихэссэн байгаа. Тэгвэл, Оюу Толгой ашиглалтад орсноор эрдэс баялгаас хамаарах хамаарал улам ихсэх нь дамжиггүй. Шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ бий болох нь эдийн засагт эерэг нөлөөлөл авчирна. Харин, эрдэс баялгийн үйлдвэрлэл хэт өсөх нь тухайн орны эдийн засгийг томоохон эрсдэлд оруулдаг гэдгийг олон орны туршлага харуулснаас гадна манай орны сүүлийн жилүүдэд ажиглагдсан чиг хандлага ч гэсэн эдгээр эрсдлийг тод томруунаар илрүүлж өглөө.

Эрдэс баялгийн экспортоос хэт хараат байх нь тухайн эдийн засгийг тогтворгүй болгодог. Тогтворгүй орчинд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах сонирхол пүүс, компаниуд, хувь хүмүүст бий болохгүй. Энэ нь эргээд эдийн засгийн өсөлтийг бий болгохгүй учраас эрдэс баялгаа хэт дулдуйдсан орны эдийн засгийн өсөлт “эрүүл биш” шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, ажил эрхлэлт, орлогын тэгш хуваарилалт, нэмэгдсэн өртгийн үйлдвэрлэл, өрсөлдөх чадвар зэрэг үзүүлэлтүүдийн хувьд сул байх талтай. Ийнхүү, эрдэс баялгаар баян байх нь тэр бүр эдийн засгийн өсөлтийг хангана гэсэн үг биш юм гэдгийг маш олон орны туршлага харуулсан. Тухайлбал, эдийн засагчид “баялгийн хараал” гэсэн ойлголтыг хүртэл гаргаж ирсэн. Учир нь эрдэс баялаг эдийн засгийн өсөлт, нийгмийн баялгийг бий болгохоосоо илүү тухайн орныг ядууруулж, баян ядуугийн заагийг улам өргөн болгож, эдийн засгийн хөгжил дэвшил авчрах биш, харин ч эдийн засаг, нийгмийг нь туйлдуулсан жишээ цөөнгүй байгаа.

Тэгвэл ямар замаар эдийн засаг эрдэс баялгаас болж ийнхүү доройтож болох вэ? Эрдэс баялгаас орох экспортын орлого ихэвчлэн гадаад валютаар орж ирдэг. Манай орны хувьд ихэвчлэн ам. доллараар орж ирдэг. Эрдэс баялгийн экспорт өсөх тусам энэхүү валютын орж ирэх урсгал өсөх болно. Хэдийгээр энэ үйл явц нь сайн зүйл мэт харагдах боловч нөгөө талдаа эдийн засгийн

тогтворгүйжилтийг бий болгодог. Тухайлбал, тухайн орны дотоодын мөнгөний үнэ цэнийг өсгөдөг. Өөрөөр хэлбэл, төгрөгийн ханш өснө гэсэн үг. Гэтэл төгрөгийн ханш чангарах нь дотоодын экспортлогчид болоод үйлдвэрлэгчдийг алдагдалд оруулдаг. Эрдэс баялгаас өөр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох нь ашиг муутай болж ирнэ гэсэн үг. Энэ үйл явц даамжирвал тухайн эдийн засаг эрдэс баялгийнхаа экспортоос хараат байдал нь улам ихэснэ. Тэгэхээр нэмэгдсэн өртөг илүүтэйгээр үйлдвэрлэдэг бусад салбар буурах тул нийгмийн олон эмзэг асуудлуудыг бий болгоно. Энэхүү үйл явцыг эдийн засагчид “Голланд өвчин” гэж нэрлэх нь элбэг. Тиймээс энэхүү “өвчин”-д нэрвэгдэхгүйн тулд эрдэс баялгийн экспортоос орох валютын урсгалыг оновчтой удирдах асуудал хурцаар тавигдана гэсэн үг.

Оюу Толгойн гэрээ батлагдсантай холбоотойгоор олон нийтийн дунд мөнгөн хувь хүртэх талаар нийтлэг хүлээлт бий болжээ. Улс төрчид, бодлого боловсруулагчид өөрсдөө энэхүү хүлээлтийг бий болгосон тул амлалтаа биелүүлэх үүднээс Айвенхоу Майнз компаниас авсан урьдчилгаа төлбөр буюу үндсэндээ зээл болох 100 сая ам. долларыг олон нийтэд халамж хэлбэрээр тараах асуудал яригдаж байна. Энэхүү шийдэл биелэлээ олбол хүн бүрт 50,000 төгрөг оногдохоор байна. Өнгөц харахад энэ арга хэмжээ нь хүмүүсийн орлогыг түр хугацаагаар өсгөж, улмаар хямралтай байгаа эдийн засагт нийт эрэлтийг өсгөх замаар түлхэц өгч болохоор харагдаж байгаа боловч энд хэд хэдэн ойлгомжгүй асуудал байгаа. Энэхүү үйл явц юуг тод томруунаар харуулж байна вэ гэхээр олон нийтэд хавтгайруулан олгож байгаа олон төрлийн халамжийг хязгаарлах эдийн засаг, хууль эрх зүй, улс төрийн тогтолцоо манай улсад огт байхгүй байна гэдгийг л тодоор харуулж байна. Түүнээс гадна халамжийн бодлого, эдийн засгийг тогтворжуулахад чиглэгдсэн бодлогууд хоорондоо огт уялдаа холбоогүй байна гэдгийг харуулж байна. Халамжийг нийгмийн эмзэг хэсэгт олгох ёстой боловч ийнхүү хавтгайруулж байгаа нь эдийн засагчдад огт ойлгомжгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн талаас нь энэхүү үйл явцыг тайлбарлах боломжгүй мэт санагдаж байна.

Эндээс дүгнэхэд, Оюу Толгой зэрэг том төслүүд хэрэгжиж эхэлснээр манай улсын эдийн засаг болоод Засгийн газрын төсөвт томоохон нөлөөлөл үзүүлэхээр байна. Тэгвэл гадаад эдийн засгийн таагүй нөлөөллөөс эдийн засгаа хамгаалахын тулд Засгийн газрын төсвийн орлого, зарлагын удирдлагыг зөв зохистой тодорхойлж өгөх шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан Засгийн газрын зарлагын хэт их өсөлтийг дахин гаргуулалгүй, эдийн засгаа иймэрхүү хэлбэлзлээс хараат бус байлгах нь чухал. Ойрын үед энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Төсвийн тогтворжилтын тухай” болоод “Эрдэнэсийн сангийн тухай” хуулиудын санал боловсруулагдаж, хэлэлцүүлэг эхэлж байгаа нь сайшаалтай.



---

## 5. Боловсрол, эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал ба тулгамдсан асуудлууд

---

Боловсрол, эрүүл мэндийн салбар нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас уламжлагдан ирсэн, өнөөгийн байдлаар манай улсын төсвийн нийт санхүүжилтийн 30 орчим хувийг эзэлдэг нийгмийн хамгийн том хоёр салбар юм. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд боловсрол, эрүүл мэндийн салбарт төр оролцох хэд хэдэн үндэслэл байдаг. Эдгээр нь эдийн засагчдын хэлдэгээр эерэг дам нөлөө (*externality*) бий болгодог үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, боловсрол болон эрүүл мэндийн үр шимийг зөвхөн тухайн үйлчилгээг хүртэж буй хүн төдийгүй мөн нийгмийн бусад иргэд хүртдэг гэж үздэг. Жишээлбэл, бичиг үсэг тайлагдах эсвэл халдварт өвчингүй байх нь зөвхөн тухайн хүндээ өгөөжтэйгээс гадна, эргэн тойрны хүмүүст эерэг нөлөө үзүүлдэг.

Нөгөө талаас, боловсролын түвшин болон эрүүл мэндийн байдал орлогын ихээхэн ялгаварлалыг бий болгодог учир боловсрол, эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийх боломжгүй ядуу өрхүүд, тэдгээрийн хүүхдүүдийн цаашдаа орлого олох боломж нь улам хаагдаж, нийгмийн хэмжээгээр орлогын хэт ялгаварлал гүнзгийрэх аюултай. Төрийн зүгээс боловсрол, эрүүл мэндийн салбарт оролцохдоо, нэгдүгээрт, уг зардал нь нийгмийн хэмжээгээр хэр их эерэг дам нөлөө үзүүлэх вэ, хоёрдугаарт, энэхүү зардлыг төр хариуцсанаар орлого багатай өрхүүд хэр их үр шимийг нь хүртэх вэ буюу орлогын дахин хуваарилалтанд энэ нь хэр нөлөөлөх вэ гэсэн асуултанд хариулах ёстой юм.

Дээрх шалгуураар хамгийн их эерэг дам нөлөөтэй үйлчилгээнд бага боловсрол, улмаар дунд боловсрол, цаашилбал вакцинжуулалт, халдварт өвчний эмчилгээ, эмнэлгийн анхан шатны тусламж зэрэг ордог. Ихэнх улс оронд эдгээр үйлчилгээг төрөөс үнэгүй үзүүлдэг нь үүнтэй холбоотой юм. Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ), дээд боловсрол, халдварт бус өвчинг анагаах зэрэг үйлчилгээний үр шимийг гол төлөв боловсрол эзэмшигч эсвэл эмчлүүлэгч өөрөө хүртдэг учир нийгмийн хэмжээгээр үзүүлэх нөлөө харьцангуй багасдаг. Хөгжиж буй орнуудын хувьд төрийн зүгээс дээд боловсрол, нарийн мэргэжлийн эмчийн үйлчилгээ зэрэгт бага хөрөнгө зарцуулдгийн шалтгаан үүнд оршино.

Харин орлогын тэгш бус байдлыг зохицуулах зорилгын үүднээс СӨБ, тусгай болон дээд боловсрол, төрөл бүрийн эмнэглийн үйлчилгээг төрөөс санхүүжүүлэх боломжтой бөгөөд шаардлагатай байдаг. Ийнхүү дэмжлэг үзүүлэхдээ нийгмийн шаардлагатай бүлэгт зориулсан санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь зохимжтой. СӨБ болон дээд боловсролд зарцуулж буй мөнгөний нийгмийн тэгш байдлыг хангах зорилгодоо хүрэхийн тулд зөвхөн энэ үйлчилгээг өөрсдөө мөнгөө төлөөд авч чадахгүй иргэдэд чиглүүлэх нь хамгийн оновчтой юм. Нарийн мэргэжлийн эмчийн үйлчилгээ үүнтэй мөн адил. Гэхдээ ийнхүү ялгавартай хандах нь иргэдийн хувьд орлогоо бууруулж, төлбөрөө даалгах зэрэг сөрөг хөшүүрэг үүсгэдгийг санах хэрэгтэй юм.

## 5.1. Боловсролын салбар

### **Боловсролын салбарын үр дүнгийн үзүүлэлтүүд**

Манай улсын боловсролын салбарын үзүүлэлтүүд бусад улс орнуудтай харьцуулахад бага ба дунд боловсрол дээр дүйцэхүйц түвшинд, харин сургуулийн өмнөх болон дээд ба тусгай боловсрол дээр нэлээд өндөр түвшинд байгаа нь төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үр нөлөө гэж үзэх үндэслэлтэй (Хүснэгт 5.1).

Хүснэгт 5.1. Хамран сургалтын бохир жин, боловсролын түвшнээр, 2007 он

	СӨБ	Бага	Дунд	Дээд ба тусгай
Төв ба Зүүн Европын бүс	64	97	88	62
Зүүн Ази болон Номхон далайн бүс	47	110	78	26
Төв Азийн бүс	28	100	95	24
Монгол Улс	54	100	92	48

Эх сурвалж: UNESCO Institute for Statistics

Сүүлийн хэдэн жилд манай бүх нийтийн боловсролын тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд орсон байна. 2008 онд “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль” батлагдсанаар уламжлалт цэцэрлэгийн сургалтын зэрэгцээ хувилбарт сургалтын хөтөлбөрүүд, үүнд явуулын багшийн үйлчилгээ ба гэр цэцэрлэг зэрэг хөтөлбөрүүд албан ёсоор хуульчлагдсан. Мөн төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны төлбөрийг төрөөс бүрэн даах болсон байна. Үүний үр дүнд хамран сургалт нэлээд өсч 2008-2009 оны хичээлийн жилд цэцэрлэгт 57 хувь, хувилбарт сургалтанд 15.7 хувь, нийтдээ 72.7 хувь болсон байна<sup>17</sup>.

Ерөнхий боловсролын хувьд 2005-2006 оны хичээлийн жилд 10-аас 11 жилийн тогтолцоонд шилжсэн. Цаашилбал, “Боловсролын тухай хууль”-ийн 7.2 заалтын дагуу 2008-2009 оны хичээлийн жилд 6 настнуудыг нэгдүгээр ангид авч, 12 жилийн боловсролын тогтолцоонд шилжсэн нь салбарын хэмжээний томоохон шинэчлэл болсон. 2008-2009 оны хичээлийн жилд 43 мянган 6 настан шинээр 1 дүгээр ангид элсэн орсон байна. Энэ нь сургалтын төлөвлөгөө, сургуулийн байрны хүрэлцээ, багш нарын бэлтгэл, сурах бичиг болон сургалтын материал, боловсролын урсгал болон хөрөнгө оруулалтын төсөв зэрэгт томоохон нэмэгдэл дарамт учруулсан нь ойгомжтой. Дэлхийн олон орон, тэр дундаа шилжилтийн эдийн засагтай улс орнууд 12 жилийн дунд боловсролын тогтолцоонд шилжиж

17 БШСУЯ-ны мэдээ

байгаа бөгөөд манай орны хувьд эдгээр орны тоонд ийнхүү багтах нь томоохон шинэчлэл юм. Үүнийг 11 жилийн тогтолцоонд шилжсэн өмнөх өөрчлөлт нь хэвшээгүй байхад хэт богино хугацаанд дахин шинэчлэл хийлээ гэж шүүмжлэх хүмүүс ч цөөнгүй байв.


Бага боловсролын (6-11 нас) хамран сургалтын цэвэр жин 2008-2009 онд 91.5 хувь, дунд боловсролынх (12-15 нас) 87.4 хувь байжээ. Хамран сургалтын үзүүлэлтүүдийн хувьд бага насны хүүхдүүдийн дунд хүйсний ялгаа байхгүй, анги ахих тусам эмэгтэй хүүхдүүдийн сургалтанд хамрагдаж байгаа хувь нь эрэгтэй хүүхдийнхээс илүү өндөр болж, ялгаа гардаг байна. Хамран сургалтын хувь хот, хөдөөгөөр нэлээд ялгаатай байгаа нь салбарын хувьд томоохон асуудал гэж үздэг. 2008-2009 оны хичээлийн жилд сургуульд сураагүй 6-14 насны нийт хүүхдийн 8.8 хувь нь хотод<sup>18</sup>, үлдсэн 91.2 хувь нь хөдөөд байгаа нь том ялгаа байгааг харуулж байна<sup>19</sup>.

### **Боловсролын салбарын санхүүжилт**

Шилжилтийн эдийн засагтай улс орнуудын хувьд боловсролын салбарын санхүүжилт нь ДНБ-ий 4-8 хувь, улсын төсвийн 10-20 хувийг эзэлж байна. Эдгээр үзүүлэлттэй харьцуулахад манай улсын хувьд санхүүжилт өндөр байгаа нь боловсролын салбарт ихээхэн ач холбогдол өгдгийг харуулж байна. 2006 онд боловсролын бодит санхүүжилт нь ДНБ-ий 5.1 хувь, улсын төсвийн 15.3 хувийг эзэлж байсан. 2008 оны хувьд энэ үзүүлэлтүүд нь нэлээд өсч, ДНБ-ий 7.2 хувь, төсвийн зарлагын 21 орчим хувийг эзэлж буй нь 12 жилийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотой юм.

2000-2008 онд боловсролын зардал дунджаар ДНБ-ий 7.0 хувьтай тэнцүү, төсвийн орлогын 20.7 хувьтай тэнцүү байсан нь бусад оронтой харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Энэ тоо боловсролын салбарт зарцуулагдсан зөвхөн төсвийн зарлагын дүнг илтгэж байгааг анхаарна уу.

Зураг 5.2. Боловсролын салбарын төсвийн ДНБ болон улсын төсвийн орлогод<sup>20</sup> эзлэх хувийн жин




Эх сурвалж: БСШУЯ

18 Хот гэдэгт Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийг оруулна.

19 БСШУЯ-ны мэдээ

20 БСШУЯ-аас орлогод эзлэх хувийн жин гэсэн үзүүлэлтийг албан ёсоор гаргадаг учир энд оруулав.

Зураг 5.3. Боловсролын нийт төсөвт хөтөлбөрүүдийн эзлэх хувийн жин, 2007 оны төсвийн гүйцэтгэлээр



Эх сурвалж: БСШУЯ<sup>21</sup>

Боловсролын салбарын нийт зардлыг боловсролын түвшнээр нь авч үзвэл манай улсын хувьд бусад ижил төстэй орлогын түвшинтэй улс орнуудтай харьцуулахад сургуулийн өмнөх боловсрол (СӨБ) болон дээд ба тусгай боловсролд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулдаг нь харагдаж байна.

Хүснэгт 5.2. Боловсролын салбарын зардлын бүтэц, зарим орноор, 2007, хувиар

Боловсролын нийт зардлын эзлэх хувийн жин	Боловсролын нийт зардалд эзлэх хувийн жин					
	ДНБ-д	Нийт төсөвт	СӨБ	Бага боловсрол*	Дунд боловсрол*	Дээд ба тусгай боловсрол
Монгол	5.1	23.5	19.7	26.7	32.8	20.8
Тажикистан	3.4	18.2	4.4	26.6	49.0	7.5
Лаос	3.2	15.8	1.6	62.5	14.1	9.2
Филиппин	2.5	15.2	0.1	52.0	26.8	13.3
Тайланд	3.9	20.9	13.6	31.5	24.4	17.9

\*- 2005 он

Эх сурвалж: UNESCO Institute for Statistics

Тайлбар: Боловсролын нийт зардал нь хувийн болон улсын, урсгал болон хөрөнгийн зардлыг багтаана.

### Эдийн засгийн хямралын боловсролын салбарт үзүүлж буй нөлөө

Эдийн засгийн хямралын боловсролын салбарт үзүүлсэн хамгийн том нөлөө нь боловсролын төсвийг 2009 оны 7 дугаар сарын улсын төсвийн тодотголоор танасан явдал юм. 2008 оны сүүлээр батлагдсан төсвөөр боловсролын салбарт 432.5 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байсан. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй Стэнд-Бай хөтөлбөрийн дагуу төсвийн алдагдлыг 6

21 Боловсролын бусад байгууллагын төсөвт Сургалтын төрийн сан болон орон нутгийн боловсролын газар зэргийн төсөв багтана.

хувиас доогуур байлгах үүргийг Засгийн газраас хүлээж, үүний дагуу 2009 он гарсаар удаа дараа төсвийн тодотгол хийсний үр дүнд боловсролын салбарын төсөв 396.5 тэрбум болтлоо буурсан байна. Энэ нь дүндээ 8.3 хувийн таналт бөгөөд урсгал болон хөрөнгийн зардлын аль алийг хамарсан байна. Танагдсан нийт хэмжээг задалж үзвэл: (i) цалин болон НДШ 2.8 хувиар, (ii) бараа, үйлчилгээний зардал 22.3 хувиар, (iii) хөрөнгө оруулалтын зардал 18.9 хувиар тус тус буурсан байна.

2008 онд “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийг баталсан. Энэ хуулийн дагуу цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолыг улсын төсвөөс үнэгүй даах тухай заалт орсны дагуу цэцэрлэгийн хүүхдийн хамралт нэлээд өсч, төсвийн ачаалал тэр хэмжээгээр нэмэгджээ. 2009 оны 1 дүгээр сараас 6 сар хүртэл хугацаанд хамран сургалт 22 хувиар өссөн гэж АХБ мэдээлж байна<sup>22</sup>. Үнэгүй хоол өгдөг болсон, хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн бөгөөд төсвийн хүндрэлийн улмаас 2009 болон 2010 онд нийтдээ 13 сая ам. доллартай тэнцэх хөрөнгө дутагдахыг АХБ-наас Боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэхийг Засгийн газраас хүсээд байна.

Хямралын үзүүлэх бас нэг нөлөө нь хоол тэжээлийн хомсдол юм. 2008 онд хийсэн Мерси Кор-ын судалгаагаар манай улсын нийт өрхийн гуравны нэг нь хоол хүнсний хувьд эмзэг гэж тооцогддог ба нийт хүүхдийн 20 хувь нь өсөлт хөгжлийн дутагдалтай гэж үзсэн байдаг. Хүнсний эмзэг байдалд ядуурал, ажилгүйдэл, ажлын байрны баталгаа байхгүй зэрэг нөлөөлж байна гэж үзжээ. Тиймээс цэцэрлэгийн хоол болон сургуулийн “үдийн цай” хөтөлбөр хямралын үед сургуулиас хүүхэд завсардахгүй байх нэг шалтгаан гэж үзэж болно. Сүүлийн үед шинээр хэрэгжүүлсэн үнэгүй хоолны хөтөлбөр нь ядуучуудад чиглэсэн бодлого болсон гэж АХБ үзсэн байна. “Үдийн цай” хөтөлбөр хэрэгжүүлснээр хоолонд зарцуулж буй нийт зардал нь 2006 онд боловсролын салбарын урсгал төсвийн 7.8 хувийг эзэлдэг байсан бол 2008 онд 13.2 хувь болтлоо өссөн байна. 2009 оны төсөвт хоолны мөнгө бүрэн хэмжээгээр туссан бөгөөд 2010 оны төсөвт ямар нэгэн таналт хийгдэхгүй гэсэн хүлээлттэй байна.

Засгийн газрын зүгээс хямралын улмаас төсвийн орлого буурсантай холбоотой зарлагаа хасахдаа зарлагын төрлүүдийг дараах байдлаар эрэмбэлсэн байна: (i) цалин, (ii) НДШ, (iii) өрхөд олгох шилжүүлэг, (iv) тогтмол зардал, (v) бусад зарлага. Үүнтэй холбоотой боловсролын салбарын 2009 оны төсвийн дөнгөж 3 хувь нь хичээлийн хэрэгсэл, сургалтын материал, холбоо, багшийн мэргэжлийн бэлтгэл, сургалт зэрэгт зарцуулагдахаар болсон байна. 2006 онд эдгээр зардалд урсгал зарлагын 5.6 хувийг зарцуулж байжээ. Сургалтын материал, компьютер, тоног төхөөрөмжийн хангамж зэргээс сургалтын чанар шалтгаалдаг учир 2009 оны төсөв танагдсан явдал сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм. Эдгээр урсгал зарлагыг нөхөхийн тулд сургалтын үйл ажиллагаагаа танах, суралцагсадын тоогоо нэмэгдүүлэн мэдүүлэх замаар төсвөөс авах мөнгөө нэмэгдүүлэх, эсвэл эцэг эхийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэхэд хүрч байна гэж багш, эцэх эхчүүд мэдэгдсэн байна<sup>23</sup>.

22 Asian Development Bank (2009) “RRP on the Proposed Asian Development Fund Grant Mongolia: Education for the Poor—Financial Crisis Response Project”, Manila

23 АХБ-наас хийсэн 16 аймгийн 107 сургуулийн багш, ажилтан, эцэг эхчүүдээс авсан судалгаа болон ярилцлагын үр дүнгээс

Сурагчдын дотуур байрны асуудал хямралын үед хүндэрсэн байна. 2008-2009 оны хичээлийн жилд 493 дотуур байртай сургуулиуд 42 мянган сурагч хүлээн авсан байна. Энэ нь нийт сурагчдын 8 орчим хувийг эзэлж байна. Эдгээрийн дийлэнх буюу 87.4 хувь нь малчдын хүүхдүүд эзэлж байсан байна. Дулааны зардал 2009 онд нийт зардлын 9 хувийг эзэлж буй нь 2006 онтой харьцуулахад ихээхэн буурсан байна. Үүний үр дүнд дотуур байрны амьдрах нөхцөл юуны түрүүнд муудна гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Хямралын улмаас ядуурлын түвшин өснө гэж үздэг. Төрөөс олон тооны хөтөлбөр хэрэгжүүлсэн хэдий ч ядуурал буурахгүй байгаа нь ядуурлын эсрэг бодлого үр дүнгээ өгөхгүй байгаагийн илрэл юм. Ядуурлын түвшин бүс нутгаар нэлээд ялгаатай байгааг мөн тэмдэглэх хэрэгтэй. Ядуурал өсөх нь боловсролд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм. Сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас зэрэг нь ядуу өрхийн төсвийн харьцангуй өндөр хувийг эзэлдэг учир хямралын улмаас байдал хүндрэх нь тодорхой. 1998 болон 2002 онд Дэлхийн Банкнаас хийсэн “Өрхийн амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-ны үр дүнд сургууль завсардалт нь ядууралтай шууд холбоотой болохыг тогтоосон байна. Ядуурлын сөрөг нөлөө бага боловсрол дээр харьцангуй бага илэрч, ялангуяа ахлах ангийн хүүхдүүдийн сургууль завсардалтанд ихээхэн сөрөг нөлөөтэй гэдгийг харуулсан. Хямрал нүүрлэхээс өмнө сурах бичиг болон хичээлийн хэрэгслийн зардал өндөр гэж олон ядуу өрх үзэж байсан. Энэ нь ялангуяа сургуулийн насны 2 болон түүнээс олон хүүхэдтэй ядуу өрхүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөдөөний өрхүүдийн хувьд ихээхэн дарамт учруулж байна. Харин, хямралын үед хүүхдээ сургуулиас гаргаж, ажил хийлгэн нэмэлт орлого олуулах гэсэн хандлага нэг их хүчтэй биш гэж өрхүүд үзсэн байна<sup>24</sup>, учир нь өнөөгийн байдлаар ажлын олдоц муу, орлого олох боломж хязгаарлагдмал байна.

2009 оны эхний 9 сарын хуримтлагдсан дүнгээр төсвийн нийт санхүүжилт 2009 оны төсвийн тодотголтой харьцуулахад 44.7 орчим тэрбум төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь төсөвлөгдсөн нийт дүнтэй харьцуулбал 14.2 хувийн хэмнэлт юм. Үүнээс ерөнхий боловсролын сургуулиуд 4.6 хувь, цэцэрлэгүүд 11.9 хувийн хэмнэлтийн дийлэнх нь хоолны хөтөлбөрийн хэмнэлт байгаа нь хүүхдийн ирц, хамралт буурсантай холбоотой гэж үзэх үндэстэй. СӨБ болон ерөнхий боловсролын сургуулиудын хоолны төсвийг боловсруулахдаа хүүхэд жилийн 190 хоног бүрэн суралцана гэсэн тооцоогоор санхүүжилтийг хийдэг бол ирц муудсан, сургууль завсардсан, шилжих хөдөлгөөн хийдсэн зэрэг шалтгааны улмаас хоолны мөнгө хэмнэгдэх нөхцөл бүрддэг гэж БСШУЯ-ны мэргэжилтнүүд үзэж байна.

Сургалтын төрийн сан болон МСҮТ-ийн төсөв нэлээд “хэмнэгдсэн” харагдаж байгаа нь гол төлөв хичээлийн жил эхлээд сургалтын төлбөр нь бүрэн шилжээгүйтэй холбоотой гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтын санхүүжилт нэлээд дутуу хийгдэж, төсөвлөгдсөн мөнгөний гуравны нэг нь зарцуулагдаагүй байгаа нь Сангийн яамны хувьд хөрөнгө оруулалтын санхүүжилтийг чухалчлахгүй байгаагаас үүдэлтэй байж магадгүй юм. Одоогоор хэмнэгдээд байгаа хөрөнгийн ихэнх нь он дуусахаас өмнө нөхөн зарцуулагдана гэж үзэж байна.



Хүснэгт 5.3. Боловсролын төсвийн гүйцэтгэл, 2009 оны эхний 9 сарын байдлаар, төгрөгөөр

	Төсөвлөгдсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү/ Төсөв
Салбарын хөрөнгө оруулалт (соёл, шинжлэх ухааныг оруулан)	40,881,270	27,357,888	13,523,382	33.1%
Сургуулийн өмнөх боловсрол	53,816,578	47,400,879	6,415,698	11.9%
Ерөнхий боловсролын сургууль	157,673,074	150,451,234	7,221,841	4.6%
Боловсролын бусад байгууллага (Сургалтын төрийн санг оруулан)	37,332,661	25,417,328	11,915,333	31.9%
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв	25,249,370	19,651,352	5,598,018	22.2%
<b>БОЛОВСРОЛЫН ДҮН</b>	<b>314,952,953</b>	<b>270,278,681</b>	<b>44,674,272</b>	<b>14.2%</b>

Эх сурвалж: БСШУЯ

Санхүүгийн хямралын улмаас хамран сургалтын түвшин бодит байдал дээр буурсан эсэхийг одоогоор тодорхойлоход бэрхшээлтэй байна. БСШУЯ-аас хамран сургалтын хувийг гаргахдаа хичээлийн жилийн эхэнд тоон мэдээгээ цуглуулан авдаг бөгөөд энэ тоо нь оны сүүлээр нэгтгэгддэг учир өнөөгийн байдлаар энэ хичээлийн жилд хамран сургалтын түвшин ямар хэмжээнд байгаа нь 12 дугаар сарын сүүлээс нааш тодорхой болохгүй тул хямралын үр нөлөөг тооцоход бэрхшээлтэй юм.

### **Боловсролын салбарын тулгамдсан асуудлууд**

Боловсролын салбарт олон асуудал байгаа хэдий ч тогтолцооны хэмжээнд цөөн тооны асуудлыг чухал гэж үзлээ. Юуны өмнө төрийн боловсролын үйлчилгээ орлого багатай өрхүүдэд илүүтэйгээр чиглэж чадахгүй байна гэж үзэж байна. Өнөөгийн байдлаар боловсролын бүх шатанд төрөөс дэмжлэг үзүүлэхдээ орлогын болон бусад ялгаварлалыг хийдэггүй. Ерөнхий боловсролын хувьд ийнхүү ялгаварлах нь оновчгүй байдаг. Гэтэл СӨБ, цаашилбал дээд ба тусгай боловсролын хувьд хавтгайруулсан тусламж нь гурван төрлийн сөрөг үр дагаврыг бий болгож байна. Нэгдүгээрт, ингэх нь төсвийн хувьд томоохон дарамтыг бий болгож байна. Төсвийн буюу татвар төлөгчийн хөрөнгийг нийгмийн хэмжээгээр хамгийн их үр өгөөжтэй зориулалтаар зарцуулах нь төрийн бодлогын суурь зарчим байх ёстой бөгөөд татвар төлөгч иргэд ч үүнийг хүсч байгаа. Хоёрдугаарт, төрийн зүгээс орлогын тэгш хуваарилалтыг бий болгох үүднээс орлого багатай иргэдээ ямагт дэмжих ёстой байдаг атал ихэнх шатны боловсролыг ийнхүү бүгдэд үнэгүй олгох нь нийгмийн халамжийн суурь зарчимтай зөрчилддөг. Гуравдугаарт, тодорхой шатны боловсролын үр шимийг хамгийн их хүртэж буй этгээд түүнтэй холбоотой гарах зардлыг голчлон төлөх ёстой гэдэг зах зээлийн зарчим боловсрол дээр нэгэн адил үйлчлэх ёстой юм. Хэрэв ямар нэгэн түвшний боловсрол эзэмшсэнээр өгөөжийг нь өрхүүд голчлон хүртэж байвал зардлыг нь мөн өрх л хариуцах нь оновчтой юм. Хэрэв өгөөжийг нэг хүн хүртэж, зардлыг нь өөр хүн төлж байвал эдийн засагчдын хэлдэгээр тухай барааны “хэт хэрэглээ” бий болж, нийгмийн хэмжээгээр нөөц үр ашиггүй хуваарилагдана гэж үздэг.

Манай улсын боловсролын тогтолцоонд дээрх суурь бэрхшээлүүд бүгд тодоор илэрч байна. Боловсролын бүх шатны хөтөлбөрт, ялангуяа СӨБ болон дээд ба тусгай боловсролд, төрийн оролцоо хэт их байна гэж үзэж

байна. Манай улсын боловсролын хамран сургалтын болон бусад үзүүлэлтүүд нь дэлхийн ижил төстэй бусад орнуудтай харьцуулахад дүйцэхүйц түвшинд, зарим нэг үзүүлэлтээр илүү байна. Гэтэл төрөөс илүү их хөрөнгө зарцуулж байна. Өөрөөр хэлбэл, бид боловсролд бусад орноос хамаагүй их мөнгө зарцуулж, бараг ижил түвшний зорилтуудыг биелүүлж байна гэсэн үг юм. Монголын хувьд цаг уур болон газар зүйн хүчин зүйлээс шалтгаалан боловсролын үйлчилгээ нь илүү өндөр өртөгтэй байх магадлалтай ч эдгээр үзүүлэлтээрээ адил оронтой харьцуулахад төсөв мөн л илүү өндөр байгааг анхаарах хэрэгтэй байна.

Боловсролын зардлыг боловсролын түвшнээр нь авч үзвэл бага, дунд боловсролд зарцуулж буй мөнгө харьцангуй бага, харин СӨБ, дээд ба тусгай боловсролд зарцуулж буй мөнгө харьцангуй өндөр байгааг өмнө нь тэмдэглэсэн. Гэтэл эдгээрийн үр шимийг гочлон өрх гэр, хувь хүн хүртдэг учир санхүүжилтийн өөр хэлбэр давамгайлах ёстой санагдана. Дээд боловсролыг улсын төсвөөс шууд санхүүжүүлэхээ больж (одоогоор зөвхөн тогтмол зардлыг санхүүжүүлж байгаа), Сургалтын төрийн сангаар дамжуулан орлого багатай эсвэл сурлагаараа сайн хүүхдүүдэд тэтгэлэг олгож байгаа нь энэ бэрхшээлийг даван туулах гэсэн зөв зүйтэй алхам байсан. Харин мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ)- ийг төрөөс санхүүжүүлдэг нь улсын хэмжээний ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн хооронд бий болсон зөрүүг багасгах зорилготой түр зуурын хөтөлбөр гэж үзэж байгаа. Цаашдаа боловсролын энэ хөтөлбөрийг дээд боловсролын нэгэн адил хувийн зардлаар санхүүжүүлэх бүрэн боломжтой бөгөөд шаардлагатай гэж үзэж байна.

Манай боловсролын тогтолцоо нь ядуу иргэдийг дэмжихэд огт чиглээгүй тогтолцоо гэж хэлж болно. Тухайлбал, Засгийн газраас ядуу өрхийн хүүхдүүд буюу нийт сурагчдын ойролцоогоор 20 хувьд үнэгүй сурах бичгээр хангах шийдвэр гарсан байна. Гэтэл Дэлхийн Банкны судалгаагаар ядуу өрхийн хүүхдүүдийн дөнгөж 9 хувь нь үнэгүй сурах бичиг авсан гэсэн тооцоо гарчээ<sup>25</sup>. Цаашдаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 2009-2012 онд улсын хэмжээгээр бүх сурагчдыг үнэгүй сурах бичгээр хангана гэсэн зорилт тавьсан нь нийт 15 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэсэн тооцоо байна. Энэ бодлого нь мөн орлого багатай иргэдэд чиглээгүй бодлогын нэг тод жишээ юм. Тэгэхээр төрийн зүгээс орлогын дахин хуваарилалтын зорилгоо биелүүлж, ядуу иргэдээ илүүтэйгээр дэмжихийн тулд иргэдийн орлогыг бодитой тодорхойлж, орлогын болон бусад шалгуурыг тогтоож, тухайн шалгуурт нийцсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм. Гэхдээ ингэх нь өрхийн хувьд орлогоо нуун дарагдуулах, орлогоо нэмэгдүүлэхгүй байх, эсвэл бүр зориуд багасгах сөрөг хөшүүрэг бий болохыг санах хэрэгтэй. Нөгөө талаас хэсэг бүлэг иргэдэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь захиргааны хувьд зардал өндөртэй байдаг гэдгийг мөн бололцох ёстой.

Цаашилбал, СӨБ буюу 2-5 насны хүүхдийн боловсролыг үнэгүй олгож, өрхийн орлогыг үл харгалзан үнэгүй хоолоор хангах хуулийг 2008 онд баталсан. Энэ нь сүүлийн хэдэн жил хэрэгжүүлсэн төсвийн тэлэлтийн бодлогын нэг илрэл юм. Гэтэл сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үр өгөөж нь өрхийн түвшинд орлогоо нэмэгдүүлэх боломжоор илэрдэг учир төрийн зүгээс

25 World Bank (2009) "Consolidating the Gains, Managing Booms and Busts, and Moving to Better Service Delivery— A Public Expenditure and Financial Management Review". Washington, DC.

үүнийг хавтгайруулан хангах нь үр ашиг талаасаа, тэгш байдал талаасаа сөрөг нөлөөтэй. Ялангуяа хэт бага насны хүүхдийн боловсролын нийгмийн үр өгөөж бага байдаг. Тийм ч учраас сургуулийн өмнөх боловсрол нь олон оронд 3 наснаас эхэлдэг байна. Зарим улс оронд 4, эсвэл бүр 5 наснаас эхэлдэг нь үүнтэй холбоотой. Хэдийгээр СӨБ-ийн хамралт 3 наснаас эхэлдэг ч 4-5 насны хүүхдийн боловсролд илүү их анхаарах нь мөн олон оронд түгээмэл байна. Тухайлбал, Филиппин улсад 5 настай хүүхдийн боловсролыг Боловсролын яам, түүнээс бага насны хүүхдийн боловсролын асуудлыг Нийгмийн халамжийн яам хариуцаж байгаа нь насны бүлэглэлийн хооронд зарчмын ялгааг бий болгож байна. Гурваас доош насны хүүхдийн хүмүүжил, боловсролын асуудлыг ихэнх оронд эцэг эхчүүд нь хариуцдаг жишиг тогтжээ.

Манай улсын СӨБ-ын хувьд нийгмийн халамжийн бусад бодлогын нэгэн адил томоохон төсөвтэй, хавтгайруулсан дэмжлэгийг үзүүлдэг тогтолцоо болж хувирсан байна. Гэтэл сургалт болон хоолны чанарын хувьд эцэг эхчүүдийн шаардлагыг хангаж байна уу гэвэл үгүй юм. Хоолны чанар, илчлэг зэрэг нь олонхи хүмүүсийн шаардлагыг хангадаггүй, эцэг эхчүүдээс биет болон мөнгөн хэлбэрээр нэмэгдэл хоол авдаг туршлага газар сайгүй байна. Тэгэхээр хязгаарлагдмал төсвийг бүх хүүхдэд хангалтгүй хэмжээний хоолыг үнэгүй өгөхөд зарцуулснаас зорилтот бүлгийн хүүхдэд хангалттай хоол үнэгүй өгч, харин өөрсдөө хоолны мөнгөө төлөх чадвартай иргэд нь энэ хариуцлагаа үүрээд явах нь оновчтой санагдана.

Дараагийн нэг бэрхшээлтэй асуудал бол боловсролын салбарт зарцуулагдаж буй хөрөнгө нь ямар үр дүн өгч байгааг тодорхойлж, хэмжин, хяналт мониторинг хийж байгаа байдал ихээхэн сул байна. Өмнө нь хэлсэнчлэн, бид энэ салбарт ихээхэн хэмжээний хөрөнгийг зарцуулж байна. Өнөөгийн байдлаар боловсролын суурь үзүүлэлтүүд болох бүх шатны боловсролд хамрагдсан байдал, анги дэвшилт, цаашилбал бичиг үсэг тайлагдсан байдал, суурь мэдлэгийн түвшин зэрэг үзүүлэлтүүдийг хамгийн ихдээ жилдээ нэг удаа авч байгаа нь хангалтгүй юм. Энэ нь шийдвэр гаргахад шаардагдах мэдээлэл дутагдалтай байгааг илтгэнэ. Цаашилбал, анги дүүргэлт, нэг хүүхдэд ногдож буй бодит зардал зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдийг тооцох боломж муу байна. Өнөөгийн байдлаар боловсролын санхүүжилтийг хоёр хэсэгт хувааж, тогтмол зардлыг бүрэн санхүүжүүлж, хувьсах зардлыг нэг хүүхдэд ногдох нормативын дагуу олгож байгаа нь захиргааны хувьд тооцоход хялбар, зардал чирэгдэл багатай хэдий ч бодит байдал дээр бүс нутаг, хот, аймаг, сумын төв зэргээрээ ялгавартай байдаг сургуулиудын онцлогийг тусгаж чадахгүй байгаа нь учир дутагдалтай юм. Нөгөө талаас, төсвийг нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар сургуулиудад олгодог учир хамран сургалтын түвшинг илүү өндөр болгож тавих, сургууль завсардсан хүүхдийг завсардаагүй байдлаар мэдээлэх сөрөг хөшүүрэг бий болоод байна. Энэ нь хамгийн энгийн суурь үзүүлэлт болох хамран сургалтын жин хэр бодитой вэ гэдэгт эргэлзэх сэтгэгдэл төрүүлж байна. Ялангуяа, шилжих хөдөлгөөнтэй холбоотой тоон мэдээлэл дутуу дулимаг гардаг нь тодорхой юм.

Боловсролын салбарын чухал үзүүлэлтүүдийг цуглуулдаггүй, эсвэл тэдгээр нь бүрэн бус байдаг, аль эсвэл ялгаатай эх үүсвэрээс авсан тоо баримт нь хоорондоо зөрчилтэй байдаг гэж АХБ дүгнэсэн байна<sup>26</sup>. Газар зүйн байршил,

26 Asian Development Bank (2009) "RRP on the Proposed Asian Development Fund Grant Mongolia: Education for the Poor—Financial Crisis Response Project", Manila

тархай бутархай байдал үүнд сөргөөр нөлөөлж буй хүндрэл байгааг үгүйсгэхгүй хэдий ч ихээхэн хэмжээний хөрөнгийг зарцуулж буй энэхүү салбарын бодит гүйцэтгэл ямар байгаа талаар хомс ойлголттой байгаа нь энэ салбарын эдийн засгийн үр ашгийг сайжруулах, Засгийн газар зорилгодоо хүрч буй эсэхийг тодорхойгүй байдалд хүргэж байна.

Салбарын гүйцэтгэлийн талаар мэдээлэл хомс байдаг нь санхүүжилт авч буй боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг хянах, бүтээгдэхүүнд суурилсан төсөвлөлтийг хэрэгжүүлэх Засгийн газрын зорилтод саад учруулж байна. Гүйцэтгэлийн талаарх тоо баримтыг цаг хугацаанд нь цуглуулах, хянах, өөрчлөлтөнд дүн шинжилгээ хийх нь боловсролын салбарын төлөвлөлт, санхүүжилт, менежментийн чухал хэсэг болох учиртай. Боловсролын талаарх тоо баримтыг сурагчийн түвшинд цуглуулах нь хөдөө орон нутгаас шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсэн энэ нөхцөл байдалд төсвийн бодит зарцуулалтыг тооцох, үр ашиггүй байдлыг багасгахад нөлөө үзүүлнэ. Боловсролын үр ашгийг сайжруулахтай холбоотой төлөвлөлт болон менежментийн мэдлэг, туршлага бүх түвшиндээ дутагдалтай байна гэдэг нь харагдаж байна. Энэ бэрхшээлийг даван туулах үүднээс боловсролын статистик, мэдээллийн тогтолцоог сайжруулах арга хэмжээ авч эхлээд байгаа нь дунд хугацаандаа эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

## 5.2. Эрүүл мэндийн салбар

Санхүү, эдийн засгийн өнөөгийн хямрал манай улсын эрүүл мэндийн салбарт үндсэндээ гурван сувгаар дамжин нөлөөлж байна. *Нэгдүгээрт*, өрхийн түвшинд орлогын эх үүсвэр хумигдаж байгаа тул эрүүл мэндийн үйлчилгээ авах эрэлт хэрэгцээ буурсан байж болох юм. Ялангуяа, эмчлүүлэгчээс төрөл бүрийн нэмэлт төлбөрүүд ихээр шаардагддаг учраас эдгээр хүмүүс эмчилгээгээ хойшлуулах арга хэмжээ авч эхэлсэн байж магадгүй юм. Харамсалтай нь эрүүл мэндийн үйлчилгээний эрэлт чухам хэдэн хувиар буурсан талаарх тоо баримт маш хомс байна. Ер нь бол эрүүл мэндийн үйлчилгээ өөрөө үнийн мэдрэмж муутай байдаг. Тухайлбал, хичнээн үнэ өссөн ч гэсэн тухайн хүн эрүүл явах нь чухал учраас үйлчлүүлэх л ёстой. Эндээс дүгнэхэд дээрх суваг манай орны хувьд нэг их нөлөөлөл үзүүлээгүй гэж таамаглаж байна.

*Хоёрдугаарт*, хүмүүс болоод төрийн бус байгууллагуудын эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа бэлэн мөнгөөр төлж байгаа төлбөр багассанаар эрүүл мэндийн салбарын орлогын эх үүсвэр буурч байна. Энэ тал дээр Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Эрүүл мэндийн яамнаас гаргадаг зарцуулалтын талаарх тоо баримт харилцан адилгүй, их зөрүүтэй байгаа нь энэ сувгийн нөлөөлөх нөлөөллийг тооцоход хүндрэл учруулж байна. ЭМЯ-ны мэдээлж байгаагаар ийм төлбөрийн хэмжээ 2007 оны байдлаар маш бага буюу 4.5 тэрбум төгрөг гэсэн байхад Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 68.4 тэрбум төгрөг гэж үнэлсэн байх жишээтэй.

*Гуравдугаарт*, эрүүл мэндийн салбарын санхүүгийн эх үүсвэр буурах тохиолдолд энэ салбарт сөргөөр нөлөөлж болно. Манай орны эрүүл мэндийн салбарын хувьд жил ирэх тусам Засгийн газрын шууд зарлагаар ихээхэн хэмжээгээр санхүүжигдэж байгаа учраас энэ суваг шийдвэрлэх нөлөөллийг үзүүлж байна гэж үзлээ. Ер нь бол эрүүл мэндийн салбарын санхүүгийн эх үүсвэр үндсэн гурван гол эх үүсвэрээс бүрдэж байна. Эдгээр нь (i) эрүүл


мэндийн даатгалаас орж ирэх санхүүжилт, (ii) Засгийн газраас энэ салбарт зарцуулах хөрөнгийн эх үүсвэр болон (iii) хувь хүмүүсийн төлж буй төлбөр. Ер нь дэлхийн аль ч орны эрүүл мэндийн салбар ийм үндсэн гурван төрлийн санхүүгийн эх үүсвэртэй. Харин улс орнууд чухам аль эх үүсвэрийг нь түлхүү ашигладаг нь харилцан адилгүй байдаг. Зарим орнууд даатгалын систем дээрээ илүү түшиглэсэн байхад, зарим орнуудын хувьд Засгийн газрын санхүүжилт гол үүрэг гүйцэтгэдэг. Манай орны хувьд энэ тал дээр нэгдмэл ойлголт үгүйлэгдэж байгаа. 1994 онд анх Нийгмийн даатгалын хууль батлагдахад Эрүүл мэндийн даатгал нэг хэсэг нь болж батлагдсан. Анхнаасаа энэхүү эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь манай улсын эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд томоохон үүрэг гүйцэтгэхээр бодож боловсруулагдаж байсан. Харин, 2006 онд эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэж буй үүрэг жил ирэх тутам бүдгэрч байгаа.

Тэгэхээр, гуравдугаар суваг манай орны хувьд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Санхүү, эдийн засгийн хямрал энэ сувгаар дамжин манай орны эрүүл мэндийн салбарт тодорхой сөрөг нөлөөллийг үзүүлж байгаа боловч энэ салбарт бугшмал байдалтай байгаа, зайлшгүй шийдвэрлэх ёстой томоохон асуудлууд давхар хөндөгдөж байна.

Эрүүл мэндийн яамнаас гаргаж буй тоон мэдээн дээр үндэслэн сүүлийн таван жилд эрүүл мэндийн салбарын зарлагыг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр хэрхэн хийгдсэн талаар дараах зураг харуулж байна.

2004-2008 оны хооронд энэ салбарт зарцуулсан зарцуулалт 78 тэрбум төгрөгөөс 213 тэрбум төгрөг болтлоо бараг гурав дахин өсчээ. Үүнд, Засгийн газраас эрүүл мэндийн салбарт зарцуулж буй зардал 50 тэрбум төгрөгөөс 160 тэрбум төгрөг болж өссөн нь үндсэндээ нөлөөлсөн. 2008 оны эцсийн байдлаар эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө ДНБ-ий 3.4 хувьтай

Зураг 5.1. Эрүүл мэндийн зарцуулалт, эх үүсвэрээр



Эх сурвалж: Эрүүл мэндийн яам

тэнцүү байгаа нь ижил төстэй орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм. (Дэлхийн Банк, 2009). Энэ хугацаанд эрүүл мэндийн салбарын жил болгоны бодит өсөлт 12.7 хувьтай, сүүлийн хоёр жилд тус бүр 38, 25 хувийн огцом өсөлттэй байжээ.

Дээр дурьдсан тоо баримт бол ЭМЯ-аас гаргасан албан ёсны мэдээ. Гэтэл Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага арай өөр тоо баримт дэлгэж байна. Тухайлбал, эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө дунджаар ДНБ-ий 6.5 хувьтай тэнцүү гэжээ. Энэхүү зөрүүний гол шалтгаан нь ЭМЯ-аас гаргаж буй тоо хүмүүсийн хэтэвчнээсээ бэлнээр төлж байгаа төлбөрийг хэт доогуур үнэлж байгаад оршиж байна.

Засгийн газраас эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна гэж дээр дурьдсан. 2005 онд Засгийн газрын эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгө нийт эрүүл мэндийн зарлагын 69 хувьтай тэнцүү байсан бол 2008 он гэхэд 79.6 хувь болж өссөн. Өөрөөр хэлбэл, үүнээс өмнөх онуудад эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийгдэж байсан зарцуулалт харьцангуй өндөр байсан бол сүүлийн жилүүдэд энэ дүр зураг огцом өөрчлөгдсөн. Учир нь, 2006 онд Эрүүл мэндийн даатгалын болоод Эрүүл мэндийн хуулиудад нэмэлт өөрчлөлт хийж эрүүл мэндийн даатгалын энэ салбарт гүйцэтгэх үүргийг хязгаарлагдмал болгосон. Өөрөөр хэлбэл, энэ тодотголоор эрүүл мэндийн байгууллагуудын бараг бүх зардлыг Засгийн газрын зарлагаар санхүүжүүлэхээр зааж өгсөн.

Энэхүү бодлогын шийдэл нь эрүүл мэндийн санхүүжилтэд гарсан маш том өөрчлөлт юм. Энэ өөрчлөлтийн гол агуулга нь эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нь нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэхэд оршсон. Эрүүл мэндийн даатгал бүх нийтийг хамарсан даатгал биш тул анхан шатны эмнэлгийн үйлчилгээг хүмүүст ойртуулах зорилгоор төрөөс эдгээр байгууллагуудын зардлыг даахаар зааж өгсөн. Хэдийгээр энэхүү алхам зөв зүйтэй боловч эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэх үүргийг маш их хязгаарлаж тухайн салбарыг засгийн газрын төсвөөс хэт хараат болгосон гэдэг нь тодорхой байна.

Одоогийн байдлаар эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд болох өрхийн, сумын болон сум дундын эмнэлгүүдийн санхүүжилтийг төрөөс хийж байгаа бөгөөд энэ зардал эрүүл мэндийн салбарын нийт төсвийн 24 хувийг эзэлж байна. Зөвхөн 2008 онд анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээнд Засгийн газраас 51 тэрбум төгрөг зарцуулж байгаа нь өмнөх оноос даруй 16.3 тэрбум төгрөгөөр илүү байна. Цаашид ч энэхүү төрлийн санхүүжилт нэмэгдэх төлөвтэй байгаа. Хэдийгээр анхан шатны эмнэлгийн үйлчилгээний санхүүжилт өсч байгаа нь сайшаалтай ч эдгээр байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний чанар хангалттай сайжрахгүй байна. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын тоо харьцангуй тогтвортой байсан бөгөөд 2008 оны эцсийн байдлаар 286 сумын эмнэлэг, 35 сум дундын эмнэлэг, 228 өрхийн эмнэлэг, нийтдээ 579 анхан шатны эмнэлгийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн хоёрдогч болоод гуравдагч шатны эмнэлгийн байгууллагуудад зарцуулж буй хөрөнгө нийт эрүүл мэндийн зарлагын 50.5 хувьтай тэнцүү байна. Дээр дурьдсанчлан эрүүл мэндийн даатгалаас эдгээр байгууллагууд хэсэг санхүүжилтээ авдаг. Монгол Улс маш өргөн хүрээний эмнэлгүүдийн сүлжээг өмнөх нийгмийн тогтолцооноос өвлөн авсан.



Ер нь эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх нь хоёрдогч болоод гуравдагч шатны нарийн мэргэжлийн үйлчилгээнээс зарлага багатай тул анхан шатны эмнэлгүүдийн гүйцэтгэх үүргийг өсгөх нь нийт эрүүл мэндийн салбарын үр ашгийг дээшлүүлэхэд сайнаар нөлөөлнө. Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа хоёрдогч ба түүнээс дээших шатны эмнэлгийн байгууллагууд хуучин нийгмийн тогтолцооны үед байгуулагдсан учраас техник технологи нь хоцрогдмол, үзүүлж буй үйлчилгээний чанар нь муу байгаа. Харин, өрхийн эмнэлгүүд бол харьцангуй сүүлд 1998-2002 онд байгуулагдсан. Тийм ч учраас хүмүүс өрхийн эмнэлэг гэхээсээ илүү хоёрдогч ба түүнээс дээд шатны эмнэлэгт үзүүлэх сонирхолтой байдаг. Дэлхийн Банкны (2009) тооцоогоор 2008 оны байдлаар манай орны 100,000 хүнд ногдох эмнэлгийн ор 18,000, эмчийн тоо 7,500 байгаа нь ижил түвшний орлоготой орнуудтай харьцуулахад маш их байгаа нь тогтоогдсон. Ер нь эмнэлгүүдийн үйл ажиллагаа зарлага өндөртэй, үр ашиг багатай гэдэг нь тогтоогдсон учраас олон улсын байгууллагууд эдгээр эмнэлгүүдийн үйл ажиллагааг харилцан уялдуулж шаардлагагүй гэж үзсэн эмнэлгүүдийг хаах, гарцаагүй байх ёстой эмнэлгүүдэд үзүүлж буй үйлчилгээний чанар чансааг сайжруулах талаар нэгдсэн бодлого дутагдаж байна гэж Дэлхийн Банк анхааруулсан байна.

Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хөрөнгийн хэмжээ манай улсын хувьд харьцангуй өндөр болох нь харагдаж байна. Тэгвэл чанартай эрүүл мэндийн үйлчилгээ энэ салбараас авч байна уу гэвэл хараахан үгүй. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг бүх түвшний эмнэлгүүдэд их, бага хэмжээгээр үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах шаардлага тавигдсаар байна. Өрхийн эмнэлгүүд харьцангуй шинээр байгуулагдсан тул хүмүүс үйлчлүүлж тэр бүр заншаагүй, үйлчлүүлж занштал хугацаа хэрэгтэй байх. Харин, одоогийн байдлаар хүмүүс ихэвчлэн нарийн мэргэжлийн эмнэлгүүдээр үйлчлүүлэх сонирхолтой. Гэтэл эдгээр эмнэлгүүдийг цаашид ажиллуулахад зардал өндөртэй, үр ашиг муутай. Тийм ч учраас нэг талаас өрхийн эмнэлгүүдийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, нөгөө талаас хоёрдагч болоод түүнээс дээд шатны эмнэлгүүдийн үйл ажиллаганы үр ашгийг дээшлүүлэх нь манай орны эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал болоод байна. Өөрөөр хэлбэл, одоогийн байгаа тогтолцоо нь үргүй зардал маш их гаргаж байна гэсэн үг.

Энэ салбарт үүсээд байгаа өөр нэг тулгамдсан асуудал бол эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэх үүрэг жил ирэх тусам бүдгэрч байгаад оршиж байна. Шулуухан хэлэхэд яг өнөөгийн байдлаар эрүүл мэндийн даатгал хэрэгтэй эсэх нь асуудалтай байна. Олон хүмүүс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж байгаа. Гэтэл эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авч байгаа эмчилгээнүүд нь маш нарийн эмчилгээнүүд байгаа учраас даатгал төлөгчид дийлэнхдээ эрүүл мэндийн даатгалаасаа ашиг тус хүртэхгүй байгаа. Гэтэл даатгал төлдөггүй хүмүүс эдгээр эмчилгээг авах шаардлагатай болсон тохиолдолд төрөөс үзүүлж буй хөнгөлөлтөөр даатгалд хамрагдаж эмчилгээ хийлгэдэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр дийлэнх эрүүл мэндийн даатгал төлөгчид даатгалд тэр бүр хамрагддаггүй эсвэл хөнгөлөлттэй хамрагддаг хүмүүсийн эмчилгээний зардлыг даадаг гэсэн үг. Харин, өөрсдөө эрүүл мэндийн даатгалынхаа ашиг тусыг тэр бүр хүртдэггүй. Тэгэхээр эдгээр даатгал төлөгчид цаашид эрүүл мэндийн даатгалд хамрагдах сонирхолгүй болж байна. Цаашилбал, ихэвчлэн албан секторт ажиллагчид л эрүүл мэндийн даатгал төлж байгаа нь эдгээр хүмүүст илүү дарамт ирж байна. Тийм учраас, нэг бол эрүүл мэндийн даатгалд бүх хүнийг хамруулж даатгалаас санхүүждэг эмчилгээний хүрээг өргөтгөх эсвэл эрүүл мэндийн даатгалыг үгүй хийж төрөөс санхүүжүүлдэг байх зэрэг бодлогын шийдэл хэрэгтэй байна.

## 6. Эдийн засгийн хямралын өрхөд үзүүлж буй нөлөө

Тайлангийн энэ хэсэгт бид нийслэлийн зарим өрхүүдэд эдийн засгийн хямрал хэрхэн нөлөөлж байгаа талаар судлахыг эрмэлзлээ. Ингэхдээ эдгээр өрхүүдийн сарын орлого болон зарлага нь хэмжээ болон бүтцийн хувьд хэрхэн өөрчлөгдөж байгаа, өрхийн хэрэглээнд чухам ямар өөрчлөлт гарсан, өрхийн ажил эрхэлдэг хүмүүсийн тоо өөрчлөгдсөн эсэх, өрхийн авдаг нийгмийн халамжийн шилжүүлгүүд өрхийн орлогод ямар нэмэртэй байгаа талаар тоон мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхийг зорилоо.


Хямрал эхлэхээс өмнөх буюу 2008 оны үзүүлэлтүүдийг голчлон ҮСХ-оос 2007 оны 7 дугаар 1-нээс эхлэн улсын хэмжээний нийт 11,232 өрхөөс цуглуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны” тоон мэдээллээс иш татан авсан бол хямралын үеийн өрхийн түвшин дэх мэдээллийг Улаанбаатар хотын гурван шатат санамсаргүй түүвэрлэлтээр сонгосон 400 өрхөөс авсан тоо баримтад тулгуурлан хийсэн юм. Тиймээс энэ судалгааны дүгнэлт нь хямрал Монгол улсын нийт өрхийн орлого, зарлага болон хэрэглээнд нийтэд нь яаж нөлөөлсөн талаар бус, зөвхөн эхний есөн сарын байдлаар улсын хүн амын тал хувь нь амьдардаг нийслэл хотын 400 өрхийн хувьд авч үзэхэд ямар өөрчлөлт гарсан талаарх дүгнэлт болно гэдгийг анхаарна уу.

### 6.1. Өрхийн орлого

Юуны өмнө бид тухайн жилийн инфляцийн түвшинг тооцохгүйгээр Монгол Улсын дундаж өрхийн сарын нийт орлого ба зарлага нийтдээ хэдэн төгрөг байдаг вэ? гэсэн асуултаар эхэлье. ҮСХ-оос гаргасан мэдээгээр дундаж өрхийн нийт орлого нь 2005 онд 172,017 төгрөг, 2006 онд 200,179 төгрөг, 2007 онд 263,681 төгрөг, 2008 онд 363,594 төгрөг байсан байна. Өрхийн нийт зарлага нь нийт орлогоосоо тогтмол илүү байгаа нь Зураг 6.1-ээс харагдаж байна. Энэ нь өрхүүд мөнгөн орлогоо дутуу мэдээлдэг эсвэл зээлээр хэрэглэдэг гэсэн санааг юуны түрүүнд төрүүлж байна.

2008 онд хот суурин газарт орших өрхийн сарын дундаж орлого 406,667 төгрөг, хөдөө орон нутагт амьдардаг өрхийнх 305,216 төгрөг буюу хотынхоос 25 хувиар доогуур байжээ. Өрхийн орлогын бүтцийн хувьд 2008 онд өрхийн нийт орлогын 43.7 хувийг цалин, 16.8 хувийг тэтгэвэр болон тэтгэмж, 21.6 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 7.3 хувийг бусад орлого бүрдүүлж байна. Үлдсэн хэсэг нь өрхийн мөнгөн бус биет хэлбэрээр олдог

Зураг 6.1. Өрхийн дундаж мөнгөн орлого, зарлага (мянган төгрөг)



Эх сурвалж: ҮСХ. 2008 оны Статистикийн эмхтгэл, Бүлэг 18

орлого эзэлдэг юм. Цалингийн орлого хотын өрхийн нийт орлогын 55.7 хувь, хөдөөгийн өрхийн хувьд 22.7 хувийг бүрдүүлдэг байна. Хөдөөд өрхийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого нийт мөнгөн орлогын 32 хувийг бүрдүүлдэг бол хотод энэ нь 16 хувьтай байна. Ийнхүү хот, хөдөөгийн өрхүүдийн орлогын бүтэц ялгаатай байна.

Тэгвэл эдийн засгийн хүндрэл бэрхшээлүүд өрхийн орлогод хэрхэн нөлөөлөв гэдэг асуудал бидний сонирхлыг татаж байна. Хөдөөгийн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого ихээхэн багассан байж болзошгүй байна. Жишээ нь, сүүлийн нэг жилд малчин өрхийн мөнгөн орлогын гол эх үүсвэрийн нэг болох ноолуурын үнэ өсөөгүй, нэг жилийн өмнө нийслэлд нэг эр хонь дунджаар 77 мянга, хонины нэхий 2,500 төгрөгийн үнэтэй байсан бол өнөөдөр нэг эр хонь 60 мянга, хонины нэхий 500 төгрөгөөр борлогдож байна. Ийнхүү, малчин өрхийн хувьд орлого нь буурч байгаа нь илт харагдаж байна. Дэлхийн Банкны суурин төлөөлөгч А.Сайед Монголын эдийн засаг бол улирлын чанартай эдийн засаг тул хөдөөгийнхний хувьд хямралын гол нөлөө 2009 оны дөрөвдүгээр улиралд буюу ирэх өвөл илүү хурцаар илэрнэ гэж үзэж байна.

Хотын өрхийн орлогод хямрал хэрхэн нөлөөлөв гэдэг асуудал байна. Харамсалтай нь хотын өрхийн орлогын тоо мэдээ ҮСХ-оос 9 дүгээр сарын байдлаар гардаггүй тул бид хотын өрхүүдэд тандалт хийсэн юм. Манай судалгааны баг 2009 оны 10 дугаар сард Улаанбаатар хотын 132 хорооноос эхний шатанд 40 хороог санамсаргүй сонгон, хоёрдугаар шатанд сонгогдсон хороо тус бүрээс 25 өрхийг санамсаргүй сонгосон. Ийнхүү сонгосон 1000 өрхөөс гуравдугаар шатанд 400 өрхийг санамсаргүй түүвэрлэлтээр сонгон асуулгын хэлбэрээр судалгаагаа авлаа.

Улсын хэмжээний нийт 11,232 өрхөөс цуглуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны” үр дүнгээс харахад улсын хэмжээнд дундаж өрхийн хэмжээ 3.9 ам бүлтэй, өрхийн тэргүүний дундаж нас 44.9 бөгөөд тэдний 78 хувь нь эрэгтэй, үлдсэн 22 хувийг эмэгтэй өрх толгойлогчид бүрдүүлж байгаа нь манай түүврийн үзүүлэлттэй ойр байна.<sup>27</sup>

27 Нийслэл хотын 6 дүүрэгт оршин суух эдгээр 400 өрхийн тэргүүлэгчдийн нас дунджаар 44 настай бөгөөд тэдний 87 хувь нь эрэгтэй, үлдсэн 13 хувийг эмэгтэй өрх толгойлогчид бүрдүүлж байна. Өрхийн тэргүүлэгчдийн 40 хувь их дээд боловсролтой, 46 хувь нь бүрэн дунд болон техник мэргэжлийн боловсролтой бол 14 хувь нь бага болон бүрэн дунд боловсролтой байна. Эдгээр өрхүүд дунджаар 4 ам бүлтэй байна.

Энэ тандалтын судалгаагаар нийслэл хотод амьдардаг эдгээр 400 өрхийн сарын дундаж мөнгөн орлого 487,460 төгрөг бөгөөд өрхийн нэг хүнд ноогдох орлого 130,127 төгрөг байна.<sup>28</sup> Энэ нь 2008 онд хот суурин газарт орших өрхийн сарын дундаж орлого болох 406,667 төгрөгөөс 20 хувиар илүү байгаа нь харагдаж байна.<sup>29</sup> Тандалтын судалгааны дүнг улсын хэмжээний хот сууриан газрын өрхүүдтэй шууд харьцуулалт хийх боломж байхгүй юм. Түүврийн орлогын түвшин ийнхүү харьцангуй өндөр байгаа нь түүвэр зөвхөн Улаанбаатар хотод хийгдсэн, түүврийн хэмжээ бага байгаагаас шалтгаалсан гэж үзэх үндэстэй.

Эрэгтэй өрхийн тэргүүнтэй айлын сарын дундаж орлого 677 мянган төгрөг байхад эмэгтэй өрхийн тэргүүнтэй айлынх 318 мянган төгрөг байгаа нь “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны” үр дүнтэй дүйцэж байна. Эдгээр өрхийн сарын дундаж орлого 487 мянган төгрөг байгаа бөгөөд орлогын түвшнээр нь тав ангилахад орлогын доод арван хувьд байгаа дундаж өрхийн хувьд сарын орлого нь 180 мянган төгрөг байхад медиан буюу голч өрхийн сарын орлого 400 мянга, хамгийн дээд орлоготой хэсгийнх сарын 812 мянган төгрөг байна. Бидний энэ хэсэгт тайлбарлаж, харьцуулж байгаа үзүүлэлтүүд бол дундаж орлоготой өрхийн хувьд яригдаж байна.

#### Хүснэгт 6.1 Тандалтын судалгаанд хамрагдсан өрхийн сарын орлогын шатлал

Хувь (Percentile)	Харгалзах дундаж өрхийн орлого (Centile)	95 хувийн итгэх завсар
10	180,000 төгрөг	150,000 200,000
25	250,000 төгрөг	230,000 281,000
50	400,000 төгрөг	353,000 400,000
75	600,000 төгрөг	528,174 600,000
90	811,600 төгрөг	705,705 920,955


Эх сурвалж: ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар

Өрхүүдийн сарын мөнгөн орлогын бүтцийг Зураг 6.2-т харууллаа. Өрх бүр доор дурьдсан дөрвөн төрлийн орлогын эх үүсвэртэй биш боловч дунджаар эдгээр өрхийн нийт мөнгөн орлогын 68 хувь нь цалингаас, 9 хувь нь тэтгэвэр тэтгэмжээс, 20 хувь нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос буюу хувиараа хөдөлмөр эрхэлсний орлогоос, 3 хувь нь бэлэг, мөнгөн тусламж, гуйвуулга, түрээсийн орлого, хүүгийн орлого, өмч худалдсанаас зэрэг бусад мөнгөн орлогоос орж ирсэн байна. Түүвэрт хамрагдсан 400 өрхийн орлогын эх үүсвэрийг 2008 оны хот суурин газрын дундаж өрхийн мөнгөн орлогын бүтэцтэй харьцуулсан байна. Хэдийгээр энэ хоёр үзүүлэлтийг түүвэрлэлтийн хувьд харьцуулах боломжгүй боловч Улаанбаатар хотын эдгээр 400 өрхийн дундаж мөнгөн орлого хэмжээний хувьд буураагүйгээс гадна бүтцийн хувьд өөр байгаа нь харагдаж байна.

28 Стандарт хазайлт нь 138,447 төгрөг бөгөөд хамгийн багадаа 12,500, хамгийн ихдээ 1,428,571 төгрөг байна.

29 Хот суурин газарт нийслэл хот болон Дархан-Уул, Орхон аймгийн төвүүд орсон байхад манай түүвэр судалгаа зөвхөн нийслэл хотын 40 өрхөд явагдсан болно.

Зураг 6.2. Тандалтын судалгаанд хамрагдсан 400 өрхийн болон 2008 оны улсын хэмжээнд хотын дундаж өрхийн<sup>30</sup> мөнгөн орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар, ҮСХ-ны 2008 оны эмхтгэл. Бүлэг 18.

Түүвэрт багтсан 400 өрхийн хувьд 2009 оны 9 дүгээр сарын байдлаар сарын нийт мөнгөн орлогын цалин, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогоос орж ирдэг хувь өнгөрсөн оны улсын дунджаас илүү байгаа бөгөөд бусад төрлийн орлогоос олох хувь бага байгаа дүр зураг харагдаж байна. Түүвэрлэлтийн хэмжээнээс хамааран бид Улаанбаатар хотын дундаж өрхийн хувьд орлогын аливаа нэг эх үүсвэр өөрчлөгдсөн талаар шууд дүгнэлт хийх боломжгүй боловч эдгээр 400 өрхийн хувьд 2009 он гараад эхний гурван улирлын турш өрхийн сарын дундаж орлого, түүн дотроо цалингийн орлого буураагүй байна гэдгийг хэлэх боломжтой юм.

Улаанбаатар хотын хувьд хийсэн бага хэмжээний тандах судалгааны үр дүн ийм гарч байгаа бол улсын хэмжээнд өрхүүдийн орлого хэрхэн өөрчлөгдөж байна гэдгийг харах нь чухал. Харамсалтай нь ҮСХ-ноос гаргаж байгаа “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны” тоон мэдээлэл 2010 оны 8 дугаар сард нийтэд хүртээмжтэй болох тул бидэнд нийт улсын хэмжээний хувьд дүгнэлт хийхэд хүндрэлтэй байна. Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх группээс 2009 оны 3 дугаар сард Улаанбаатар хот, Орхон, Завхан, Баянхонгор, Сүхбаатар, Дундговь аймгуудийн 2,382 иргэдээс санал асуулгаар авсан судалгаагаар хямрал хэрхэн нөлөөж байна гэсэн асуултанд 28 хувь нь орлого буурсан гэж хариулсан байна<sup>31</sup>. Гэхдээ уг судалгаа нь түүврийн хувьд улсын хэмжээн дэх нийт өрхийг төлөөлж чадах нь эргэлзээтэй бөгөөд хугацааны хувьд хямрал дөнгөж эхэлж байх үед хийгдсэн учир эндээс бид тодорхой дүгнэлт хийх боломжгүй юм.

2009 оны гуравдугаар улирлын хувьд өмнөх оны мөн үетэй харцуулахад хүмүүсийн бодит орлого нэмэгдсэн. Учир нь 2009 оны 9 сард ҮСХ-оос гаргасан мэдээгээр инфляцийн түвшин 0.9 хувь болж эрс буурсан байна. Энэ нь нийт

30 Энд нийслэл хот болон Дархан Уул, Орхон аймгийн төвүүд орсон болно.

31 Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх групп (2009). “Монгол дахь эдийн засгийн хямрал, түүнийг зөөлрүүлэх арга зам” www.mmcsг.mn


өрх гэрийн бодит орлого буюу байгаа нэрлэсэн нийт мөнгөн орлогынхоо хэмжээнд худалдан авч чадах бараа, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдсэн болохыг харуулж байна. Тухайлбал, өмнөх оны мөн үетэй харцуулахад 1кг дээд гурилын үнэ 8 хувиар, нэгдүгээр зэргийн гурил 14 хувиар, нэг ширхэг талхны үнэ 7 хувиар, 1кг хонины махны үнэ 25 хувиар, үхрийн махных 20 хувиар, түлшний мод, нүүрсний үнэ 25 хувиар тус тус буурч харин цэвэр бохир ус, хогны үйлчилгээ, халаалт, цахилгааны үнэ хэвээрээ байна. Тэгэхээр ажлаа алдаагүй эсвэл тэтгэвэр тэтгэмжээр голдуу амьдардаг өрхийн хувьд нэрлэсэн орлого нь буурахгүй бөгөөд үнийн түвшин тогтвортой үед бодит орлого өөрчлөгдөхгүй, худалдан авч буй барааны сагснаас шалтгаалан өсч болох юм. Харин энэ хугацаанд ажилгүй болсон эсвэл албан бус байдлаар хөдөлмөр эрхэлдэг иргэдийн нэрлэсэн орлого нь буурсан байх магадлалтай, харин бодит орлого нь нэрлэсэн орлогоос багаар буурсан байх юм.

## 6.2. Өрхийн зарлага

ҮСХ-ноос гаргасан мэдээгээр Монгол Улсын дундаж өрхийн сарын нийт мөнгөн зарлага 2005 онд 172,855 төгрөг, 2006 онд 201,470 төгрөг, 2007 онд 267,988 төгрөг, 2008 онд 329,142 төгрөг байсан байна. Дундаж өрхийн сарын хэрэглээний бүтцийг үзэхэд хүнсний бус бараа, үйлчилгээнд илүү ихийг зарцуулдаг нь Зураг 6.3-аас харагдаж байна. Энэ нь голчлон хувцас, орон сууцны төлбөр, түлш, утас, тээврийн зардал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний зардал юм. 2008 онд хот суурин газарт орших өрхийн дундаж зарлага 410,134 төгрөг байсан бол хөдөө орон нутагт амьдардаг өрхийн дундаж зарлага түүнээс бараг хоёр дахин бага буюу 219,361 байна. Гэхдээ хөдөө орон нутагт амьдардаг өрхийн хувийн аж ахуйгаасаа авч хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн нь мөнгөн дүнгээр илэрхийлбэл нэг сард 63 мянган төгрөг байхад хотын өрхийн хувьд энэ нь 2,000 төгрөг байна.

2009 он гараад өрхийн зарлагад ямар өөрчлөлт гарсан талаар хийсэн дорвитой судалгаа мөн алга байна. Дээр дурьдсан Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх группээс 2009 оны 3 дугаар сард Улаанбаатар хот болон 5 аймгийн 2,382 иргэдээс авсан мэдээгээр хямралын улмаас тэдний 19 хувь

Зураг 6.3. Дундаж өрхийн мөнгөн зарлагын бүтэц, улсын хэмжээнд, төгрөгөөр



Эх сурвалж: ҮСХ. 2008 оны эмхтгэл. Бүлэг 18.




нь мөнгө илүүчилж хадгаламж хийж чадахаа больсон, 14 хувь нь хувцас хунар худалдаж авахаа больсон, 12 хувь нь хоол хүнсэнд зарцуулдаг зардал буурсан, 10 хувь нь авсан зээлээ төлж чадахаа байсан хэмээн хариулсан байна. Улаанбаатар болон баруун, зүүн, хангай, төвийн бүсийг төлөөлөн авсан эдгээр аймгуудын иргэдийн хувьд өрхийн зарлага ерөнхийдөө буурсан, тэр дундаа хадгаламж хийх, зээлээ эргүүлж төлөх явдал багасч хүнсний болон хүнсний бус хэрэглээ буурсан нь харагдаж байна.<sup>32</sup> Тухайлбал, 2009 оны 9 дүгээр сард гаргасан ХААН банкны мэдээгээр хөдөөгийн малчдад олгосон зээлийн эргэн төлөлт буурсан тул 2009 оны эхний зургаан сард гэхэд 2,760 орчим малчин өрхийн зээлийн хугацааг сунгасан гэж мэдээлсэн.<sup>33</sup>

2009 оны 10 дугаар сард Улаанбаатар хотын 400 өрхөөс авсан тандалтын судалгаагаар эдгээр өрхийн сарын дундаж мөнгөн зарлага дунджаар 443,724 төгрөг бөгөөд өрхийн нэг гишүүнд нэг сард ногдох зарлага дунджаар 153,727 төгрөг байна. Өрхийн нэг гишүүнд нэг сард ногдох өрхийн орлого 130,127 төгрөг байсан бол өрхийн нэг гишүүнд нэг сард ноогдох зарлага 153,727 төгрөг байгаа нь дээр дурьдсанчлан өрхүүд орлогын хэмжээгээ дутуу мэдээлдэг эсвэл зээлээр хэрэглэдэгтэй холбоотой байж болох талтай. Эдгээр өрхүүдийн хувьд сарын мөнгөн зардал нь 2008 оны улсын нийт хот суурин газарт орших өрхийн сарын дундаж зардал болох 410,134 төгрөгөөс буюу 8 хувиар илүү байна. Судалгаа авсан өрхийн сарын дундаж хэрэглээний бүтцийг үзэхэд хоол хүнсэнд 159 мянган төгрөг, хүнсний бус бараа, үйлчилгээнд 285 мянган төгрөг зарцуулж байгаа нь 2008 оны улсын дундаж түвшнээс тус тус 32 хувь ба 43 хувиар их байна (Зураг 6.3). Энэ өрхүүдийн сарын мөнгөн зарлагын бүтцийг Зураг 6.4-т харууллаа.

Эдгээр өрхийн сарын хэрэглээний бүтцийг үзэхэд нийт мөнгөн орлогынхоо 36 хувийг хоол, хүнсэнд зарцуулдаг бөгөөд 36 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 11 хувийг нь хадгалдаг бөгөөд 17 хувийг бусад зүйлд буюу зээл төлөх, үнэт цаас, хөрөнгө оруулалт хийх гэх мэтэд зарцуулдаг байна (Зураг 6.4). Өөрөөр хэлбэл, эдгээр өрхүүдийн хүсний бус бараа, үйлчилгээний зарцуулалт нь улсын хэмжээний дундаж зарцуулалтаас их байгаа нь харагдаж байна.

Зураг 6.4. Тандалтын судалгаанд хамрагдсан 400 өрхийн мөнгөн зардалын бүтэц, хувиар



Эх сурвалж: ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар

32 Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх групп (2009) "Монгол дахь эдийн засгийн хямрал, түүнийг зөөлрүүлэх арга зам". www.mmcg.mn

33

	Улаанбаатар (2008 он)	Улаанбаатарын 400 өрх (2009 он)
Хүнсний зүйл	41,305	43,084 <sup>34</sup>
Хүнсний бус бараа үйлчилгээ	83,089	110,643


Эх сурвалж: 2008 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар

2008 оны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаагаар” Улаанбаатар хотын өрхүүдийн нэг сард нэг хүнд ногдох зарлагыг хүнсний болон хүнсний бус гол бараа үйлчилгээгээр гаргасныг энэхүү тандалтын судалгааны 400 өрхийн хувьд гарсан тухайн үзүүлэлттэй харьцуулсныг Хүснэгт 6.2-т харууллаа. Эдгээр хоёр түүвэр судалгааг шууд харьцуулахад учир дутгадалтай тул бид өөрсдийн авсан түүвэртээ гол анхаарлаа хандуулж байна.

Санал асуулгаар эдгээр 400 өрхийн хувьд 2008 оны эхний есөн сартай харьцуулахад 2009 онд уг өрхийн хэрэглэдэг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний хэрэглээ ерөнхийдөө хэвийн байсан гэж хариулсан. Түүвэрлэсэн 400 өрхийн 63 хувь нь махны хэрэглээ, 68 хувь нь гурил, 64 хувь нь будааны хэрэглээг хэвэндээ байна гэж үзжээ. Харин элсэн чихэр, жимсний хэрэглээ нь илүү буурсан байна (Зураг 6.5).

Санал асуулгаар бараа үйлчилгээ тус бүрээр асуухад 2008 онтой харьцуулахад эдгээр өрхийн 55 хувь нь боловсролд, 42 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээнд, 43 хувь нь тээвэр, холбоонд, 28 хувь нь хувцсанд зарцуулах зардал өссөн гэж үзэж байна (Зураг 6.6).


Зураг 6.5. Тандалтын судалгаанд хамрагдсан өрхийн хүнсний хэрэглээний өөрчлөлт



Эх сурвалж: ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар

34 Эдгээр 400 өрхийн сард нэг хүнд зарцуулах хүнсний зардал хамгийн багадаа 2,857 төгрөг, хамгийн ихдээ 200,000 төгрөг байна.

Зураг 6.6. Тандалтын судалгаад хамрагдсан өрхийн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын өөрчлөлт



Эх сурвалж: ННФ, ЭЗС-ийн хийсэн тандалтын судалгаа 2009 оны 10 дугаар сар

Тандалтын судалгаанд хамрагдсан эдгээр айл өрхийн хямралын үе дэх хэрэглээ нь хоол хүнсний хувьд буураагүй боловч хүнсний бус бараа үйлчилгээ, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд төлөх зардал өссөн гэж үзэж байгаа өрхүүд олон байна.

### **Ажилгүйдэл, ажил хайлт**

2008 оны байдлаар дундаж өрхийн дундаж орлогын 43.7 хувь нь цалингаас орж ирдэг тул хямрал ажил эрхлэлт, цалингийн түвшинд хэрхэн нөлөөлж байна вэ гэдгийг авч үзье. Нийт улсын хэмжээнд 2009 оны 9 дүгээр сарын байдлаар ажилгүй бөгөөд ажил хайж аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн албанд очиж бүртгүүлсэн хүмүүсийн тоо 2008 оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 27 хувиар өссөн бол хүн амын тал хувь нь амьдардаг нийслэл хотод энэ тоо 43 хувиар өссөн байна.<sup>35</sup> Зөвхөн бүртгүүлсэн ажилгүй хүмүүсийн хэмжээ ингэж өссөн бол цаана нь ажилгүй боловч бүртгүүлээгүй хүмүүс хэд байгаа вэ гэдэг нь гол асуудал билээ. 2009 оны 9 дүгээр сарын байдлаар ажил хайж байгаа нийт 40,354 хүмүүсийн 57 хувь нь эмэгтэйчүүд байна. Энэ нь ажилгүй байгаа эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд өрхийн орлогоо нэмэгдүүлэхийн тулд ерөнхийдээ ялгаагүй ажил хайж байна гэдгийг харуулж байна.

Дээрх хэсгийг уншихад нийт орон даяар ялангуяа нийслэл хотын хэмжээнд ажилгүй хүн их болсон мэт ойлгогдож болох юм. Гэтэл нарийвчлан авч үзвэл тийм биш байна. *Нэгдүгээрт*, ҮСХ-ноос сар болгон гаргадаг мэдээгээр он гараад эхний есөн саруудад Говь-Алтай, Завхан, Дорнод болон Хэнтий аймгуудад бүртгүүлсэн ажилгүй хүмүүсийн тоо өсөөгүй харин буурсан байна. *Хоёрдугаарт*, 2008 оны эхний есөн сарын нийт дүнгээр ажил хайж бүртгүүлсэн хүмүүсээс 33,231 ажилд орж байсан бол 2009 оны 9 дүгээр

35 Энэ нь он гараад аймаг, дүүргүүдийн хөдөлмөр эрхлэх албанд бүртгүүлсэн хүмүүсийн тоо өссөн гэдгийг харуулсан үзүүлэлт юм.

сарын байдлаар нийтдээ 35,553 хүн ажилд орсон байна. Өөрөөр хэлбэл, бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон хэмжээ хямралын өмнөх үетэй харьцуулахад буураагүй, харин бага зэрэг буюу 7 хувиар өссөн байна. *Гуравдугаарт*, нийгмийн даатгал төлдөг хүний тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн байна. Тухайлбал, 2008 оны эхний есөн сарын нийт дүнгээр улсын хэмжээнд нийт 481,740 хүн нийгмийн даатгал төлж байсан бол 2009 оны 9 дүгээр сарын байдлаар 516,313 хүн нийгмийн даатгал төлж байна. Нийгмийн даатгал төлөгсдийн тоо 7 хувиар өссөн байна. Дотор нь ангилбал, хувийн хэвшлийн болон төсвийн байгууллагуудад ажилладаг даатгал төлөгсдийн тоо адилхан 7 хувиар тус тус өссөн байна. Энэ нь хувийн хэвшил ба төсвийн байгууллагууд ажилд шинээр хүмүүс авч байна гэдгийг харуулж байна. Нийгмийн даатгал төлдөг хүний тоо өссөн гэдэг бол ажилд ороод татвар төлж байгаа хүний тоо өсч байгааг харуулсан чухал үзүүлэлт билээ. Энэ нь цаашилбал Монголын хөдөлмөрийн зах зээл шингээх чадвартай байгааг харуулж байна.

Дээр дурьдсан Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх группээс хийсэн түүвэр судалгаанд оролцсон хүмүүс хямралыг даван туулахын тулд 38 хувь нь зардлаа багасгах, 26 хувь нь орлогын нэмэлт эх үүсвэр хайх, 18 хувь нь урьд урьдынхаасаа илүү их хөдөлмөрлөж байна гэж хариулсан байна.<sup>36</sup> Эндээс харахад нийт улсын хэмжээнд хямралын улмаас хот, хөдөөд ялгаагүй хүмүүс илүү ажил хийх хүсэл эрмэлзэлтэй болсон байгаа бөгөөд мөн ажилгүй хүний тоо их болсон гэхээсээ ажилгүй байсан хүмүүс ажил илүү идэвхтэй хайж, ихээр бүртгүүлдэг болсон байж болно.

2009 оны гуравдугаар улирлын хувьд хүмүүсийн ажил эрхлэлт нэмэгдсэн байх талтайг нотлох нэг судалгаа байна. 2009 оны 9 дүгээр сард Дэлхийн Банкнаас Монгол Улсад суугаа суурин төлөөлөгчийн газраас Улаанбаатар хотын албан бус секторт хийсэн түүвэр судалгаагаар энэ салбарт ажиллагсдын тоо буюу Нарантуул зах, Барс хүнсний зах, Зуун айл, Гурвалжингийн гүүр, Ботаникийн цемент буулгаж ачих цэгүүдэд ажиллагсдын тоог 2009 оны 4 дүгээр сартай харьцуулахад 25 хувиар, бодит орлого нь 12 хувиар өссөн гэж тооцсон байна.<sup>37</sup>

Нийслэлийн 400 өрхөөс авсан судалгааны нэг гол асуулт болох 2009 он гарсаар танай өрхийн хэдэн гишүүн ажилгүй болсон бэ? гэсэн асуултанд 80 хувь нь өрхийн гишүүдээс ажилгүй болсон хүн байхгүй гэсэн бол 17 хувь нь өрхийн 1 хүн ажилгүй болсон, 2 хувь нь 2 хүн, 1 хувь нь 3 болон түүнээс дээш хүн ажилгүй болсон гэж хариулсан байна. Он гараад өрхөөс нь ажилгүй болсон хүн байгаа гэж хариулсан 81 өрхийн нийт 96 ажилгүй болсон хүмүүсээс 23 хувь нь дүүргийнхээ Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэст бүртгүүлсэн бол үлдсэн 77 хувь нь бүртгүүлээгүй байна. Өрхийн аль нэг гишүүн нь ажилгүй болсон гэж хариулсан 81 өрхийн 12 хувь нь ажилд орсон, 88 хувь нь ажилд орж чадаагүй байна гэж хариулсан байна.

### ***Гадаадаас ирдэг мөнгөн гуйвуулга***

2008 оны байдлаар дундаж өрхийн орлогын 7.3 хувь нь бусад байдлаар орж ирдэг гэж тооцогдсон байна. Бусад гэдэгт шууд тооцож гаргахад

36 Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх групп. (2009). Монгол дахь эдийн засгийн хямрал, түүнийг зөөлрүүлэх арга зам. [www.mmcg.mn](http://www.mmcg.mn)

37 World Bank "Mongolia Monthly Update", September 2009

түвэгтэй, тогмол биш орлогын төрлүүд ордог. Тухайлбал, гадаад, дотоодоос гуйвуулдаг мөнгөн тусламж энэ бүлэгт орно. Хямралаас өмнө, 2003 онд Монгол Улсын бүх бүс нутгийн бүх аймгуудад болон нийслэл хотод хийгдсэн “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-нд оролцсон 2,454 өрхийн 1,173 өрх гэр буюу 72 хувь нь гадаадаас мөнгөн тусламж, гуйвуулга авсан ба хүлээн авсан гуйвуулгын хэмжээ дунджаар 49,311 төгрөг байсан гэж хариулсан байна.<sup>38</sup> Эдгээр 1,173 өрхийн 32.5 хувь нь нийслэлд, 25.5 хувь нь аймгийн төвд, 26.6 хувь нь сумын төвд, 14.5 хувь хөдөө амьдардаг айлууд байсан. Эндээс гадаадаас ирүүлдэг мөнгөн гуйвуулга хөдөө орон нутагт илүү очдог нь харагдаж байна. ҮСХ-ноос гаргасан “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаан”-ы 2008 оны мэдээгээр улсын хэмжээнд нийт өрхийн 17.7 хувь нь гадаадаас мөнгөн гуйвуулга хүлээн авдаг бөгөөд гуйвуулгын дундаж хэмжээ нь нэг сард дунджаар 42,360 төгрөг гэж тооцоолсон байна.<sup>39</sup>

Хямралын үед өрхийн орлогын энэ гол бүрэлдэхүүн хэсэгт ямар өөрчлөлт орж байгааг авч үзье. 2009 оны 10 дугаар сард Улаанбаатар хотын 400 өрхөөс авсан тандалтын судалгаагаар эдгээр айлуудаас 30 өрх буюу 8 хувь нь гадаадад ажилладаг хүнтэй гэж хариулсан бөгөөд 2009 он гарсаар тэдгээр хүмүүсийн гэртээ илгээдэг мөнгөний хэмжээ өрхийн 58 хувьд өөрчлөгдөөгүй, 14 хувьд ихэссэн, 28 хувьд буурсан байна. Иймд, гадаадаас ирдэг мөнгөн гуйвуулгын хэмжээ болон эзлэх хувь нь ерөнхийдөө буурах хандлагатай байгаа, энэ нь хямралын үед илүү ихээр мэдрэгдэх болсон гэж дүгнэж болох юм.

Өрхийн түвшинд хямралын улмаас гарч буй өөрчлөлтийн талаар тодорхой ойлголттой болох үүднээс хийсэн тандалтын судалгаагаар өрхийн орлого болон зарлага буураагүй, харин өрхийн хэрэглээнд бага зэрэг өөрчлөлт орсон гэж Улаанбаатар хотын 400 өрх үзсэн байна. Ялангуяа ажлын байраа алдаагүй хүмүүсийн хувьд үнэ тогтвортой байгаа, зарим гол нэр төрлийн барааны үнэ буурсны үр дүнд бодит орлого буураагүй, өсөх хандлагатай байна. Харин, хөдөөгийн өрхүүдийн хувьд мөнгөн орлогын гол эх үүсвэр болох хөдөө аж ахуйн түүхий эд, махны үнэ буурсан нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна.

38 ҮСХ (2003) “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-ны тоо баримт

39 ҮСХ. 2009 он. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. [www.worldbank.org.mn](http://www.worldbank.org.mn)

## 7. Дүгнэлт

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад эдийн засгийг дэмжих төсвийн тэлэлтээ хэзээ, хэрхэн яаж зогсоох вэ гэдэг асуудлыг хэлэлцээд эхэлсэн нь хямрал болон түүнтэй холбоотой бодлогын арга хэмжээ дараагийн шатандаа орж буйн нэг дохио юм. Гэхдээ эдийн засгийн өсөлтийн тухай ярих хараахан эрт байгаа бөгөөд дэлхий нийтээр эдийн засаг тодорхой хугацаагаар зогсонги байдалд байх магадлал байна.

Манай эдийн засаг гурван улирал дараалан уналттай байна. Энэ нь үйлдвэрлэл болон гадаад худалдаан дээр тод мэдрэгдэж байна. Гэхдээ Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсантай холбоотой ирэх жилийн өсөлтийн төлөв болон хүлээлт нэлээд өөдрөг байгаа. Энэ улирлын хувьд макро эдийн засгийн бодлогоо сулруулах хандлага илэрч эхэллээ. Энэ нь инфляци доогуур түвшинд тогтворжиж, улмаар Монголбанк бодлогын хүүгээ бууруулж, мөнгөний нийлүүлэлтээ нэмснээр илэрч байна. Гэхдээ өндөр үнэ цэнээр олдсон үнийн тогтворжилтоо мөнгөний бодлогоо хэт эрт зөөлрүүлснээр алдаж болзошгүйг дахин сануулж байна.

Өнөөгийн байдлаар хамгийн их хүндэрсэн салбар бол банк, санхүүгийн салбар юм. Анод банкны явдал өөр банкин дээр давтагдахгүй гэсэн баталгаа алга байна. Тогтолцооны хэмжээгээр ёс суртахууны эрсдэл даамжирсан нь өмнө нь хүндэрсэн олон банкны асуудлыг татвар төлөгчийн хөрөнгөөр шийдэж байсантай холбоотой. Цаашдаа энэ байдлаас гарах гарц нь хадгаламжийн даатгалын тогтолцоог банкны хяналт шалтгалтын тогтолцоотой нь хамт уялдуулан сайжруулах арга гэж үзэж байна.

Төсөвтэй холбоотой эрдэс баялгийн орлогын менежментийн асуудал хурцаар тавигдаж байна. Засгийн газар “Төсвийн тогтворжилтын тухай хууль”-ийг боловсруулж төсвийн шинэчлэлийг хийхээр санаачилж байгаа нь төсөв, сангийн бодлогод орох томоохон өөрчлөлт болох юм. Ингэснээр төсвийн мөчлөг дагасан шинж чанарыг халж, эрсдэлийг багасгах том алхам болох юм. Энэ бодлого хэрэгжсэнээр өндөр өсөлт болон уналтын бүтэн циклээс бидний авсан хамгийн том сургамж болох учиртай. Энэ нь улс төрийн хувьд амаргүй шийдвэр байх нь ойлгомжтой.



Төсөв, сангийн бодлогын мөчлөг дагасан шинж чанарын нэг тод жишээ бол боловсрол болон эрүүл мэндийн салбар юм. Энэ хоёр салбар нь өмнөх тогтолцооноос уламжлагдаж ирсэн нүсэр бүтцэд суурилдагийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд зарлага нь ихээхэн өсч, тэлэлт хийгдсэн байна. Боловсролын салбарын хувьд 11 улмаар 12 жилийн тогтолцоонд шилжсэн, Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн, СӨБ-ын хоолыг үнэгүй даах болсон зэрэг олон арга хэмжээ шинээр авч хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн салбарын хувьд зарлагын ихэнхийг даатгалаас бус харин төсвөөс даах болсон. Ийнхүү төрийн оролцоо улам нэмэгдэж, үр ашиг, эдийн засгийн хөшүүрэг суларсан. Түүгээр ч үл барам, ядуу иргэддээ чиглээгүй, хавтгайруулсан халамжийн шинж чанарыг улам ихээр агуулж, улс төрийн амлалтын талбар болсон байна. Цаашдаа энэ хоёр салбарт зах зээлийн суурь зарчим, хөшүүргийг илүү хүчтэй болгох, төрийн оролцоог багасгах, санхүүжилтийн холимог эх үүсвэрийг ашиглах, даатгал болон хувь хүний хариуцлагыг нэмэгдүүлснээр үр ашгийг сайжруулах шаардлага тулгараад байна.

Санхүү, эдийн засгийн хямралын нөлөөг бид гол төлөв макро эдийн засгийн цөөн үзүүлэлтээр тодорхойлж байгаа нь өрх болон пүүсийн түвшинд үзүүлж буй нөлөөг судалж, холбогдох дүгнэлтийг хийх боломжийг олгохгүй байна. Гол бэрхшээл нь тоон болон чанарын өгөгдөл хомс, цуглуулахад амаргүй, өртөг өндөртэй байдагт оршино. Энэ байдлыг даван туулах зорилгоор Улаанбаатар хотын 400 өрхөд хийсэн тандалтын судлагааны үр дүнд өрхийн орлого, зарлага ерөнхийдөө буураагүй, харин хэрэглээний бүтцэд тодорхой өөрчлөлт орсон нь зарим хүнсний болон боловсрол, эрүүл мэнд зэрэг хүнсний бус хэрэглээ өссөнтэй холбоотой гэсэн дүгнэлтийг хийж байна.

## 8. Ашигласан материал

“Мөнгөний бодлогын хүүтэй холбоотой зарим асуудал”, Монголбанк, 2009.

Монголбанк, 2009. “Анод банкны санхүүгийн байдлын тухайд”

Монголын маркетингийн зөвлөлгөө өгөх групп (2009) “Монгол дахь эдийн засгийн хямрал, түүнийг зөөлрүүлэх арга зам”. [www.mmcg.mn](http://www.mmcg.mn)

Нээлттэй нийгэм форум (2009) “Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй нөлөө”, нэг, хоёрдугаар улирлын тайлангууд

Үндэсний статистикийн хороо, 2008 ба 2009 оны “Статистикийн бюллетень”

Үндэсний статистикийн хороо (2009) “Статистикийн 2008 оны эмхтгэл”

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2009 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын Их Хурал 2008

Asian Development Bank (2009) “RRP on the Proposed Asian Development Fund Grant Mongolia: Education for the Poor—Financial Crisis Response Project”, Manila

Asian Development Bank, 2009. “Private Sector Assessment for Mongolia”, Manila

Jens R. Clausen, 2009. “Calculating Sustainable Non-mineral Balances as Benchmarks for Fiscal Policy: The Case of Botswana”, IMF, WP/08/117

Carter Dougherty, September 30, 2009 “IMF Calls for Overhaul of Financial System”, New York Times

Norbert Fiess. “Chile’s Fiscal Rule”, The World Bank, May 2002

Charles Freedman, Michael Kumhof, Douglas Laxton, and Jaewoo Lee, 2009. “The case for global fiscal stimulus”, IMF, SPN/09/03

IMF, 2009. “First Review under the Stand-By Arrangement”, IMF Country Report No. 09/254

IMF, 2009. “Mongolia: Request for Stand-By Agreement”, March

IMF, 2009. “Review of Recent Crisis Programs”, Strategy, Policy and Review Department

IMF (2009) “World Economic Outlook: Sustaining the Recovery” October


World Bank, 2009. “Battling the Forces of Global Recession”, Economic Update for East Asia and Pacific, April

World Bank (2009) “Consolidating the Gains, Managing Booms and Busts, and Moving to Better Service Delivery— A Public Expenditure and Financial Management Review”. Washington, DC.

World Bank, 2009. “Mongolia Monthly Economic Update”, August and September


## 9. Хавсралт

Хавсралт 9.1. Хотын дундаж өрхийн мөнгөн орлогын бүтэц, 2008 он



Эх сурвалж: ҮСХ. 2008 оны эмхэтгэл. Бүлэг 18.

Хавсралт 9.2. Хөдөөгийн дундаж өрхийн мөнгөн орлогын бүтэц, 2008 он.



Эх сурвалж: ҮСХ. 2008 оны эмхэтгэл. Бүлэг 18.